


# МОНГОЛЫН АНАГААХ УХААН



1/91



**БНМАУ-ЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГАДАР АРДЫН ЭМЧ,  
ГАВЬЯАТ ЗҮТГЭЛТЭН ЦОЛ ХУРТЭГСЭД**

Ардын эмч, төрийн шагналт Р.Пүрэв

(Нийслэлийн клиникийн төв эмнэлгийн гэрлийн зөвлөх эмч)

БНМАУ-ын хүний гавьяат эмч Д. Бадарчин (Улсын клиникийн төв эмнэлгийн зүү төө-  
нүүр заслын зөвлөх эмч).

БНМАУ-ын Эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан Г. Өөдөс (Эх, хүүхдийн эрүүл мэн-  
дийг хамгаалах эрдэм шинжилгээний улсын нэгдсэн төвийн мэс заслын тасгийн су-  
вилагч)

Эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан Д: Дашдорж (Улсын эмгэг анатомын тов-  
чооны дарга) гавьяат эмч Ц: Янжин (Хавдар судлалын төвийн эмэгтэйчүүдийн мэс  
заслын тасгийн эрхлэгч), гавьяат эмч О. Должинсүрэн (Эх хүүхдийн эрүүл мэндийг  
хамгаалах эрдэм шинжилгээний улсын төвийн поликлиникийн эрхлэгч)

Гавьяат эмч Б. Жав Анагаах ухаан дээд сургуулийн эх барих, эмэгтэйчүүдийн ёвчин  
судлалын тэнхимийн эрхлэгч зөвлөх эмч, БНМАУ-ын гавьяат багш М: Дамбадорж  
(Анагаах ухааны дээд сургуулийн багш); Гавьяат эмч Д. Чулуун (Сүхбаатар аймгийн  
нэгдсэн эмнэлгийн эх барих, эмэгтэйчүүдийн эмч), гавьяат эмч Ж. Хайрула (Анагаах  
ухааны дээд сургуулийн багш, мэдрэлийн мэс заслын зөвлөх эмч) Гавьяат эмч Т.  
Дэлгэр (Халдварт ёвчнийг анагаах клиникийн төв эмнэлгийн зөвлөх эмч) нар

# АНАГААХ УХААН

ЭМЧ, ЭМЗҮЙЧ НАРЫН УЛИРАЛ ТУТМЫН ОНОЛ ПРАКТИКИЙН СЭТГҮҮЛ

32 дахь жилдээ

№ 1 (77)

1991 он

## АГУУЛГА

БНМАУ-ын Эрүүлийг хамгаалах салбарыг хийх өөрчлөлт шинэчлэл болон хүн амын эрүүл мэндийг сайжруулах талаар 2005 он хуртэлх хугацаанд баримтлах үндсэн чиглэлийн тухай

Р. ЦЭРЭНЛХАГВА. Монголын хүн эмнэлгийн ажилтны IV их хурал боллоо

### СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ

Г. ОРОСОО Бага насын хүүхдийн мэдрэл-сэтгэцийн хөгжлийн судалгаа 14

Д. МАЛЧИНХҮҮ Хүүхдийн уушгийн стафилококт анхдагч үрэвслийн үеийн дархалын өөрчлөлт 18

С. ЦООДОЛ, Н. ЦЭНД Сахуу, татрангийн эсрэг нэмэлт давтах вакцинуулалтын үр дүн 20

Б. ЭРДЭНЭЧУЛУУН, Б. ОЮУН, А. САЙНЖАРГАЛ Хүүхдийн дунд чижний идээт үрэвслийн үед хэнгэрэгний ба хэнгэрэгний арын өөрчлөлтийг оношлох асуудалд 23

Ч. ИШХАНД, Ш. ЖАДАМБАА Лицензийг хүүхдийн тэжээлд хэрэглэх боломж 28

### ЛЕКЦ, ТОГМ, ЗӨВЛӨГӨӨ

Э. ЛУВСАНДАГВА, Ч. ӨЛЗИЙБУРЭН Л. Н. ЦВЕТКОВА Хүүхдийн

хоол боловсруулах эрхтэний эмгэг судалалын тулгамдсан асуудлууд 30

Б. ГОМБОСҮРЭН, Ш. ЖИГЖИД-СҮРЭН Улаанбаатар хотын насанд хүргэчдийн гуурсан хоолойн тэлэг-дэлтийн өвчин

Ч. ЦЭЦЭГМАА Бөөрний түүдгэнц-рийн үрэвслийн шалтгааныг судлах асуудалд 35

### УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААН

М. АМБАГА. Монгол анагаах ухааны хий, шар бадгандын тухай ухагдхууныг тайлбарлах асуудалд 38

### ХОВОР ТОХИОЛДОЛ

Д. ЦОГТ Цээжний хөндийд тунгалгийн шингэн хуралдсан тохиолдолд 43

Насны ой, Пэлжээгийн Долгор 45

### ТАНИН МЭДЭХҮЙ, ЭМНЭЛЗҮЙН СЭТГЭЛГЭЭ

Д. ЧОИЖИЛ. Өвчин, Өвчиний шинжийг ангилах нь 46

### ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Ц. МУХАР Өрхийн эмчийн загвар Оноолын судалгааг онцлон хөгжүүлье 53

1989, 1990 онд эрдмийн зэрэг хамгаалсан эмч, мэргэжилтнүүд 62

### **СЭТГҮҮЛИИН РЕДАКЦИИН ЗӨВЛӨЛ:**

**П. Нямдаваа** (эрхлэгч), **Ч. Энхдалай** (орлогч эрхлэгч), **Д. Цогт** (Хариуцлагатай нарийн бичгийн дарга), **Б. Болдсайхан**, **Ж. Батсуурь**, **Б. Дэмбэрэл**, **Г. Дашзэвэг**, **Д. Доржсүрэн**, **Ш. Доржжадамба**, **Э. Пүрэвдаваа**.

---

**Манай хаяг:** Улаанбаатар 210648, Карл Марксын гудамж 4, ЭМЯ  
«Эрүүл энх» хэвлэлийн газар. Утас 22943, 21307

---

**Техник редактор** **Ө. Бямбажаргал**, Хянагч **Д. Чимгээ**, **Б. Наранжартал**

---

Өрөлтөд 1991 оны 1-р сарын 9-нд орж 5000 ш хэвлэв.  
Цаасны хэмжээ 70 x 108 1/16, Хэвлэлийн хуудас 4 С-116  
Д. Сүхбаатарын нэрэмжит Улсын хэвлэлийн комбинат  
өндөр хэвлэлээр хэвлэв.

**БНМАУ-ЫН ЭРҮҮЛИЙГ ХАМГААЛАХ САЛБАРТ ХИХ  
ӨӨРЧЛӨЛТ ШИНЭЧЛЭЛ БОЛОН ХҮН АМЫН ЭРҮҮЛ  
МЭНДНИЙГ САЙЖРУУЛАХ ТАЛААР 2005 ОН ХҮРТЭЛХ  
ХУГАЦААНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТУХАЙ**

Илтгэгч нь: БНМАУ-ын Эрүүл мэндийн сайд П. Нямдааа

Их хурлын төлөөлөгч нөхөд өө!  
Манай эрхэм хүндэт зочид өө!

БНМАУ-ын хүний эмч нарын III их хурал хуралдсанаас хойш бүтэн 14 жил өнгөрчээ. Энэ хугацаанд манай орны нийтгэм, эдийн засаг, улс төр, соёлын амьдралд олон чухал үйл явдал, өөрчлөлт, шинэчлэлт гарлаа.

Эдгээр үйл явцын жинхэнэ оргил нь тус орны нийгмийн амьдралыг бүхэлд нь хамран өрнөж буй өөрчлөн байгуулалт өргэлт буцалтгүй чиг зүгээ олж, гүнзгийрч байгаа явдал юм. Нийгмийн шударга ёс, арчиллын төлөө тэмцэл хүн амын өргөн давхыг хамран өрнөсний үр дунд ардын эрхт хууль цаазат төрийн шинэ тогтолцоого бүрэлдүүлж өхөллээ.

Улс орны амьдрал, хөгжлийн ийм өвөрмөц онцгой цаг үед хүн эмнэлгийн ажилтны IV их хурал хуралдаж байгаа нь түүхэнд тэмдэглэгдэх үйл явдал болох нь өргөлзээгүй.

Хүн амын эрүүл мэндийг хамгаалан бэхжүүлэх асуудал манай төр засгийн нийгэм-эдийн застгийн бодлогын төвд байсаар ирсэн бөгөөд өөрчлөн байгуулалтын өнөө үед ард түмний эрүүл мэндийн тэргүүлэх ач холбогдол улам тод томруун илрэх боллоо.

Улс орны эдийн засаг, нийгэм-улс төрийн амьдралд өргөн далайцтай өрнөж байгаа өөрчлөлт шинэчлэл нь эрүүлийг хамгаалах салбарын хамт олны бүтээлч идэвх санаачлагыг өрнүүлж, үйл ажиллагааныхаа арга барилыг өөрчлөн шинэчлэх замаар урьдчилан сэргийлэх, эмчлэн эрүүлжүүлэх, хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээх ажлын эсийн үр дунд чанарын ахиц гаргахын төлөө тэмцлийг өрчимжуулж байна.

Нөхөд өө!

Манай эрүүлийг хамгаалах салбарт хуримтлагдан дутагдал, догоолдлыг даван туулиж, шинэчлэн өөрчлөх зорилт тавихдаа бид өмнөх үеийнхнийхээ шударга хөдөлмөрийн үр шимээр бүтсэн ололт, амжилт бүхийг ор тас угүйсэх үндэсгүй юм.

Ард түмний эрүүл мэндийг хамгаалан бэхжүүлэхэд чиглэсэн дэс дараатай арга хэмжээний үр дунд сүүлийн 15 жилийн хугацаанд хүн амын эрүүл мэндийн зарим үзүүлэлт сайжирч, өвчлөл, эндэгдлийн бүтцэд өөрчлөлт гарлаа.

Дээрх хугацаанд эрүүлийг хамгаалах салбарыг санхүүжүүлэхэд улсын төсвөөс 6 тэрбум орчим төгрөг зарцуулсанаас, нэг тэрбум шахам төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, 11 мянга шахам ортоой 290 гаруй эмнэлэг, урьдчилан сэргийлэх байгууллагын барилга байгууламжийг ашиглалтад оруулснаар өнөөдөр эрүүлийг хамгаалах

салбар хэвтүүлэн эмчлэх эмнэлгийн 24160 ортог, амбулатори-поликлиникээр нэг ээлжинд 41,5 мянган хүн үзэх хучин чадалтай болоод байна.

Арван таван жилийн өмнө хэрэглэх нь бүү хэл, ихэнх маань сонсоо ч угуй байсан хэт авиан зураглалын багаж (эхосонограф), дотор эрхтэний уян дуран (фбрископ), тооцоолуулж рентген зураглалын болон цацраг идэвхит бодис шингээлтийн зураглалын төхөөрөмж (компьютерт томограф, радиоскеннограф), электрон бичил харуур, цацраг идэвхт бодис болон фермент холбоог эсрэгбиеийн урвал, нэг удаа хэрэглэх зүү, тариур зэрэг орчин үеийн оншилол, эмчилгээний багаж, төхөөрөмж практикт нэвтрэч, зарим нь манай эмч, эмнэлгийн ажилтны өдөр тутмын хэрэглээний зүйл болжээ.

Одоо эрүүлийг хамгаалах салбарт 44,3 мянга гаруй хүн хөдөлмөрлөж, түүний дотор 6000 шахам их эмч, 18 мянга гаруй эмнэлгийн дунд мэргжилтэн ажиллаж байгаа нь 1976 онтой харьцуулахад манай салбарт ажиллагдсдын тоо бараг 2 дахин нэмэгдэж, тус улсын 10000 хүн амд 27,4 их эмч, 87,3 дунд мэргжилтэн ногдох боллоо. Одоогийн манай эмнэлэг, ариун цэврийн тусламжийн цар хүрээ, техникийн жилтийн түвшин нь тус салбарт хэдэн мянган жолооч, инженер-техникийн болон санхүү-эдийн застгийн ажилтан, химич, физич, биотехнологийг зэрэг «эмнэлгийн бус» мэргэжлийн хүмүүс ажилладаг боллоо.

Манай эмч, эмнэлгийн ажилтны дотор мэдлэг мэргэжил, хүнлэг ариун ажил үйлсээрээ хөдөлмөрчин олон түмэн, хамт ажилладаг нөхдийнхөө хайр талархлыг хулээсэн олон шилдэг тэргүүний хүмүүсийн бий. Саязвар манай төр, засгийн газар эрүүлийг хамгаалах салбарын шилдэг тэргүүний хүмүүсийн манлайд яваа гэрлийн эмч, төрийн шагналт Р. Пүрэвт «БНМАУ-ын ардын эмч», эх барих-эмэгтэйчүүдийн эмч Б. Жав, О. Должинсурэн, Д. Чулуун, мэс заслын эмч Ж. Хайрулла, Г. Амгалан, Ц. Янжин, зууний эмч Д. Бадарчин, халдвартын эмч Т. Дэлгэр нарт «БНМАУ-ын гавьяат эмч» АУДЭС-ийн багш М. Дамбадоржид «БНМАУ-ын гавьяат багш», сувилагч Г. Өөдөс, эмгэг анатомич Д. Дашиборж нарт «БНМАУ-ын эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан» цол олгож, сумын эмнэлгийн эрхлэгч их эмч Ц. Даваа, сумын эмнэлгийн жолооч М. Цэвэгмид, гэмтлийн эмч Ц. Дэмбэрэл нарын олон хүнийг БНМАУ-ын одон, медаль, засгийн газрын жуух бичгээр шагналгаа. Төр, засгийн өндөр шагнал хүртсэн энэ нөхөддөө баяр хүргэж, цаашдыхи нь ажилд улам

их ажилт хүсээд бидний хөдөлмөрнийг ийнхүү эндрөөр чиэлж, улам ихний бүтээх урзээ зориг хайрласан тэр, засагтаа та бүхний болон салбарынхаа нийт ажиллагсын эмнээс баярласан, талархсанаа илэрхийлье.

Тэр, засгаас дэс дараатай авч хэрэгжуулж байгаа арга хэмжээ, эмч, эмнэлгийн ажилтуудын бүтээлч хөдөлмөрийн үр дүнд тус орны хүн амзүй, болон эрүүл мэндийн үзүүлэлтүүд өрөөхийдөө сайжирсаар байгаа юм. 1989 оны жилийн эцсийн үзүүлэлтийг 1976 оныхтой харьцуулбал, өнгөрсөн 15 жилийн дотор манай улсын хүн ам 600 мянга шахмаар өсч, 10000 хүн амд ногдох цочмог халдварт өвчин 119 тохиолдлоор, амьд төрсөн 1000 нярайгаас ойндоо хүртэлх хугацаанд эндсэн хүүхдийн төо 20 тохиолдлоор тус тус буурчээ.

Бид манай орны эрүүлийг хамгаалах салбарт гарсан ололт, амжилтын тухай ярийдаа олон улсын зарим байгууллага, ЗХУ болон бусад социалист орны үзүүлсэн тусlamжийн тухай дурдахгүй байх эрхгүй юм.

НҮБ-ын төрөлжсөн зарим байгууллага, тухайлбал. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ), НҮБ-ын хөгжлийн программа (ХП), хүүхдийн фонд (ХФ), хүн амзүйн фонд (ХАФ)-оос өнгөрсөн 15 жилийн хугацаанд нийтдээ 12 сая америк долларын тусlamж үзүүлсний дотор манай 500 шахам эмч, мэргжилтнийг өндөр хөгжилтэй оронд сургаж, мэргжлийг нь дээшилүүлж өгчээ.

Сүүлийн 15 жилд БНМАУ-ын эрүүлийг хамгаалах салбарт ЗХУ-ын техникийн засгийн тусlamцаатайгаар нэг тэрбум шахам төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийсний дотор Хавдар судлалын төв, Улаанбаатар хотын клиникийн төв эмнэлэг, халдварт өзчиний анагаах клиникийн төв эмнэлэг, эх нялхсэн эрүүл мэндийг хамгаалах төвийн цогцолбор, зургаан аймгийн төвийн нэгдсэн эмнэлэг зэрэг томоохон барилга байгууламж орж байгаа юм. БНАГУ, БНРАУ, БНУАУ, БНСЧСУ (тусlamж үзүүлж байх уийн нэрээр) дээрх хугацаанд манай 100 шахам эмчийг буцалтгүй тусlamжийн шугамаар клиникийн ординатурт сургаж өгчээ.

Гэвч харамсалтай нь улс орны нийгэм-эдийн засгийн амьдралд удаан хугацаатгаар тохирсон захиргаадан тушаах арга барил, хэт төвлөрөн удирдлага, төлөвлөлтийн хүнд сурталт механизм нь эрүүлийг хамгаалах салбарын ажилд ч нэн муугаар нөлөөлж, эмнэлэг-ариун цэврийн тусlamжийн чанар, ажиллагсадын мэдлэг мэргжил, үйлчилгээний соёлын түвшин нь хүн амын өсөн нэмэгдэж буй хэрэгцээ шаардлагаас ихээхэн хоцорч, нийгмийн бухимдлын нэг шалтгаан болох болжээ.

Тэр, засгаас улс орондоо хүнээг ардчилсан нийгэм байгуулах улс тэр, нийгэм-эдийн засгийн өөрчлөлтийг шуурхайлан эхэлж, одоо байгаа улс төрийн бүх нам, хүчинүүд хүний эрхэмлэн дээдлэх үзлийг дэмжиж байгаа нь хоцрогдол, доголдлын-

хоо учир шалтгааныг буурь суурьтай задлан шинжилж, хүнийг эрүүл эхийн байлаар өвөг дээдсийнхээ болон хүн төрөлхтний бүтээсэн, бүтээн буй болгосоор байгаа их эвөөс өөрийн орны нөхцөл бололцоо, хүн амынхаа билемхбод, сэтгэл санаа, зан заншилд хамгийн нийцтэй, прэдүйтэй бүхний шингээсэн үндэсний эрүүлийг хамгаалах шинэ бодлого боловсруулан хэрэгжүүлж эхлэх тун хариуцлагатай бөгөөд асар хүндтэй үргийг түүх Та бидэнд ногдуулж байна.

Манай мэргжилтнүүд хүн амын эрүүл мэндийг хамгаалах ажлын одоогийн байдалд шинэчлэл, өөрчлөлтийн үзэл санааны үүднээс дүгнэлт хийж, хэтийн төлвийг нь тодорхойлох ажлыг 1989 оны эхнээс эхэлсэн бөгөөд «БНМАУ-ын эрүүлийг хамгаалах, нийгэм хангамжийн салбарыг хөгжүүлэх, хүн амын эрүүл мэндийг сайжруулах талаар 2005 он хүртэлх хугацаанд баримтлах үндсэн чилгэл-ийн тэсэл боловсруулж, энэ оны VIII сард «Ардын эрх» сонинд нийтлүүлсэн юм. Үндсэн чиглэлийн тэслийг Х сарын 15 хүртэлх хугацаанд хэлэлцүүлэх явцад эмч, эмнэлгийн ажилтан, хөдөлмөрчидтэй 268 удаа санал солилцох уулзалт, ярилцлага зохион байгуулж, 17554 хүний саналыг авснаас гадна төв, орон нутгийн 3575 хүн 1900 гаруй саналыг амаар болон бичээр ирүүлсэн байна. Эдгээр саналыг «Үндсэн чиглэл»-ийг эцслэн боловсруулахдаа харгалзан үзэж зайлшгүй хэрэгжүүлэх асуудлыг тусгаяд, энэ их хуралд ийнхүү хэлэлцүүлэхээр оруулж байна.

Тус орныг төрийн зохицуулалттай зах зээлийн харилцаанд шилжих явцад нэг талаас улс, хоршоолол, олон нийтийн байгууллага, хамт олон, иргэн бүрээс эрүүл мэндээ тавих аяхаарал халамж, ногөө талаас хүн амд үзүүлэх эмнэлэг-ариун цэврийн үйлчилгээний чанар, хүрэлиээ нь байнга боловсронгуй болон сайжирч байх нөхцөлийг хангасан удирдлага-зохион байгуулалтын арга хэмжээ, эдийн засгийн механизмыг боловсруулан хэрэгжүүлэх замаар эрүүл монгол үндэстэн өсч хөгжих болоцоог бурдүүлэхэд эрүүлийг хамгаалах албаны үйл ажиллагааг чиглүүлж, манай улсын иргэн бүрт тэдний оршин сууж байгаа газар, эрхэлж байгаа ажлын онцлогоос үл хамааран эмнэлгийн тусlamжийг жигд, хүртээмжтэйгээр дэлхийн түвшинд үзүүлж чадах монгол үндэсний эрүүлийг хамгаалахын боловсронгуй систем бий болгохыг зорино.

Ингэхдээ одоогийн манай эрүүлийг хамгаалах албаны гол дутагдал боло:

— байгууллага, хамт олон, хувь хүн, нийгмийн болон хувийн эрүүл мэндээ ухамсартайгаар хамгаалах хөшүүрэг болж чадахгүйгээс эрүүл мэндийг эзэнгүйдэхэд хүргэж байгаа эдийн засгийн харилцаа, хуваарилалтын зарчим:

— өвчтөний эмчээ сонгож авах эрх, эмч-эмнэлгийн ажилтны мэдлэг, чадвараараа чөлөөтэй өрсөлдөх нөхцөлийг боогдуулснаас эмнэлгийн материаллаг бааз, техникижилтийн түвшингийн хониродолд хүргэж байгаа эмнэлэг-ариун цэврийн тусламжин дахь улсын монополыг халж;

— шинэчлэгдэж буй эдийн засгийн харыцаанаас үүсч болох эрүүл мэндийн сөрөг үр дагавар, шинээр аж үйлдвэржсэн орнуудад ихээдэг зүй тогтолцой зарим өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг цаг алдалгүй зохион байгуулан хэрэгжүүлэх хэрэгтэй болох юм. Энэ үүднээс «БНМАУ-ын үндсэн хууль», «Эрүүлийг хамгаалах хууль» болон бусад хууль, тогтоомжид хүний эрүүл мэндтэй холбогдоон орсон заалтуудыг эргэн хянаж өөрчлөн байгуулалтын бодлогод нийцүүлэн боловсронгуй болгох, зарим шинэ хууль боловсруулан мөрдөх шаардлагаа зайлшгүй гарна.

Эмнэлэг ариун цэврийн тусламж, үйлчилгээний хүрээг өргөтгөж, чанарыг сайжруулах гол арга зам нь эмнэлэг-ариун цэврийн байгууллагыг улсын, хоршиооллын, хувь нийлүүлсэн, хамтын, хувийн г. м олон хэв шинж, хэлбэрээр хэрэгжүүлж, оршин буй болон тохиолдож болох бэрхшээлийг эрдэм мэдлэг, оюун санааны шударга өрсөлдөөнийн үндсэн дээр шийдвэрлэх явдал гэж үзээ. Зах зээлийн харилцаа сайтар хөгжсөн орнуудад эмнэлэг-ариун цэврийн тусламж, үйлчилгээний олон хэвшиг байдал хийгээд хатуу төловслөгөөт эдийн заасаас зах зээлийн эдийн засагт шилжсэн Хятад, шилжиж буй Дорнод европын орнуудад ийм чиглэл баримталсан нь манай орны хувьд ч ийм байж болох нөхцөлтэйн баталгаа болно. Гэхдээ бидний авч үзэж буй үеийн туршид, нэн ялангуяа зах зээлийн харилцаанд шилжих явцад эмнэлгийн тусламжийн зонхилох хэлбэр нь улсын эмнэлэг байх болно гэж үзэж байна.

Харин улсын эмнэлэг-ариун цэврийн албаны зохион байгуулалтын нэг загварын бүтэц, удирдлагын хэт төвлөрлийг өөрчилж, улсын эмнэлэг, ариун цэврийн байгууллагуудын бие даасан, бүтээлч үйл ажиллагааг өргөтгөж, нэгж байгууллагуудыг орон нутгийн болон хун амын өвчлөлийн өвөрмөц байдлыг харгалzan бүтэц, зохион байгуулалтаа өөрчлөх эрхээр хангана.

Эрүүлийг хамгаалахын төлөвлөлтийн системийг үндсээр нь өөрчилж, эмнэлэг-ариун цэврийн тусламж, үйлчилгээний өргтгийг тогтосны үндсэн дээр нэг иргэнд ногдох зардлын нормативыг боловсруулж төлөвлөлтийн үндэс болгоно.

Эрүүлийг хамгаалахын санхүүжилтийн эх үүсвэрийг нийгмийн баялагтай уялдаа-

тай, баталгаатай байлгах зорилгоод салбартаа улсын төсвөөс зарцуулах хөрөнгийн хэмжээг жил бүр улсын үндэсний орлогын 8—10 хувь байлгах боллогыг баримтлах нь зүйтэй гэж үзээ.

Эрүүл мэндийг хамгаалан сайжруулахад улсын төсвөөс гарна санхүүжилтийн бусад эх үүсвэрийг өргөн ашиглах чиглэл баримталж, аажимдаа даатгалын зүүлийг хамгаалах зарчимд тулгуурласан тэлбэрт үйлчилгээнд тодорхой үе шаттайгааршилжин. Ингэхдээ одоогийн үнэ тэлбэртгүй үйлчилгээг шууд халах замаар бус харин түүнд измэлт болгон дам болон шууд тэлбэрт үйлчилгээг бий болгон өргөжүүлэх замаар хэрэгжүүлнэ.

Эрүүл чийргэ бие бялдар нь хэдэлмөрийн зах зээл дээр ажиллах хучний өртгийг тодорхойлох нэгэн чухал хэмжүүр болох тул зах зээлийн харилцаа нь эрүүл мэндийн үнэ цэнийг өөрийн эрхгүй ижсэгэх болно. Гэхдээ эрүүл мэндийн «үнэ» өсөхийг идэвхгүйгээр хүлээж суух бус, хүн амд эрүүл мэндийн үнэ цэнийг ойлгуулахад чиглэсэн олон талт үйл ажиллагаа, үүний дотор эдийн засгийн хөшүүргийг ч идэвхтэй ашиглах шаардлагатай гэж үзээ.

Хувь хүн өөрийнхөө болон үйлдвэр, аж ахуйн газар, албан байгууллагууд хөдөлмөрийн хамт олон, гишүүнийхээ эрүүл мэндийн төлөө тавих анхаарлыг дээшлүүлэх зорилгоор нийгмийн даатгалын хөрөнгийн тодорхой хувийг үйлдвэр, албан газруудын мэдэлд шилжүүлж, түүнийг хөдөлмөрчдийн эрүүл мэндийн төлөө, эмчилгээ-сувилааны зардлыг нөхөхөд зарцуулах эрх олгох, хөдөлмөрийн чадвар түр алдуулах өвчлөлөөс өөрийгээ урьдчилан сэргийлж эрүүл мэндээ хамгаалах иргэний үүргээ сайн биелүүлж байгаа ажилчин, албан хаагчдад урамшил, шагналт өгөх, эрүүл мэндийн сан бий болгох зарцуулах журмыг хэрэгжүүлнэ. Хөдөлмөр өрхэлж байгаа хүн бүр эрүүл мэндийн даатгалын санд зохих хувь нэмэр оруулдаг журамд дэс дараатай шилжих нь хүн амын эрүүл мэндийн үзүүлэлтэд сайн нөлөө үзүүлэх нэг нөхцөлийг бүрэлдүүлнэ гэж үзэж байна. Эрүүл мэндийн даатгалтай хүн өвчилвэл уг сангаас мэнгэн тусламж авах, эрүүл мэндээ хамгаалж, тодорхой хугацаанд эмнэлгийн тусламж аваагүй бол эрүүл мэндийн даатгалын санд оруулсан мөнтөнийхөө зохих хувийг эрүүлж авах эрхээр хангдах ёстой.

Хүний эрүүл мэндэд сергээ нөлөө үзүүлэх орчин нөхцөлөөс болсон үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчиний үед хөдөлмөрийн чадвар түр алдах үед олгох тэтгэмж, эмчилгээ, оношлол, хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээхэд шаардагдан хөрөнгийг гэм буруутай үйлдвэр, албан газар, байгууллага, хувь хүнээс гаргуулдаг журамд шилжих нь зүйтэй гэж үзээ.

Хүний эрүүл мэндийг санаатайгаар хохироосон этгээд, түүнд дэм нөлөө үзүүлсэн гэм буруутнаэр хохирогсдыг эмчлэх, хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээн зэрд-

лыг гаргуулах, зарим халдварт өвчнөөр өвчилгэсөд эмчилүүлэхээс санаатайгаар зайлсхийсэн үед тэднийг албадан эмчилж, эмчилгээ, үйлчилгээний өргтгиг өөрсдөөр нь төлүүлэх, архаг архичин, хар тамхины болон бусад хорын дон туссан хүмүүс, түүнчлэн өөрийн буруугаар эрүүл мэндээ хохириоогсод төлбөртэй эмчилгээ, үйлчилгээ хийж зардлыг өөрсдөөс нь гаргуулж байж нь зөв юм.

Эрүүлийг хамгаалах салбарт хийх шинчэллэл, өөрчлөлтийг хэрэгжүүлэхдээ урьдчилан сэргийлэх арга хэмжээг урьдын адил үйл ажиллагааны үндсэн зарим болгож, түүнийг жинхэнэ бодит үр дүнтэй ажил болгоно. Ингэхдээ одоогийн хосон сурталдах, лоозогнох хэлбэрээс шийдвэртэй салж, эрүүл хүний эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн эрүүл аж төрөх дэглээм, хүний нас, бие бялдрын онцлогт тохирсон биен тамираа хичээллэх нөхцөл болоцоог бүрдүүлэхэд зах зээлийн эдийн засгийн харицааг ухаалгаар ашиглаж, «эрүүл мэндийн аж үйлдвэрлэл»-ийг явуулах санаачлагыг идэвхтэй дэмжино.

Урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулажад эрүүл ахуй, халдварт судлалын хяналтын албаны гүйцэтгэх үүрэг, тэргүүлэх үйл ажиллагааг улам өндөржүүлж, эрүүлийг хамгаалахын материал, санхүүгийн чадавхийн зонхилох хэсгийг урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд зориудна.

Төв, орон нутгийн эрүүл ахуй, халдварт судлалын хяналтын байгууллагуудыг орчин үеийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон зориулалтын барилга байгууламж, лабораторийт болгож, хүчин чадлыг нь нэмэгдүүлэн бэхжүүлнэ.

Урьдчилан сэргийлэх ажлыг байгаль, орчны хамгаалах, экологийн тэнцвэрийг хадгалах асуудалтай нягт уялдуулан орчны бохирдуулж байгаа үйлдвэрүүдийг хүн ам оршин суух бүсээс гаргах, хортой хаядлыг багасгах, хот төлөвлөлтөд тавих эрүүл ахуй-арийн цэврийн хяналтыг сайжруулах, үйлдвэрлэлд хаягдалгүй технологийг ортгён нэвтрүүлэх, хот, суурин газрын агаар, хөрс, усны бохирдолтой тэмцэх зэрэг арга хэмжээг улс, олон нийт, хувь хяналтын болон байгаль орчны хамгаалах байгууллагын хамтын үйл ажиллагаагаар хэрэгжүүлнэ.

Хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд хор нөлөө, хохирол учруулсан буюу учруулахад хүргэсэн үйлдвэр, аж ахуйн газар, албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагыг енлэөжүүлж элийн засгийн эргаар нөлөөлөх системийг бий болгоно.

Одоо улсын хэмжээгээр барилга, уул уурхай, хзврлэлийн үйлдвэрүүдийн ажлын байрны 43—56 хувь, эрчим хүчиний салбарын ажлыч байрны 33 хувь нь эрүүл ахуйч шаардлагыг хангахгүй байна.

Үйлдвэрлэлийн эрүүл ахуйн нөхцөл, хортой болон хүчтэй үйлчлэх бодисын хэмжээт хяналтын дотоод хяналтын буюу автомат хяналтын систем бий болоогүй, үйлдвэрлэлд ашиглах химийн болисыг галаадаас авахдаа хүний эрүүл мэнд, байгаль

орчинд нөлөөлөх чадварыг судлах, хяналтын систем байхгүй байна. Одоогоор үйлдвэрлэлд 700 орчин изэр төрлийн химийн бодисыг гадаадаас авч ашиглаж байгаагийн 200 орчмын нь химийн найрлагыг мэдэхгүй, судлан тогтоо лаборатори ч байхгүй байна.

Эдгэр нь шинэ үйлдвэр байгуулахадаа төлөвлөх шатнаасаа эхлэн тэнд ажиллах хүний эрүүл мэндийг хамгаалах, хөдөлмөрийн эрүүл ахуйн нөхцэлийг бурдүүлэх ажлыг орхигдуулаад барьж байгуулсныхаа дараа ч ажиллагасдыг хөдөлмөрийн хунд, хортой нөхцөлд оруулах, нэмэгдэл амралт өдлүүлэх, тэтгэвэрт эрт гаргах, цаг хорогдуулах зэрэг хүний эрүүл мэндийн хохирлыг нөхөх чадвартай, тэтгэгмж хөнгөлөлтөөр оруулах зохицгүй практик газар авснаас шалтгаалж байгаа юм.

Малцид, тариаланчид, ажилчдыг сувилан эрүүлжүүлэх, эрүүл мэндийг нь бэхжүүлэх амралт, сувиллын газрыг олшуулах, хүн амын хөдөлмөр, амралт, сургалтын байр, орчин, орон сууцны эрүүл ахуйн нөхцөл, хоол хүнсний тэжээллэг чанарыг сайжруулах, нийт хүн ам ялангуяа говийн аймгуудын хүн амыг эрүүл ахуйн шаардлага хангасан үндсны усаар хүрэлцээтэй хангах арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлнэ. Хүнсний бүтээгдэхүүнийг боловсруулах, хадгалах, тээвэрлэх, борлуулах үйл ажиллагаа, хөдөө аж ахуйд хэрэглэх эрдэс бордоо, химийн хорт бодист тавих хяналтын чангатгана.

Хүн амд, түүний дотор хүүхэд, ёсвэр үеийнхэн, залуучуудад эрүүл аж төрөх мэдлэг, эрүүл ахуй, бие бялдрын хүмүүжил олгож төлөвшүүлэх хичээлийг боловсролын системийн бүх шатны сургуульд тусгай хөтөлбөрөөр зааж, бүх нийтээр эрүүл мэндийн боловсрол эзэмшиг арга хэмжээг зохион байгуулна. Хүн амын эрүүл мэндийг хамгаалан бэхжүүлэх үндсэн хэрэглүүрийн нэг нь нийтийн биен тамир байх болно. Биен тамирийн сургалтыг ясли-цэцэрлэгийн наслын хүүхдээс эхэлж, сургуулийн өмнөх наслын хүүхдүүдэд «Эрүүл мэнд-бие бялдрын хүмүүжил» олгох хээцээл зааж, гэр бүлийн дотор биен тамираар хичээллэх ажлын шинжлэх ухаалагын үндэстэй хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.

Гүйлт, аялал, гимнастик, ног, ушуу зэрэг биен тамир-чийрэгжүүлэлтийн төрөлжсөн клубуудыг байгуулах норматив тогтоож аймаг, хотод «спорт-амралт-аялалын бааз» бий болгох чиглэлийг баримтлан дэмжинэ.

Хүүхдийн эрүүл мэндийг бэхжүүлэх хэрэгт гэр бүлийн үүрэг, хариуцлагыг өндөржүүлж, эх, эцгийг хүүхдээ асарч сувилах, тэдэнд эрүүл ахуйн хүмүүжил олгох ажилд сургадад бүх нийтийн анхаарлыг чиглүүлнэ. Сул биетэй, олон дахин өвчилдөг хүүхдэд зориулан тусгай сургалт, эмчилгээ бүхий сувилал байгуулах ажлыг өргөжүүлнэ. Урьдчилан сэргийлэх тариалтын чанар, хамралтыг сайжруулаан вируст гепатит, гахай хавдар зэрэг хэд хэдэн шочимог халдварт өвчний эсрэг урьдчилан сэргийлэх ажлыг бэхжүүлэх ажлыг өргөжүүлнэ.

гийлэх тарилга, халдварт өвчний оношлол, эмчилгээ, сэргийлэлтийн зарим биобэлдмэлийг эх орондоо үйлдвэрлэн практикт нэвтрүүлэх замаар эдгээр өвчинөөр өвчлөх явдлыг бууруулна.

Улсын хэмжээнд цацрагийн болон биобэлдмэл, эмнэлгийн дотоо халдварт тавих хяналтыг улам өргөжүүлнэ.

Дархалал хомсдлын хамшинж, гоц аюулт болон байгалийн голомтот халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх ажлыг онцгой анхааралд авч, уг халдварт өртөж болзошгүй хүмүүс, халдварт дамжуулах хүчин зүйлд хийх лабораторийн шинжилгээг өртөтгөж, эдгээр халдвараас биеэ хамгаалах арга, мэдлэгт хүн ам, ялангуяа залуучуудыг сургах ажлыг сайжруулна.

Хүн амын нийт өвчлөлийн дотор голлох байрыг өзэлж, хүн амын нас баралт, хөдөлмөрийн чадвар түр алдалтын үндсэн шалтгаан болж байгаа өвчинүүдээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг жинхэнэ үр дүнтэй ажил болгох хэрэгтэй байна.

Сүүлийн 3 жилд улсын хэмжээгээр өвчлөлийн улмаас жил тутам 226,8 мянган хүн, 3304,5 мянган хоног, өвчтөн асарч сууилсан 115 мянган хүн, 1155 мянган хоног хөдөлмөрийн чадвар түр алдаж, үүнд чийгийн даатгалаас 40 сая гаруй төгрөг зарцуулжээ.

Хүн амын өвчлөлд зонхилох байр өзэлж байгаа амьсталын зам, зүрх судас, хоол боловсруулах, мэдрэл, мэдрэхүйн эрхтэн, хавдрын болон халдварт өвчинүүдтэй тэмцэх тодорхой хугацааны иж бүрдмэл хөтөлбөрийг голлох өвчин бүрээр боловсруулаан гаргаж хэрэгжүүлэх эрчимтэй арта хэмжээ авах нь зүйтэй гэж үзэж байна. Энэ хөтөлбөрийн хүрээнд тэдгээр өвчлөөс сэргийлэх, эмчлэх, нөхөн сэргээх тусламжийг бүхэлд нь багтаасан, судалгаа, сургалт, үйлчилгээг хосолсон цогцолборуудыг төвлөрсөн буюу буссилсэн үйлчилгээтэйгээр дагнуулан байгуулж, шинжлэх ухаан, техникийн дэвшлийн шинэ түвшинд хүрэхүйц материаллаг бааз, чадварлаг боловсон хүчинээр бэхжүүлэх арга хэмжээг авах болно.

Ингэснээр бид эрүүлийг хамгаалах салбарыг хөгжүүлэх гол чиглэлийг зөв тогтоож жинхэнэ бодит үр дунд хүрч чадна. Амбулатори-поликлиникийн тусламжийг давуутай хөгжүүлэх бодлогын дагуу тэдгээрийн оношлолын баазыг ойрлын 3—5 жилд багтаан өргөжүүлэн бэхжүүлэх арга хэмжээг авах бөгөөд юуны өмнө хөдөөтийн эмнэлгүүдэд өвчинийг эрт оношлох, нөхцөл бүрдүүлэх болно.

Эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх ажлыг улам боловсронгуй болгох арга замын нэг бол одоо хэрэглэж, үр дунтэй болох нь ноглогдож байгаа өдрийн болон өөрийн стационарны уйл ажиллагааг өргөжүүлэх, улмаар хөдөлгөөнт үйлчилгээний явуулын амбулатори, их эмчийн өргүүлийн байлын үйлчилгээ, явуулын тусламжийн бие даасан бригад ажиллуулах үйлчилгээний шинэ хэлбэрүүдийг зохион байгуулах явдал юм.

Амбулатори-поликлиникийн тусламжийг тулхүү үзүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхдээ эмнэлгийн идэвхтэй хяналтын аргыг улам боловсронгуй болгох өргөжүүлэх, үр дүнг дээшлүүлэх явдал нэн чухал байна. Манай эрдэм шинжилгээний байгууллагуудын судалгааны дүгнэлтээс үзвэл улсын хүн амын 44,8—61,8 хувь нь өвчиний учир диспансерийн хяналтад байх хэрэгцээ гарч байна.

Гэвч одоогоор идэвхтэй хяналтад байх өвчтэй З хүн тутмын нэг нь л ийм хяналтад бүрэн хамрагдаж байна гэсэн тооцоо байгаа юм.

Эрүүл хяналтад байвал зохих бага насын хүүхэд, жирэмсэн эхчүүдээс 194,0 мянган хүн идэвхтэй хяналтад хамрагдажээ. Үүнээс үзвэл одоогоор манай улсын хүн амын 25,5 хувь нь эмчийн идэвхтэй хяналтад хамрагдаж чадаж бүйгээ ажээ.

Хүн амын эмнэлгийн идэвхтэй хяналтын үр дүнг цаашид сайжруулахын тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй юм. Үүнд: Юуны өмнө үйлчилгээний хүн амыр, нийгэм-эрүүл мэндийн байдлыг бүрэн судалж мэдсэн байх явдал идэвхтэй хяналтын эхний шатны нэг гол ажил байвал зохино. Нөгөөтэйгүүр хяналтад хамрагдах хүмүүст энэ ажлын мөн чанар, зорилт, ач холбогдол, үр ашгийг ойлгуулж, итгэл үнэмшил төрүүлэх сурталчилгааны өргөн ажил зохиох хэрэгтэй байна. Өнөөдрийн байдлаар эмнэлгийн идэвхтэй хяналтад буртгэгдсэн, тодорхой хугацаанд үзлэгт орвол зохих хот, суурин газрын хүмүүсийн 30—50 хувь нь үзлэгт ирэхгүй байгаа явдал диспансерчлалын ажлын үр нөлөө муу байгааг нотолж байна.

Хүрц өвчтэй хүмүүсийг больнищ, поликлиникээр эмчлээд хяналтад авахгүй орхисноос болж өвчин архагших тал баагайг гарч байна.

Сурьеэ, арьс өнгө, хавдар, сэтгэл мэдрэл, халдварт өвчиний диспансеруудын зүргээс нүүдлийн амбулатори, нутаг дэвсгэрийн поликлиник, сум, хэсгийн эмч наратай хамтран ажиллах, өвчинийг эрт илрүүлэхдээ поликлиникийн урьдчилан сэргийлэх тасгийн үйл ажиллагааг үр дунтэй ашиглах, ажлын уялдаа холбоог сайжруулах талаар ихээхэн ажил зохиох зүй ёсны шаардлага гарч байна. Цаашид нутаг дэвсгэрийн поликлиникийн эмч, сум, хэсгийн эмч нарын ажлын чанарын үнэлгээнд сурьеэ, хавдар, арьс өнгөний өвчиний эрт оношлолт-илрүүлэлтийг тооцож дүгнэх журамд шилжих болно.

Эмч нараас хяналтын эрүүл, өвчтэй хүмүүст гам дэг, эмчилгээний хоол хэрэглэх талаар тодорхой зөвлөгөө өгөхэд ихээхэн санаачлагаа гаргах хэрэгтэй. Хоолоор эмчлэх, сувилах, эрүүл мэндийг бэхжүүлэх талаар орон нутгийн нөхцөл бололцоонд тулгуурлан баагайг амжилт олох бололцоо байгааг идэвхтэй ашиглалав зохино.

Эрүүл мэндийг хамгаалах хүчин зүйлийн гуравны хөбөр нь аж төрөх ёс, гадаад орчинтой холбоотой гэсэн номлолыг

Үндэслэн хяналтад байгаа эрүүл, өвчтэй хүмүүсийн хөдөлмөр, ахуйг улс, олон нийт, гэр бүлийн гишигдтэй хамтран эруулжүүлэх, архи, тамхи хэрэглэх, би-еин жин ихсэх зэрэг аливаа өвчинд өртөмтгий болгох хүчин зүйлийг арилгах, хүний нийгмийн асуудалд идэвхтэй оролцох, гэр бүлд эрүүл аж төрөх ёсиг хэвшүүлэх талаар эмч нарын зүтгэс зохион байгуулах ажил их байна.

Эмнэлгийн анхан шатны тусlamжийг чанарын шинэ түвшинд гаргахад эмнэлгийн яаралтай ба түргэн тусlamжийн үйлчилгээг шуурхай, үр дүнтэй болгох явдал нэн чухал юм.

Эмнэлгийн түргэн ба яаралтай тусlamжийн шуурхай, бэлэн байдлыг хангаж, хот, хөдөөгийн түргэн тусlamжийн станцуудыг орчин үеийн аппарат, багаж, зориулалтын автомашин, холбооны хэрэгслийр тоноглолж, мэргэжлийн бэлтгэл сайтай эмч ажиллуулан, аймгуудад яаралтай тусlamжийн бригад байгуулах чиглэл баримтлана. Эрчимт болон сэхээн амьдрзуулах эмчилгээний материаллаг бааз, боловсон хучин хангамж, бэлтгэлийг дээшилүүлж, үр дүнг сайжруулна.

Үйлдвэрлэл, ахуйн гэмтэл, ослын үед үзүүлэх эмнэлгийн мэргэжлийн тусlamжийг шуурхай, үр дүнтэй болгож, гэмтэл согогийн тусlamжийн материаллаг бааз, боловсон хучин хангамжийг сайжруулна.

Яаралтай тусlamжийн больниц, түлэнхийг эмчлэх, нөхөн сэргээх эмчилгээний төв байгуулах арга хэмжээ авна.

Эрүүлийг хамгаалахын үндсэн асуудлын нэг бол эх, хүүхдийн эрүүл мэндийг хамгаалан бэхжүүлэх ажил мөн.

Энэ салбарын үзүүлэлт үзүүлэх биднийг гялайлгах юмаар бага байна. Гэтэл хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах асуудлыг нийт хүн амын эрүүл мэндийн тулгуур гэж үздэг бөгөөд хүний эрүүл мэндийн гуравны хоёр нь хүүхэд насанд бүрэлдэг бийээ.

Эрүүл мэндийн яамны тайлан, судалгааны материалаар нялхсэн эрүүл мэндийн үзүүлэлт (индекс) буюу нэг хүртэлх насандaa ямар нэг өвчинөөр орт өвчлөгүй хүүхдийн хувийн жин манай оронд 20—24 хувь байгаа боловч тэд дунджаар 3 удаа ханиад, уушгины хатгалгаар, хоёр удаа, ходоод гэдэсний ба бусад өвчинөөр өвдөж, нийтдээ нэг жилийн хугацаанд 4—6 удаа өвчилж байна. Нэг хүртэлх насандaa өвчилсөн хүүхлийн дунджаар 80 хувь нь эмнэлгэтийн хэвтэн эмчилүүлж байгаа юм.

Нялхсэн эндэгдлийн шалтгаанд амьсгалын зам, хоол боловсруулах эрхтэний ба цочмог халдварт өвчинүүдээс гадна төрөлтийн өндөр түвшин, жирэмслэлтийн хоорондох зайд, эхийн нас, боловсрол, амьдралын түвшин үлээмж нелөөлж байна. Хүүхдийн өвчилэлийн хүүхдийн бүх насанд харьцуулж үзвэл 3 хүртэлх насанд хамгийн их байснаа аажмаар буурч 8—15 насанд хамгийн бага байгаа боловч энэ нь тухайн насны хүүхдэд үзүүлж байгаа эмнэлгийн тусlamжийн хүрэлцээ, өвчин ил-

руулэлттэй холбоотой байж бэлж үндэстэй юм.

Манай судлагчдын судалгасгаар жиремсэн эхчүүдийн 40 хувь нь цус багатай, эмэгтэйчүүдийн 21,8 хувь нь эрхтэй, 3 хүртэлх насны хүүхдийн 30—40 хувь нь сульдаа, тургаал мэтийн суурь өвчтэй, төрсөн эхийн 10 хувьд нь төрөлтийн хоорондын хугацаа 1 жил 6 сараас бага байна.

Манайд хүүхэд, эхийн эрүүл мэндийн асуудлыг дан ганц эрүүлийг хамгаалах байгууллагын хариуцах «мэргэжлийн ажил» мэт буруу ойлголт газар авснаас хүмүүсийн аж амьдралын түвшин, аж төрөх ёс, хоол хүнс, ухамсар, мэдлэг, чөлөөтцаг, ахуй орчин, хувь хүний анхаарал халамж, хариулага зэрэг эх, хүүхдийн эрүүл мэндэд шийдвэрлэх нелөө үзүүлдэг хүчин зүйлүүдийг дутуу үнэлж ирсэн нь асуудлыг ул үндэстэй шийдвэрлэхэд үзүүлж бэрхшээл учруулж байлаа.

Хүүхэд, эхийн нас баралт, өвчлөлийг эрэс бууруулж чадсан орнуудын жишээ, туршлагаас үзэхэд гэр бүл төлөвлөлтийн бодлого баримталж, хүүхдийн хоол тэжээлийг асуудлыг үйлдвэрлэлийн аргаар шийдвэрлэж, хүүхдийн асаргаа сувилгааг сайжруулж, эцэг эхийн хүүхдээ асрамжлах боломж нөхцөлөөр хангаж чадсанд оршиж байна. Энэ талаар манай орцанд зарим арга хэмжээ авч байгаа боловч алиныг нь ч төгс шийдвэрлэгүү, хүүхдийн хоол тэжээлийн хангамж 57—60 хувь, цэцэрлэгжслийн хангамж 20 гаруйхан хувь, жирэмслэхээс сэргийлэх хэрэгслийн хангамж 5—6 хувь байна.

Энэ байдлыг өөрчлөхийн тулд З хүртэлх насны хүүхдийг эцэг эх нь зөрсдөө асран торниулах боломж нөхцөлж бурдуулж, яслийг бие султай буюу эмгэгтэй хүүхдийг сувилахаар өөрчлөн зокион байгуулах, Улаанбаатар зэрэг төвлөрсөн хотод хүүхдийн хэсгийн системийн ажлын зохион байгуулалтыг өөрчлэн боловсронгуй болгох, хүүхдийн хоол тэжээл, чийрэгжүүлэлт, борогшилтын ажлыг улсын хэмжээнд төгс шийдвэрлэх дорвitoй арга хэмжээг давын өмнө авах шаардлагатай юм. Ийм арга хэмжээнүүд заагийн газраас боловсруулсан «Эх, хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах 2000 он күртэлх хугацааны зорилтот программ-д тусгагдан боловч хэрэгжилт удаан байгааг анхаарч, шинэчлэл өөрчлөлтийн бодлоготой уялдуулан боловсронгуй болгож эрчимжүүлэх шаардлагатай байна.

Эх, хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, үр удмынхаа удамшлын цэвэр ариун байдлыг хангах, ухаан хомдол, төрөлхийн гажигтай хүүхэд төрөхөөс сэргийлэх зэрэг олон чухал асуудлыг оновчтой шийдвэрлэх гол арга замын нэг нь БНМАУ-д хүн амзийн зохистой бодлого хэрэгжүүлэх явдал юм.

Хүн амзийн бодлого нь манай орны эдийн засаг, нийгмийн хөгжлийн зорилтуудтай ният уялдсан, хүн амын нийгмийн болон ажил, мэргэжил, насны тохиромж-

той бүтэц бүхий зохицтой тоо нь өсөлтийг хангахад чиглэсэн цогцолбор арга хэмжээг авч хэрэгжүүлэх нөхцөлийг бурдүүлэх болно.

Хүн амзүйн бодлогын хүрээнд хүн амын нөхөн үйлдвэрлэлийг зохицуулах, түүний тоо, чанарын зохицтой бүтцийг хангах, гэр бүлийг бэхжүүлэх, хүмүүсийн эрүүл мэндийг сайжруулж, тэдний дундаж наслалт, идэвхтэй хөдөлмөрлөх хугацааг уртасгах зэрэг нийгэм-эдийн засгийн өргөн арга хэмжээг хэрэгжүүлэх зорилт тулгарч байна. Хүн амзүйн иж бүрэн бодлогын хүрээнд гэр бүл төлөвлөлт, эмнэлэг-удамзүйн алба байгуулан ажиллуулах асуудал нь эрүүлийг хамгаалах байгууллагуудын голлон гүйцэтгэх ёстой ажил болно.

Манай судлаачдын тооцоолж байгааар эх, нялхсын эндэгдэл их байдаг 20-фос доош, 35-аас дээш насанд төрөх явдлыг зотсоож, эмэгтэй хүн бүр 20—35 насандас хоорондоо 3-аас доошгүй жилийн зайтай 5 хүртэлх төрөх бодлого баримтлавал хүн амын цэвэр өсөлтийн одоогийн хандлагыг бууруулахгүйгээр эхийн болон нялхсын эндэгдэл, оюуны хомдолтой хүүхэд төрөхийг тус бүр 3 дахин хүртэл бууруулж, үүнийхээ хэрээр нэг хүнд ногдох эрүүл мэндийн зардлыг төдийчинээ өстөх болоцшоот ажээ.

Хүн амд үзүүлж байгаа эмнэлгийн тусlamжийн чанарыг дээшлүүлэх асуудлыг эцсийн бүлэгт манай улсын эмнэлгийн шинжлэх ухааны хөгжлийн түвшин, түүний эзэмшил боловсон хүчиний мэргэжлийн ур чадвар, дадлага шийдвэрлэж байгаа юм.

Үүнтэй холбогдуулан хэлэхэд сүүлийн үед манай оронд орчин үеийн анагаах ухааны хүчин чадалд итгэх итгэл буурч, ардын эмнэлэг, уламжлалт анагаах ухааны өргөн сурталчилж, шохорох, түүнд бишрэх явдал үлэмж нэмэгдлээ. Зарчмын хувьд хэлбэл, манай оронд шинжлэх ухааны эмнэлтийг нэвтрүүлж одоогийн түвшинд хүргэсэн нь манай төр, засгийн нэг гавьяа, зөв бодлого мөн.

Гэхдээ энэ явдал түүхэн хөгжлийн онцлогтой. 1930-аад оныг хүртэл улсаас уян хатан бодлого явуулж, төвд, монгол, европ эмнэлгийг хослуулан ажиллуулж байжээ. Гэтэл 1930-аад оны үед гарсан зүүний нуталaa, ялангуяа хувьсгалт хууль ёсыг ноцтойгоор завхруулж, нэг хүнийг тахин шүтэх үед «лам нар» гэдэг нэрийн доор олон тооны оточ, эмч, маарамбуудыг хоморголон баривчлах, сүм хийдийн хамт мамбын дацанг нураах, соёлын өвийг үрэн таран хийх, шинэ боловсон хүчин, үүний дотор эмнэлгийн боловсон хүчинийг хэлмэгдүүлэх зэрэг харамсалтай, эмгэнэлт явдал гарсан үе бий. Энэхүү ноцтой алдаа завхралын хор уршиг нь уламжлалт анагаах ухааныг бүхэлд нь шашин шүлэгтэй холбож, хар шар феодалын хэмээх нэр хоч өгч, эм барьдаг, эмчилгээ хийдэг барраг бүх хүнийг «хувьсгалын эсэргүү»-д тооцож сүрдүүлснээр тэднийг «нүүц бай-

далд» оруулж, ардын эмнэлэг, уламжлалт анагаах ухааныг судлан шинжлэх эх сурвалжгүй болгосонд оршино. Үүнээс уламжлалт орчин үеийн анагаах ухааны ихэнх эмч, эрдэмтэд ч уламжлалт анагаах ухаан, ардын эмнэлгийг үнэлхээ болж, түүнийг шинжлэх ухааны үндэсгүй, хоцрогдсон зүйл хэмээн ул үндэсгүй няцаах явдал газар авч залуу эмч, оюутнууд төвд, санскрит байтугай хуучин монгол бичгээ мэдэхгүйгээс эртний анагаах ухааны эх судар, материалаас холдон хөндийрч уламжлалт анагаах ухааныг сургалтад заах байтугай, судлах шинжлэхийг ч дэмжих хүн хордсон нь үнэн.

Энэ бүхэн та бидний амьдарч буй өнөөгийн нөхцөл нэг бол орчин үеийн шинжлэх ухаан гэдгээр бүхийг халхавчлан ардын эмнэлэг, уламжлалт эмчилгээний дэвшилттэй олон арга барил, түмэн бодисын анагаах чадлыг хэт үгүйсгэх, эсвэл ардын уламжлалт эмчилгээ гэдгийг хэт дэвийлгэж, орчин үеийн анагаах ухааны эмнэлгийн ололтыг үгүйсгэх болсон нь манай орны анагаах ухааны судлалд сайнаар нөлөөлөхгүй.

Ардын эмнэлэг, уламжлалт анагаах ухааныг хөгжүүлснээр бид хүн амд үзүүлэх эмнэлгийн тусlamжийн төрөл, эмийн бодисын нөөцийг нэмэгдүүлж болно. Гэхдээ орчин үед дэлхий дахинаа эд, эс, молекулын түвшинд хийж байгаа судалгааг ор тас үгүйсгэх нь үлэмж эргэлзээтэй номлол болно.

Энэ учраас ардын эмнэлэг, уламжлалт анагаах ухааныг орчин үеийн анагаах ухаанаар баяжуулж, хослон хөгжүүлэхээс бус дан ганц ардын эмнэлгээр хүн ардынхаа эрүүл мэндийн асуудлыг шийдвэрлэнэ гэвэл ухралт болох билээ.

Орчин үеийн анагаах ухаан судлалыг төвд-モンголын уламжлалт ба ардын эмнэлгэгтэй зэрэгцүүлэн хөгжүүлэх чин эрмэлзлийг баримталж, аль алиных нь илүү талыг батлан, бие биенээр нь баяжуулах зарчим баримтлах нь зөв шугам гэж үзэж байна.

Энэ асуудлын хүрээнд эх орны эмсүдлэл, эмзүй, рашиансудлал, эмийн бус эмчилгээний аргуудыг илүү давуутай хөгжүүлэх арга хэмжээ авах болно.

Улсын эмийн бодлогыг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулж хэрэгжүүлнэ. Үндэсний фармакопей зохиож мөрдүүлэхийн зэрэгцээ эмийн зориулалтыг журамлах, хүн амын эмийн гаралтай харшилын өвчин, элдэв төрлийн гаж нөлөөний илрэл, хорын дон тусах явдлаас хамгаалахад чиглэсэн эрхзүйн актыг боловсронгуй болгоно.

Улсын эмийн нэгдсэн бүртгэлийг бий болгож, эмийн хэрэгцээг шинжлэх ухааны үндэстэй тодорхойлон импортлох, доодод үйлдвэрлэх эм, эмнэлгийн хэрэглэлийн нэр төрлийг хянан зохицуулж, хүн амын хэрэгцээ, эмнэлэг, урьдчилан сэргийлэх байгууллагын хэвийн үйл ажиллагаат хангахад нийцүүлнэ. Эмийн мэдээлэл, лавлагааны албыг бэхжүүлнэ.

Эм хангамжийн байгууллагын бүтэй, удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгож, өөрийгөө санхүүжүүлэх, зарлагаа өөрөө нөхөх бүрэн аж ахуйн тооцоонд шилжүүлж, үүнтэй холбогдуулан эмийн сангийн ажиллагааны ундсан үзүүлэлтийг гүйлгээний төвлөвлөгөөний биелэлтээр биш, эмийн тусlamжийн чанар, үйлигчлэгээний соёлын түвшингээр дүгнэх журамд шилжин.

Эмзүйн эрдэм шинжилгээний ажил, ялангуяа дотоодын эмийн түүхий эдийн судалгааны ажлыг өргөжүүлэн дотоодын эмийн үйлдвэрлэлийг эрс нэмэгдүүлнэ. Эмийн үйлдвэрлэлийн түүхий эдийн тогтвортой баазыг бий болгох зорилгоор эмийн ургамлын байгалийн нөөц судлах, говь, хангайн бүсэд эмийн ургамал тарималжуулах, сангийн аж ахуй, туршлагын амьтад үржүүлэх станц байгуулна.

Хүн амд үзүүлэх эмнэлэг, ариун цэврийн тусlamжийн чанар, хүртээмж, эцсийн бодит үр дунг дээшлүүлэхэд эмнэлэг урьдчилан сэргийлэх байгууллагын материаллаг бааз ихээхэн аж холбогдолтой нь тодорхой билээ. Манай орны өрүүлийг хамгаалахын цэг салбарын ёсёлтөөс материаллаг бааз хоцрогдсоор ирсэн нь эмнэлэг үйлчилгээний ажилд муугаар нөлөөлсөөр байна.

Манай үүлсад эмнэлгийн нэг оронд дунджаар 4570 төгрөгийн аппарат, хэрэгсэл ногдох, энэ үзүүлэлтээр манай улс ЗХУ болон дорнод европын орууудас 16—55 дахин доогуур байгаа нь оношлол, эмчилгээний чанарт нөлөөлж байна.

Өнөөгийн байдлаар хот, хөдөөгийн эмнэлэг, урьдчилан сэргийлэх байгууллагуудад байвал зохих аппарат, бараж, тоног төхөөрөмжийн хангамж дөнгөж 18—25 хувьтай байна. Үүний дотроос лабораторийн алба ихээхэн хоцрогдсон нь онцгой анхаарал татаж байгаа юм.

Улсын нийт эмийн хэрэгцээний 90 гаруй хувийг гадаадаас авч байна. Эм хангамжийн байгууллагууд дөнгөж 20 гаруй нэр төрлийн эм, эмнэлгийн бараа үйлдвэрлэдэг бөгөөд эмийн үйлдвэрийн тоног төхөөрөмж, технологи ихээхэн хоцрогдонгүй, эх орны ургамал, амьтан, эрдсийн гаралтай түүхий эдийг төдий л ашиглаж гүй байгаагаас хүн амын эмийн хэрэгцээг хангахад дорвitoй нөлөө үзүүлж чадахгүй байна.

Манай хот, хөдөөгийн нийт эмнэлэг, урьдчилан сэргийлэх, эм хангамжийн байгууллагын 65,5 хувь нь зориулалтын барилгагүй байгаагаас нэгдсэн эмнэлгийн 33 хувь, хүүхийн эмнэлгийн 52 хувь, төрөх газрын 68 хувь, халдвартын эмнэлгийн 38 хувь, ариун цэвэр, халдвэр судлалын станцын 74 хувь, сум дундын нэгдсэн эмнэлгийн 47 хувь, сумын эмнэлгийн 53 хувь, эмийн сангийн 73 хувь, яслийн 68 хувь, төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлгийн 50 хувь нь тус зориулалтын бус барилгад байна. Энэ байдлаас шалтгаалан эмнэлгийн байгууллагуудын хүч чадлаас нь

барааг 2 дахин илүү ор тавьж, эрүүл ахуйн норм, норматив, ариун цэврийн дэгэлэмийг ноцтой зөрчиж байгаагаас өвчтэйний эдгээрэлт удаашрах, хүндэрх, эмчилгээний зохих түвшинд хийхгүй байх, эмнэлгийн дотоод халдвэр гарах зэрэг зохисгүй үр дагаварт хүргэж байна.

Ирэх 5 жилд нэг ээлжинд нийтдээ 6,6 мянган үзлэг хийх хүчин чадалтай амбулатори-поликлиник, 7,0 мянган ор буйхий эмнэлэг, эрүүлжүүлэх төв байгуулах, шаардлагатай тооцоо гарч байна. Мэргэжилтнүүдийн үзэж байгаагаар 2005 он хүртэлд хугацаанд ардын эмнэлгийн төв, бичил мэс заслын нэгдсэн клиник, элгийн эмгэг судлалын төв, зүрх судасны төв, сэтгэсийн эмгэг мэдрэл судлалын төв, сурьеэ уушигны эмгэг, арьс өнгөний өвчин судлалын төв, оношлолын нэгдсэн төв, нэг удаагийн зүү тариурын үйлдвэр, эмийн үйлдвэр, эмнэлгийн тоног төхөөрөмж, засвар угсралтын үйлдвэр, шинжилэх ухаан үйлдвэрлэлийн «Биомед» нэгдсэн зэрэг барилга байгууламж барьж, аймгууд болон Дархан, Эрдэнэт хотын нэгдсэн эмнэлгүүдийг лаборатори, шүд, дотор, мэс засал, флюорографийн төхөөрөмжтэй автомашинаар, эрүүл ахуй, халдвэр судлалын болон гоц аюулт халдварт өвчинийг эсэргүүзэн судлах байгууллагуудыг нян судлалын хөдөлгөөнт лаборатори, шуурхай хяналт, халдвэр судлалын зориулалттай автомашинаар хангаж, физик, хими, нян судлалын лабораторийг өргөтгэх;

— эмнэлэг, урьдчилан сэргийлэх, бийийн тамирын байгууллагуудын 70-аас доошгүй хувийнх нь дотоод тавилга, гал тогоо, угаалгын тоног төхөөрөмжийг шинэчлэхийн зэрэгцээ сум дундын нэгдсэн эмнэлгийг 3—5, сумын эмнэлгийг 2—3 автомашинтай болгож, тэдгээрийг багино долгионы холбооны хэрэгслээр бүрэн тоноглох хэрэгтэй байна.

Гэхдээ эрүүлийг хамгаалах албаны материалыг баазыг бэхжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхдээ зах зээлийн эдийн засгийн бүх л механизмыг ухаалгаар ашиглах шаардлага гарч байна. Өөрөөр хэлбэл, улсын эмнэлгүүдийн барилга байгууламж, томоохон төхөөрөмжүүдийг хувьцаагаар эзэмшиүүлэх, хувьцаа эзэмшигчдийн эрүүл мэндийг хамгаалахад өөрчлөлт гаргах замаар сонирхлыг нь өрнүүлэх, гадаадын хувь нийлүүлэгчийг ашиглах гэх мэтийн замаар эмнэлгээ өргөтгэх, шинэчлэх, хөрөнгө бүрдүүлэх хэрэгтэй болох болно.

Ард түмний эрүүл мэндийг хамгаалах сэлгүйг өөрчлөн байгуулж, төгс боловсронгийг болгох нийт ажлын хувь заяаг эцсийн дүнд мэргэжлийн боловсон хүчин, 44. мянга гаруй хүнтэй эрүүлийг хамгаалахын бүхэл бүтэн армиийн гишүүн бүр идэвхтэй, бүтээлчээр оролцож байж шийдвэрлэх болно. Одоо манай их эмч, эмзүйч нарын 75—80 хувь нарийн мэргэжил эзэмшигч, мэргэжил дээшлүүлсний гадна эрдмийн зэрэг, цолтой 250 гаруй, эмчийн нарийн мэргэжлийн зэрэг хамгаалсан 212, клиникийн

ординатур төгссөн 381 эмч ажиллаж байгаа нь дунджаар 13 их эмчийн нэг нь эрдмийн болон эмчийн зэрэг хамгаалсан, клиник ординатур төгссөн байна. Эмнэлгийн дунд мэргэжилтний 37,1 хувь нь мэргэжил эзэмших, дээшлүүлэх курс суралцжээ. Анаагаах ухааны дээд сургуулийг 400, тусгай мэргэжлийн дунд сургууль болон сувилагчийн сургуулиудыг 1200 эмч, мэргэжилтэн, сувилагч жил бүр төгссөн боловсон хүчиний залуу халаа болж байна.

Эдгээр тоо баримт нь эруулдиг хамгаалах салбарын хэмжээнд боловсон хүчиний шилж сонгох, зүй зохицой хуваарилах, зөв байршуулах, нөхөн сэлбэх их нөөцтэй болсныг харуулж байна. Энэ их нөөц боломжийг оновчтой ашиглаж чадахгүй байгаад л боловсон хүчиний асуудлаарх бодлогын нэг гол дутагдал оршиж байгаа билээ.

Эрүүлийг хамгаалах байгууллагын ажлын дотоод зохион байгуулалт, үйл ажиллагааны уялдаа холбоо хангатгүй, ерөнхий болон нарийн мэргэжлийн эмч нарын тооны харьцаа алдагдсан, эмч, мэргэжилтний зарим хэсгийн мэдлэг, мэргэжлийн түвшин, ажлын хариуцлага, сахилга, хүнлэг энэрэнгүй сэтгэл дутагдал байгаа нь эмчилгээ, үйлчилгээний талаар хөдөлмөрчдийн гомдол, санал гарах нэг шалтгаан болж байна. Түүчинчлэн эрүүлийг хамгаалахын бүх шатны удирдах ажилтууд хөдөлмөрчийн олон түмэнтэй ойр дотно ажиллан тэдний санал, дүгнэлт, хүсэл бодлыг сонсож, асуудлыг хамтран зөв шийдвэрлэх талаар иджвс санаачлагатай ажиллахгүй байгаагас дээрх дутагдлыг бүрэн таслан зогсоож чадахгүй байна.

Эмнэлгийн байгууллагатай колбогдсон гомдол, шүүмжлэлийн дийлэнх нь зан харьцааны доголдолтой, ажлын хариуцлага муутай цээн тооны эмч ажилчидтай холбоотой гарч байна. Шүүх эмнэлгийн магадлах товчоор шалгагдсан хэргийн 60 хувь нь эмч, эмнэлгийн ажилчдын ажлын хариуцлагатай холбоотой байна.

Мэргэжил мэдлэгээр хоцрогдсон, хариуцлага сахилгаар сүл, архинд автсан, зан харьцаа, ёс суртахууны доголдолтой цөөн тооны хүмүүс нь хамт олны нэр хүндийг гутааж байна.

Бид эмч нарын цалинг нэмбэл хамаг ажил сайжрах мэтээр нэг үе ярж, бодож байлаа. Гэтэл их эмч, эмзүйч нарын цалинг измэнээр ажилд дорвортой өөрчлөлт гарсангүй. Энэ нь цалингийн одоогийн систем нь ажиллагдын бүтээлч идэвхийг дайчлах хэрэглүүр болж чадаагүйг харуулж байна.

Тиймээс эмнэлэг-арин нь цэврийн бүх үйлдэл, үйлчилгээний өртгийг тооцоолж, ажиллагдыг бүтээсэн өртөгтэй нь шууд хамааралт щалижуулах системд шилжих нь зүйтэй гэж үзэж байна.

Эмчийн үйл ажиллагаанд мэргэжлийн мэдлэг, ур чадвараас газна ёс суртахууны эрхэм чанар, энэрэнгүй сэтгэл онцгой аж колбогдолтой билээ. Энэ талын мэдлэг хүмүүжил олгохол ишаад очигийлон

анхаарч, анаагаах ухааны сургуулзуудад сэтгэлсүдлэл, сурган хүмүүжүүзэх аргазүү, эмчийн ёсэүйн сургалт хариуцсан сургуулын дундын тэнхим байгуулах ч шаардлагатай байна. Эмч, мэргэжилтний ёсэүйт тодорхойлсон, БНМАУ-ын хүний их эмчийн тангараг, ёс суртахууны хэм хэмжээ, мэргэжлийн үндсэн эрх үүрэг зэрэг эрхийн актууд байгаа боловч өдгэр нь эмч, мэргэжилтний хариуцлага, сахилтыг бэхжүүлэх, хүнлэг энэрэнгүй хүмүүжлийг жинхэнэ ёсоор төлөвшүүлэхэд бодит нөлөө үзүүлж чадахгүй байна. Эмч, эмнэлгийн ажилтан, ажилчдын мэргэжлийн онцлог шинж чанар, үйлчилгээний өвөрмөц байдлыг харгалзан цаашид эмч, эмнэлгийн ажилчид ажил, үйлчилгээнийхээ байран дээр аль нэг улс төрийн нам, эвсэл холбоодын эрх ашиггийг илрэхийлсэн үйл ажиллагаа явуулахгүй байх нь эмчийн хүнлэг, энэрэнгүй ёсонад илүү нийцтэй байх болно гэж үзэж байна.

Эмчийн мэдлэг, мэргэжлийн түвшин, ёс суртахуун, энэрэнгүй үзлийн хүмүүжлийг шинж өндөр шатанд гаргаж, өөрчлөгүй нөхцөлд ямар ч их хөрөнгө, барилга байшин, багаж аппарат өөрчлөн байгуулалтын асуудлыг шийдвэрлэж чадахгүй юм.

Эмч, эмнэлгийн ажилчдын үйл ажиллагааны дутагдал, догоилдол, хариуцлагаагүй байдлыг ил тод шүүмжлэн өвлөршгүй тэмцэл явуулахын хамт эмч, эмнэлгийн ажилчдын нэр хүндийг хамгаалах асуудалд ч бодит байдлаар хандах явдал чухал байна.

Эмнэлгийн ажилчдын хөдөлмөрийн чадвар тур алдалт өндөр түвшинд, улсын хэмжээнд хоёрдугаарт байна.

Эрүүлийг хамгаалах салбарын 100 ажиллагдын жилд хөдөлмөрийн чадвар тур алдсан 63,6 тохиолдол, 999 хоног ногдохж байгаа юм. Гэвч эмнэлгийн ажилчдад зориулсан амралт, сувилыг газар байхгүй, дөргээдээ сувилал бүхий эмнэлэг алга байна. Эмнэлгийн ажилчдын ажиллах орчин нөхцөл мую, эмчилгээ-оношлолын багаж хэрэгсэл, урвалж бодисоор үргэлж гачигдаж байна.

Судалгаанаас, үзэхэд их эмч нарын 54,4 хувь нь ямар нэг бэрхшээлтэй нөхцөлд ажиллаж байна. Ажилд бэрхшээл учруулдаг шалтгааны 43,4 хувь нь онош, эмчилгээ, шинжилгээний багаж, төхөөрөмж, эм урвалж дутагдалтайгаас болж байна гэж үзжээ. Орон нутагт ажиллаж байгаа эмч нарын орон сууцаар хангах тухай Сайд нарын Зөвлөлийн тогтоол гарсан боловч энэ талаар тодорхой ахиц өөрчлөлт гараагүй байна. Судалгаанаас үзэхэд анаагаах ухааны дээд дунд сургууль төгсөөд хөдөө орон нутагт очсон олон залуу эмч, мэргэжилтэн орон сууцгүйгээс эмнэлгийн хээ нэг өрөөнд юмуу, айлд сууж ажиллаж, амьдарч байна.

Эмнэлгийн ажилчдын 80 гаруй хувь нь эмэгтэйчүүд байдаг тул өөрсдөө өвчлийн, хүүхдээ харах, сахих зэргээс ажиллас тур чөлөөлөгдхөх нь их байдаг бөгөөд ялангуяа хүүхдээ гэрээр тэтгэмжтэй

харах чөлөөт өргөжүүлсэн зарлиг тогтоол гарсантай холбогдон ажиллах хүчин дутагдан хандлага гарч эхэлж байна.

Ниймээс эрүүлийг хамгаалахын ажилтан, ажилчдын нийгмийн асуудлыг тодорхой төлөвлөгөөтэйгээр дэс дараатай шийдвэрлэх нь эмнэлэг-ариун цэврийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах нэн чухал нөхцөл болно.

Эмнэлэг ариун цэврийн байгууллагад ажиллагдсны хөдөлмөр хамгааллын хувцас, хөрөгслийн хангамж хүрэлцээг сайжруулж, ажлын шинэ байр бий болгоходо ажиллагдсны эрүүл мэндэд сөрөг нөлөөтгүй байх, амрах, алжаал тайлах нөхцөл бололцоог бүрдүүлэхэд онцгой анхаарна.

Туслах аж ахуйг хөгжүүлэх замаар ажиллагдсны амьжирааны түвшинг дээшлүүлэх, ажилд ойр цайны газрыг олшируулж, шөнийн ээлжийн болон мэс ажилбарт оролцсон эмч, ажилчдад хямдруулсан халуун цай, хоолоор үйлчлэх арга хэмжээг өргөжүүлнэ.

Эмнэлгийн ажилчдын амралт, сувидал байгуулж, байгууллага, хувь хүмүүсийн зардлаар аялах, жуулчлалд оролцуулах явдлыг өргөжүүлэх, ээлжийн амралтын хутсааг урамшилын шугамаар нэмэгдүүлэх ажлыг дэмжине.

Эмнэлэг-ариун цэврийн үйлчилгээний зориулалттай бөрилга байгууламжийг ажиллагдсны сууц, хуухдийн ясли, цэизэрлэгийн хамт барьдаг болгохын хамт амины болон хоршоолын сууц барих хөдөлгөөний нийзвэхтэй дэмжинэ.

Эмч, эмнэлгийн ажилчдын ажлын өдрийн үргэлжлэх хугацааг богиносож 6—7 цагийн ажилд шилжүүлэх саналыг тус их хуралд оруулж байна.

Цаашид боловсон хүчний бодлогыг хэт төвлөрүүлэх өрөөсгөл хандлагаас ангинжирч, орон нутгийн болон нэгжк байгууллагууд өөрийн боловсон хүчинийг бэлтгэх, давтан бэлтгэх, хуваарилах ажлыг өөрсдөө бүрэн мэдэж, шийдвэрлэж байхадар бүх шатны удирдах ажилтан, хөдөлмөрийн хамт олны эрхийг өргөтгөх болно.

Анагаах ухааны дээд, дунд сургуульд элсэгчдийн тоог хэтийн хараатай зөв тоопож тогтоох, аль болохоор эмнэлэг, урьдчилан сэргийлэх байгууллагад ажиллагдаас элсүүлэх, гэрээгээр сургах бодлого баримтадна. Сургалтыг эрүүлийг хамгаалахын практикийн хэрэгцээ шаардлагад ойртуулах зорилгоор сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хянан узэж боловсронгуй болгоходо өрөнхий эрдмийн хичээлийн цагийг багасгах, мэргэжлийн хичээлийн цагийг нэмэгдүүлж, бага ангиас нь мэргэжлийн хичээл зааж эхэлдэг болох, оюутнуудын бие даах ажиллагаа, практик дадлага хийх, ялангуяа орчин цагийн эмчилгээ, оношлолын техник, технологийг эзэмших, анагаах ухааны эдийн засаг, сэтгэл судлал, эмийн бус эмчилгээ, гадаад хэлний сургалтын хөтөлбөр цагийг нэмэгдүүлэхэд онцгой анхаарч өөрийн.

Анагаах ухааны дээд, дунд сургууль төгсөгчдөөс онол, практикийн талаар заавал эзэмшсэн байх мэдлэг чадварын үзүүлэлтийн нэгдээн шалгуур боловсруулж мөрдөх, амбулатори-поликлиникийн тусламжийг бие дааж, гардан үзүүлэх практик үйл ажиллагаанд илүүтэй сургаж, дадлагажуулах чиглэл баримтлана.

Анагаах ухааны дээд сургууль төгсөгчдийг 1—2 жил туслах эмчээр ажиллуулж, практик дээр ажиллаж чадаахаа харуулсын дараа улсын шалгалт авч мэргэжлийн диплом олгодог журмыг мөрдөх нь зүйтэй гэж үзэж байна.

Анагаах ухааны дээд, дунд сургуулиудад багшлах боловсон хүчин ялангуяа эмнэлзүйн хичээл заах багшийг бэлтгэх, сонгон авахдаа тодорхой хугацаанд эмнэлгийн байгууллагад ажиллуулж, туршлагажуулсны дараа аттестатилал, мэргэжлийн бэлтгэл, ажлын үр дүн, ажил хариуцах, гүйцэтгэх чадвар, сахилга, ёс суртахууны түвшинг хамт олноор нь хэлэлцүүлж, зохих үзэлтэй өгүүлсний дүнгээр шийдвэрлэдэг журамд шилжих нь зүйтэй.

Анагаах ухааны сургалт, эрдэм шинжилгээний ажлын нэгдлийг хангах зорилгоор Анагаах ухааны их сургууль байгуулан ажиллуулахыг дэмжине.

Эмнэлгийн ажилтны мэргэжил дээшлүүлэх институт байгуулж, курс суралцах, хугацааг хянан үзэж, мэргэжлийн давтан сургалтыг үндэслэн курсээс гадна сэдэвчилсэн семинар, энээс мэргэжил дээшлүүлэх зэрэг хэлбэрээр баяжуулах арга хэмжээ авахын гадна эмнэлгийн асрагадыг тусгайлан сургалт, бэлтгэдэг системтэй арга хэмжээг хэрэгжүүлнэ.

БНМАУ-ын эрүүлийг хамгаалах салбарын үйл ажиллагаа, анагаах ухааныг хөгжүүлэх, хүн амын эрүүл мэндийг сайжруулах зорилтыг хэрэгжүүлэхдээ манай үйл ажиллагааны зарчим, чиглэлтэй нийцэх олон улсын байгууллага дэлхийн бүх улс орон, тэдгээрийн төрөл бүрийн байгууллага, иргэдтэй харилцан ашигтай байх зарчимд үндэслэсэн, үр ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх чиг бодлогыг баримтлан хэрэгжүүлнэ.

Их хурлын төлөөлөгч нөхөд өө!

БНМАУ-ын эрүүлийг хамгаалах салбарт хийх өөрчлөлт, шинэчлэл болон хүн амын эрүүл мэндийг сайжруулах талаар 2005 он хүртэлх хугацаанд баримтлах үзэл баримтлал, түүнийг хэрэгжүүлэх арга замын талаараа товч илтгээв.

Та бүхэн манай ажлыг өөрчлен байгуулах зорилт, арга замын асуудалд нутгийн хичээлийн эдийн засаг, сэтгэл судлал, эмийн бус эмчилгээ, гадаад хэлний сургалтын хөтөлбөр цагийг нэмэгдүүлэхэд эрүүлийг хамгаалах салбарын 44,3

## МОНГОЛЫН ХҮН ЭМНЭЛГИЙН АЖИЛТНЫ IV ИХ ХУРАЛ БОЛЛОО

1990 оны 11 дүгээр сард хуралдсан монголын хүн эмнэлгийн ажилтын IV их хуралд эрүүлийг хамгаалах салбарын 44,3

мянган эмч, эмнэлгийн ажилтан ажилчдыг төлөөлж, ажил үйлсээрээ шалгарсан хот, хөдөгийн 735 төлөөлөгч оролцлоо.

IV их хуралд «БНМАУ-ын Эрүүлийг хамгаалах салбарт 2005 он хүртэлх хугацаанд хийх өөрчлөлт шинэчлэл болон хүн амын эрүүл мэндийг сайжруулах үндсэн чиглэл»-ийн тухай илтгэлийг Эрүүл мэндийн сайд П. Нямдаваа, «БНМАУ-ын эмч нарын эрдэм шинжилгээний нийгэмлэгийн тайлан, дүрмийн тухай илтгэлийг тус нийгэмлэгийн дарга Б. Дэмбэрэл, «Монголын эрүүлийг хамгаалахын ажилтын холбооны зорилт, мөрийн хөтөлбөр, дурмийн тухай» илтгэлийг холбооны түр зөвлөлийн төргүүлэгч Ш. Доржадамба нар тавьж танилцуулав. Мөн БНМАУ-ын засгийн газрын ерөнхий сайд Бямбасүрэн дэлгэрэнгүй уг хэлэв.

Хэлэлцсэн асуудлуудтай холбогдуулан 80 гаруй хүн уг хэлж санал гаргав.

IV их хуралд ЗХУ-ын Эрүүлийг хамгаалах яамны орлогч сайд Царегородский төргүүтэй төлөөлөгчид оролцож, баяр хүргэж уг хэлэв.

Их хурал хэлэлцсэн асуудлуудаар тогтоол гаргав. Үүнд: — БНМАУ-ын Эрүүлийг хамгаалах салбарыг хөгжүүлэх, хүн амын эрүүл мэндийг сайжруулах талаар

2005 он хүртэлх хугацаанд баримтлах үндсэн чиглэлийг зүйтэй гэж үзэж энэхүү үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран нарийвчлан боловсруулж БНМАУ-ын Төр, засгийн газарт толилуулан шийдвэрлүүлж байхыг БНМАУ-ын Эрүүл мэндийн яаманд зөвлөв.

— БНМАУ-ын хүний их эмч нарын эрдэм шинжилгээний нийгэмлэгийн үйл ажиллагаа сүүлийн жилүүдэд идэвхижиж байгааг тэмдэглэж, нийгэмлэгийг цаашид «Монголын хүний их эмч нарын эрдэм шинжилгээний нийгэмлэг» хэмээн нэрэлжээр тогтох, дүрмийг нь батлав.

— Эмч, эмнэлгийн ажилтан ажилчдын нийгмийн болон мэргэжлийн эрх ашгийг илэрхийлсэн олон нийтийн байгууллага болох БНМАУ-ын хүн эмнэлгийн ажилтны холбоог байгуулах нь зүйтэй гэж үзэв. Монголын хүний их эмч нарын эрдэм шинжилгээний нийгэмлэгийн даргаар Б. Дэмбэрэл, БНМАУ-ын хүн эмнэлгийн ажилтны холбооны түр зөвлөлийн ерөнхийлөгчөөр Ш. Доржадамба, дэд ерөнхийлөгчөөр Б. Дагвардорж, хариуцлагатай нарийн бичгийн даргаар П. Янсан нарыг сонголоо.

**Р. Цэрэнхагва (ЭМЯ-ны ажилтан)**

# СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ

## БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН МЭДРЭЛ-СЭТГЭЦИЙН ХӨГЖЛИЙН СУДАЛГАА

ЭХЭМЭШҮТ-ийн ажилтан Г. Оросоо

Бие бялдар, оюун санааны үв тэгш хөгжилтэй, эрүүл чийрэй иргэдийг төлөвшүүлэх нь анагаах ухааны урьдчилан сэргийлэх чиглэлийн үндсэн зорилтуудын нэг билийз.

Өнөө үед олон улс орны эмч, багш сурган хүмүүжүүлэгчид, физиологичид, эрүүл ахуйчид, сэтгэгээ зүйчид бага насыны хүүхдийн өсөлт хөгжлийг их анхааран судлааж байгаа явдал санамсаргүй биш (6), харин энэ наасанд хүүхдийн бие бялдар, мэдрэл сэтгэцийн хөгжил маш эрчимтэй явагдахын зэрэгцээ тэдний эрүүл мэнд, хүмүүжлийн эх сүрвэлж тавигдаж, бие хүн төлөвшиж эхэлдэгтэй холбоотой (5).

Хүүхдийн бие бялдар, сэтгэцийн хөгжлийн физиологийн суурь судалгаа нь эрүүл хүүхэд төрүүлж өсгөх, тэдний хүмүүжих бүх нөхцөлийг хангах, ирээдүйн иргэний бие бялдар, оюун санааны идэвхийг хамгаалаан хөгжүүлэх, аливаа өвчинээс урьдчилан сэргийлж өвчлөл эндэгдлийг бууруулах зэрэг эх, нялхсын эрүүл мэндийг хамгаалахын тулгамдсан зорилтуудыг амьдралд хэрэгжүүлж шийлдэх үндэс мэн.

Хүүхдийг аль болох бага насаас нь эхлэн хөдөлмөрлөх, сурч боловсрох, хүмүүжих сайн сайхан нөхцөлөөр хангах явдал мэдрэл сэтгэцийн эрүүл мэндийг урьдчилан хамгаалах нөхцөл болж байна (5, 7, 9, 37).

Орчин үеийн нийгмийг хөгжлийн нарийн явц, шинжлэх ухаан техникийн давшил, хотжилт, үйлдвэржилтэй уялдан хүн амын сэтгэц, сэтгэхүйн эрүүл мэндийг хамгаалах асуудал анагаах ухааны тулгамдсан зорилтуудын нэг болж байна. Мэдээлэл ихсэж, сургалт хүмүүжлийн хөтөлбөр өргөсөж, техник хэрэгслүүдийг өргөн ашиглаж, бүх насын хүмүүст тавих зан төлөв, ёс суртахуун, гоо-зүйн шаардлагаа ихсэж байгаа нь хүүхдийн төв мэдрэлийн тогтолцооны ачааллыг нэмэгдүүлсээр байна. Эдгээр ачаалал, шаардлагыг зөв зохиоч байгуулж, гадаад орчны сөргөг нөлөөг багасгах асуудлыг физиологийн, ялангуяа нейро-физиологийн судалгааны үндсэн дээр шийдэж байна (24, 5, 30).

Хүүхдийн хөгжлийн маш нарийн олон талт үйл явцыг тэдний сэтгээнийг судлах гүйгээр, мөн тэдний нас хүйсний болон хувийн онцлог, шаардлага, хэрэгцээ, сонирхлыг харгалзахгүйгээр залж удирдах боломжтүй гэж эрдэмтэд үзэж байна (16, 37).

Хүүхэд өсвөр үеийнхийн бие бялдрын хөгжил хурдсаж байгааг гадаадын болон манай орны эрдэмтэд судлан тогтоожээ. Харин хүүхэд, өсвөр үеийнхийн уураг гархинын бүтэц, үйл ажиллагааны хөгжил хурдсаж байгаа эсэх талаар эрдэмтэд санал зөрлөлөнтэй байна (14). Иймд хүүхдийн хөгжлийг өөрийн улс орны нийтэй эдийн засгийн хөгжилтэй уялдуулан судлах тэдний эрүүл мэндийг хамгаалах, сурган хүмүүжүүлэх үндэс болгон хэрэглэх, ялангуяа монгол хүүхдийн сэтгэц, сэтгэхүйн хөгжлийн хэвийн байдал, түүний хувьсал өөрчлөлтийг судлах асуудал чухал болж байна.

Мөн хүүхдийн хуанлийн нас, биологийн насын зөрөө, өөрөөр хэлбэл хүүхдийн эрхтэн тогтолцооны хөгжил насаасаа түрүүлэх нь давамгайлах боллоо. Үүнээс үүдээд хүүхдийн эрүүл мэндийг хамгаалаан хөгжүүлэх, авьяас чадварыг нь эрт илрүүлэн сонгон сургах, хүмүүжлийн ажлыг ялгавартай явуулах зэрэг нь эрдэмтдийн анхаарлыг их татах болов (8).

Уураг тархины бүтцийн гаж хөгжилгүй эрүүл хүүхэд нь сурхас асар ях нөөц чадвартай бөгөөд байнга тогөлдөржих байдаг онцлогтой. Иймд хүүхдийн сэтгэцийн физиологи, насы болон хувийн онцлогийг харгалзан, эрүүл ахуй, хүмүүжил сургалтын арга хэмжээг шинжлэх ухааны үндэслэлтэй зөв зохион явуулбал хүүхэд эрүүл мэнд, бие бялдар, оюун ухаан, ёс суртахуун, гоозүйн өндөр түвшинд хүрч болно (10, 33, 39).

Аугаа их физиологич И. П. Павлов «Дээд мэдрэлийн тогтолцооны үйл ажиллагааны гайхамшигт уян хатан байдал нь надад маш өндөр сэтгэгдэл төрүүлэв. Гагихуу шаардлагатай нөхцлийг бүрдүүлж чадвал хувиргүү, засаж болохгүй тийм үйл гэж байхгүй, бүгдийг засан залруулж, үр дунд хүрч болно» гэжээ.

Гадаад орчны байнгын өөрчлөлт нь хүүхдийн бие махбодын дасан зохицолтод нэмэлт ачаалал үзүүлж, хүүхдийн байгууллага ясли цэцэрлэгт хүмүүждэг хүүхдийн тоо жилээс жилд өсөн хүн амын шилжилт хөдөлгөөн ихсэж байгаа зэрэг нь хүүхдийн мэдрэл сэтгэцийн өөрчлөлт, онцлогийг судлах бас нэг шаардлага болж байна.

Хүүхдийн сэтгэц-физиологийн судалгааны зорилт нь нэгдүгээрт сэтгэц-физиологийн хөгжлийн насын хэвийн байдал тогтоох; хөрдугаарт гадны орчноос үзүүлэх нөлөө, хүүхдийн сэтгэц мэдрэл, фи-

зиологийн эөрчлөлтийг харгалзан судлах явдал мэн (30).

Бага насны хүүхдийн эрүүл мэнд, мэдрэл сэтгэц, бие бялдрын хөгжил нь салшгүй холбоотой. Хүүхдийн эрүүл чийрэг бие эмхбод нь мэдрэл сэтгэцийн хөгжлийн эх үндэс, мэдрэл сэтгэцийн хөгжил нь эрүүл мэндийн нэг шалгуур шинж болно. Иймд хүүхдийн эрүүл мэнд, тэдний билемхбодын хөгжлийн асуудлыг диалекти нэгдэлтэй судлах нь зүйтэй юм (31, 39).

Хүүхдийн биологийн нэг онцлог бол эрхтэн тогтолцооны бүтэц, уйл ажиллагааны хөгжил бүрэн төглөдөржөөгүй, ялангуяа төв мэдрэлийн тогтолцооны уйл ажиллагааг илүү хоцронги байдаг. Үүний тод илрэл бол нярай хүүхэд аминд тулсан зацуулыг мэдрэх, түүнээс зугтан амиа хамгаалах мэдрэхүй, хөдөлгөөний чадваргүй зөвхөн амьдралын зайлшгүй шаардлагаяа хангах цөөн тооны болзолт биш рефлекстэй төрдөг явдал юм (26, 28, 29, 36).

Хүн биологи, нийгмийн гаралтай байдаг нь хүүхдийн нейрофизиологийн судалтааг 2 дахин хүндүүлнэ. Бие хүн төрдөггүй харин нийгмийн орчин, хувь хүний онтогенезийн хөгжлийн явцад бүрэлдэж бий болно. (9, 16, 21, 24, 30).

Хүүхдийн сэтгэцийн хэвийн хөгжилд төв мэдрэлийн тогтолцооны эрүүл мэндээс тадна хүүхдийн төлөө анхаарал халамж тавьж тэдэнтэй харилцан ярилцаж, зугаачуулан тоглож, дэг журам баримтуулж байнга ажилладаг эцэг эх буюу тэднийг орлогч хүн, тэдний амьдралын болон оюуны хөргөцээг хангасан тайван нөхцөл, нөхцөг, тохилог орчин маш чухал (9, 20).

Яслийн байгууллагад эхэлсэн үед тэнд бойжсон хүүхдүүд нь аливаад сонирхол багатай, нэгийг гөлөрсөн, сэтгэцийн баясал, нийээд хөөргүй, хуруугаа хөхөн, идэвх сул, хөдөлгөөний хөгжил хонорсон байсыг өрдэмтэд ажилган «хорионы шинж» хэмээн нэрлэсэн (1).

ХХ зууны эхэн үеэс энэ шинжийг судлан ой хүртэлх насны хүүхдийн өсслэг хөгжил зөвхөн хоол нойр, дулаан орон байр л хангалттай гэсэн үзлийг няцаан хүүхдийт төрсөн өдрөөс нь эхлэн хүмүүжлийн төлөрхий арга хэмжээ зайлшгүй гэдгийг баталсан юм (4, 27, 32, 33).

Н. И. Щелованов (1925) дээд мэдрэлийн тогтолцооны онтогенезийг судалсныхаяа дүүд уураг тархины хөгжил нь удамшиж дамжихгүй, хувь хүний хөгжлийн явцад бүрдэж бий болно гээд «хүүхэд өөрөө гаяндаа мэдэж сурдаг зүйл байхгүй, хүүхдийг бүх зүйлд сургадаг» гэсэн нь төв мэдрэлийн тогтолцооны хөгжилд удамшиж зонхилох нөлөөтэй гэсэн онолыг угүйгээн бол Н. А. Касаткин (1951), Н. Л. Фигурин (1949) нар болзолт рефлексийн үүсэл хөгжлийг судалсан нь хүүхдийг төрсөн өдрөөс нь эхлэн зөв хүмүүжүүлэхийн ач холбогдлыг баталсан суурь судалгаа болсон юм.

И. М. Сеченов, И. П. Павлов нарын сургааль дээр тулгуурлан бусад өрдэмтэй явуулсан судалгаа нь хүүхдийн сэт

гээцийн хөгжил гадаад орчноос хамааралтай баталсан. Хүүхдийн хөгжилд удамшил, гадаад орчин, сургалт З чухал нөлөөтэйг өрдэмтэд санал нэгтэй зөвшөөрч, байна. В. А. Гатев (1973)-ын хэлснээр гадаад орчны хүчин зүйлийн нөлөөллийг тодорхой зорилго тавин сонгож хэрэглэхийг сургалт гэнэ.

Хүүхдийн асаргаа сувилгааны явцад олон дахин давтагдаг нөлөөллөөр болзоот рефлексүүд үүсэн хүүхэд янз бүрийн зөв, буруу хэвшил эзэмшин, хувийн туршилагыг хуримтлуулдаг байна (3, 34).

Хүүхэд гадаад орчноо зөвхөн хүний оролцоогоор тусган танин мэдэж байдаг тул хүүхэдтэй ажиллаж буй хүмүүс нь тэдний амьдралын хэрэгцээг хангаснаар нийгмийн өмнө хүлээх үүргээ биенүүлж чадахгүй (23, 29, 35).

Хүүхдийн байгууллагад хүмүүжик буй хүүхэд нь тоглож наадах, хоол унд, асаргаа сувилгааны хувьд дутагдах зүйлгүй боловч эцэг, эхээсээ тусгай байдаг нь хүүхдийн сэтгэл хөдлөл, ухамсар, сэтгэцийн хөгжилд ч нөлөөлж болно. Өнөө үед дэлхий дахинаа «хорионы шинж»-ийн гол шалтгаан нь хүн хүүхэдтэй бага ярж харьцах явдал гэдэг нь нэгзгэн батлагдаж яслийн хүмүүжүүлэгч хэн байх вэ? гэдэг асуудалд их анхаарч байна (4, 22, 35, 44).

Хүүхэд гурван долоо хоногтойдоо хүний харцанд хариулж эхэлнэ. Хүний нүүр нь хүүхдэд тоглоом, хөх, угжнаас илүү таалагдаж анхаарлыг их татаж тайвшируулдаг. Хүүхэд амьдралынхаа эхний долоо хоногуудад эхийн дууны аялга, эхийнхээ үнэрийг ялгаж, шургэх, биенийн халуун зэргийг мэдэрч, өхөөрдсөн дууны аялганд нь уярч, эх хүн ч хүүхдээ гэнших, уйлагнах төдийд түүний учрыг ойлгон, хүүхдийн шаардлага, хэрэгцээг хангаж чадлаг нь эх, хүүхдийн биологи-физиологийн холбоо юм. Эх, хүүхдийн энэ холбоо нь нийгмийн амьдралын үндэс болдог. Цаашилбал эх, хүүхдийн биологи, физиологийн энэ холбоог хүүхэд-яслийн хүмүүжүүлэгчийн хооронд хэрхэн язж бий болгох асуудал бүрэн шийдэгдээгүй байна. (17).

Судлагчид (41,42) эхийн мээмээ, хөхөн өссөн 1 настай хүүхдийн сэтгэц, хөдөлгөөний хөгжил, нийгмийн гишүүн төлөвшилт нь угжаар өссөн үеийн хүүхдийнхээс илүү байдгийг, мөн өсвөр залуу насандаа эх болсон охидуудын хүүхдээс нас бие гүйцэн эхчүүдийн хүүхэд сэтгэцийн хөгжлээр давуутай эзргийг судлан тогтоожээ (43). Мөн хүүхдийн бие даасан идэвхтэй ажиллагааг хөгжүүлж бусадтай харьцах бодомжоор хангах нь чухал (25). Нийгмийн бусад гишүүдтэй хүүхэд харьцах харьцаа нь нэгдүгээрт хүүхэдтэй ойр дотно байдаг хүмүүсийн шууд нөлөөлэл; хөёрдугаарт хүүхдийн өөрийн нь идэвхтэй ажиллагаа; гуравдугаарт бусад хүүхэдтэй харьцах харьцаанаас бүрдэнэ (15,27). Хүүхдийн янз бүрийн насанд эдгэр харьцааны үүрэг өөр өөр байх бол-

ловч насанд хүрэгсийн ухамсартай нөлөөлөл л аль ч насын хүүхдийн сэтгэцийн хөгжилд онцгой нөлөөтэй (2,26).

Хүүхдэд ой хүрэхэд бусдын үйлдлийг дууриах чадвартай болдог, бага насанд бусдыг дууриах нь их тул үеийн хүүхдийн нөлөө их байдаг. Эр нь хүүхднийг төрсөн өдрөөс нь эхэн хүмүүжлийн арга хэмжээг зөв явуулах нь чухал юм. Орчин үед эрүүл чийрэг хүүхдийг зөв хүмүүжүүлэхэд л их анхаарч байна (31). Буруу хүмүүжсэн хүүхдийг засан хүмүүжүүлнэ гэдэг нь маш бэрх асуудал юм.

Гэр бүл нь нийгмийн соёлын хөгжил, нийгэм болон үйлдвэрлэлийн харьцааны хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг энэг, эх, ах дүү, эр эмийн харьцаанд тулгуурласан нийгмийн бичил орчин бөгөөд хүүхэд гэр бүлийн дотор хүмүүстэй харьцаж хэлд орж, бодит өртөнцийн үйл, эд юмсыг танин мэдэж авдаг учраас гэр бүл нь хүүхдэд нийгмийн тусгалыг дамжуулагчийн үүрэг гүйцэтгэн (12, 13, 18, 23).

1960-аад оны үеэс судлагчид анхаарах болсон «өртөмтгийн байдал» гэдэг ойлголт нь бага насын хүүхдийн биологийн ямар байдалд гадаад орчны ямар хүчин зүйл нөлөөлж байгааг илрүүлэх явдал юм. «Өртөмтгийн байдал»-д үзүүлэх гадаад хүчин зүйлсийн нөлөөг арилгаж түүний үр дагаврыг багасгахын тулд дараах зүйлүүдэд анхаарах хэрэгтэй (21). Үүнд:

— Сөрөт нөлөө тооны хувьд цөөн байвал тэдний үйлцэл, үр дагавар сүл байна.

— Биологийн хүчин зүйлсийн сөрөт талыг амьдрал, сэтгэц нийгмийн аятай нөхцөлөөр дарангуйлж илрүүлэхгүй байж болно.

— Сэтгэц-нийгмийн сөрөт нөлөөний үр дагавар нь биологийн хувьд эрүүл байхад сүл илэрнэ.

— Зөвхөн тодорхой нөлөөлэтийн дор илрэх «өртөмтгийн байдал» байна.

— Тодорхой «өртөмтгийн байдал» урьдчилан тооцоолсоос тод илэрч байвал хүүхэд гадаад орчны нөлөөнд мэдрэмтгийн байна.

— Биологийн, сэтгэц-нийгмийн хүчин зүйл нь харилцан бие биеz дэмжинэ.

Биологийн болон нийгмийн хүчин зүйлс нь хоорондоо салшгүй уялдаа холбоотой байх боловч эцсийн эцэст нийгмийн хүчин зүйл нь хүүхдийн хөгжлийг тодорхойлдог гэж өрдөмтэд үзэж байна.

Гадаад орны өрдөмтдийн судалгааны ажлын дүнг нэгтгэн дүгнэлт хийвэл дараах асуудлууд тулгамдаж байна.

— Монгол хүүхэд, освэр үеийнхийн мэдрэл сэтгэцийн хөгжлийг улс орны нийгэм эдийн засгийн хөгжилтэй уялдуулан судалж, тэдний эрүүл мэндийн хамгаалах, сурган хүмүүжүүлэх, тоо-зүй, зан төлөв, эр эмийн хүмүүжил олгох зэрэг ажлуудын онолын үндэс болгон хэрэглэх;

— Хүүхдийн эрүүл мэнд, сургалт хүмүүжил, ер нь шине хүнийг хүмүүжүүлэх асуудалд иж бүрэн хандахын нэг үндсэн нөхцөл нь хүүхдийн сэтгэл зүйчдийг бэлтгэж, хүүхдийн «эгзэгтэй» насуудыг тог-

тоох сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах хөгжүүлэх зэрэг асуудалд анхаарах явдал юм. Хүүхдийн сэтгэл-зүйг физиологич, философичид хамтран судлах;

— Манай орны нөхцөлд хүүхдийг яслийн нөхцөлд хүмүүжүүлж буй арга барилд шүүмжлэлтэй хандан, хүмүүжүүлэгч багшиг нарыг тусгайлан бэлтгэх, нэг хүмүүжүүлэгч багшид болон ангид ноогдох хүүхдийн тоог цөөрүүлэх, яслийн хүүхдийн эрүүл мэнд, хүмүүжлийн байдалд тавих эмнэлэг сурган хүмүүжүүлэх хяналтыг сайжруулахад анхаарах.

— Иэг хүртэлх насын хүүхдийн дасан зохицолын болон сэтгэцийн хөгжлийн онцлогтой уялдан яслиар хүмүүжүүлэхэд хэцүү улмаар өвчлөл эрүүл мэндэлж нөлөөлдөг зэргийг харгалзан эхэд төрсний дараа олгодог цалинтай ба цалингүй амралт чөлөөг уртасгах шаардлагад эмьдралаас урган гарч байна;

## АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

*Н. Авеева, С. Мещерякова.* Младенец: такой простой и такой сложный. Дошкол. воспитание. 1986, № 10, стр 32—37.

*Н. М. Аксарина.* Воспитание детей раннего возраста. М, Медицина, 1977, стр. 304,

*Е. И. Андреева.* Успехи в организации общественного воспитания детей в социалистических странах. стр 1—4. Тезисы докладов 1-й Международной конференции по охране здоровья детей в Риге, м, 1978.

*О. В. Баженова.* Диагностика психического развития детей первого года жизни. М, Изд-во МГУ, 1986, стр 92.

*Т. Бауэр.* Психическое развитие младенца. Перевод с англ, М, «Прогресс», 1985, стр 320.

*М. В. Бениаминова.* Воспитание детей, М, Медицина, 1985, стр 287

*А. Д. Болдырева, Э. Л. Фрухт.* Методы диагностики соответствия уровня развития детей их биологическому возрасту, стр 144—145. В кн: Основные закономерности роста и развития детей и критерии периодизации. Одесса, 1975.

Внешняя среда психическое развитие ребенка, Под редакцией Р. В. Тонкова-Ямпольская (СССР), Е. Шмидт-Кольмер (ГДР), Э. Хабинаковой (ЧССР), М. Медицина, 1984, стр 208.

*А. А. Воробьева.* Физиологические основы организации учебно-воспитательной работы с детьми. Педиатрия, 1983, № 1, стр 49—52.

*Б. А. Гатев.* Развитие зрительно-двигательной координации в детском возрасте. София, 1973, стр 154.

*И. И. Грёбешева, Л. Г. Камсюк.* Актуальные вопросы организации работы с семьями детей по охране и укреплению их здоровья. Педиатрия, 1986, № 12, стр. 3—7.

*И. И. Гурскис.* Работа детской поликлиники с семьей по воспитанию здорового ребенка. Педиатрия 1988, № 5, стр 87—88.

*Л. Т. Журба, Е. М. Мастюкова.* Нару-

ашение психомоторного развития детей первого года жизни. М., 1981, стр. 272.

*Т. С. Залевская, Э. Л. Фрухт* Влияние некоторых социальных и биологических факторов на развитие детей первых 3 лет жизни стр. 113—114. В кн: Тезисы докладов 1-й Международной конференции по охране здоровья детей в Риге. М., 1978.

*Д. Н. Исаев* Психопрофилактика в практике педиатра. Л., Медицина, 1984, стр. 192.

*Л. Г. Камрюк* Пути повышения роли семьи в формировании здорового ребенка. стр. 42—43. В кн: Тезисы докладов XI Всесоюзного съезда детских врачей, М., 1982.

*Н. И. Касаткин* Очерк развития высшей нервной деятельности у детей раннего возраста. М., Медгиз, 1951.

*М. Ю. Кистяковский* Развитие движений у детей первого года жизни. М., Педагогика, 1970, стр. 205.

*В. В. Ковалев* Проблема факторов риска в возникновении нарушений психического здоровья в детском возрасте и ее значение для профилактики, стр. 55—56. В кн: Психогигиена детей и подростков. М., Медицина, 1985,

*Я. Кох* Значение воспитания в раннем детстве, стр. 87. В кн: Тезисы докладов Международной конференции по охране здоровья детей в Риге. М., 1978.

*Д. Н. Крылов, Т. П. Кулакова* Нервно-психическое здоровье и задачи психогигиены детства, стр. 152—153. В кн: Гигиенические аспекты здоровья детей и подростков. Под редакцией Г. Н. Сердюковской. М., 1984.

*Д. Н. Крылов* Критические периоды в психофизиологическом развитии детей и подростков, стр. 17—35. В кн: Психогигиена детей и подростков. М., Медицина, 1985.

*А. В. Мазурин, И. М. Воронцов* Пропедевтика детских болезней. М., Медицина, 1986, Стр. 430.

*К. Л. Печора* Контроль за психическом развитием детей в СССР. стр 74—91. В кн: Состояние здоровья и диспансеризация детей раннего возраста. Под редакцией Т. Я. Черток (СССР), Г. Нубиш (ГПР), М., Медицина 1987.

Психическое здоровье и психосоциальное развитие детей (Доклад Комитета Экспертов ВОЗ) Женева, 1979, стр 85.

Руководство по педиатрии. Общие вопросы: развитие, питание, уход за ребенком, Под редакцией Р. Е. Бермана, В. К. Вогана. Перевод с англ. М. Ф. Логачева, В. Ф. Кобеляцкого и С. С. Никитина, М., Медицина, 1987, стр 640.

*Г. Н. Сердюковская* Задачи психогигиена и пути ее развития. В кн: Психогигиена детей и подростков. М., Медицина, 1985, стр 7—17.

гиена детей и подростков. М., Медицина, 1985, стр 7—17.

*М. Я. Студеникин* Научно-технический прогресс и научные проблемы здоровья детей. Педиатрия. 1985, № 11, стр 3—5.

*Р. В. Тонкова-Ямпольская* Проблема адаптации при поступлении в дошкольные учреждения. В кн: Тезисы докладов 1-й международной конференции по охране здоровья детей в Риге. М., 1978, стр 73—75.

*Р. В. Тонкова-Ямпольская, Л. Г. Голубева* Достижения в системе общественного воспитания детей. Вопр. охр. мат. 1980. № 3, стр 3—7.

*Р. В. Тонкова-Ямпольская, Л. Г. Голубева* и соавт Система профилактического медико-педагогического обслуживания здоровых детей раннего возраста на педиатрическом участке (Методические разработники). М., изд. ЦОЛИУВ, 1981, стр 107.

*Р. В. Тонкова-Ямпольская, Л. В. Дружинина* и соавт Руководство для врачей домов ребенка. М., Медицина, 1987, стр 320.

*А. Ф. Тур* Пропедевтика детских болезней. Л., Медицина, 1967, стр 490.

*Физиология развития ребенка*. Под ред. В. И. Козлова, Д. А. Фарбер. М., Педагогика, 1983, стр 296.

*Н. Л. Фигурин, М. П. Денисова* Этапы развития поведения детей от рождения до года. М., Медгиз, 1949, стр 101.

*Т. Я. Черток, Р. В. Тонкова-Ямпольская* Определение понятия здоровья, стр 10—19. В кн: Состояние здоровья и диспансеризация детей раннего возраста. Под редакцией Т. Я. Черток (СССР), Г. Нубиш (ГДР), М., Медицина, 1987.

*Н. М. Щелованов* Методы генетической рефлексологии. В кн: Новое в рефлексологии и физиологии нервной системы. Л, М, 1925, стр 134—153.

41. Baumgartel C. Psychomotor and social development of breast-fed and bottle-fed babies during their first year of life. Acta paediatrica hung 1984. № 4 409—417

42. Bhatia B. D. Banerjee D. Agarwal K. N. Ixtraluteal growth, Relationship w. th maternal body size and dietary intakes Indian J. paediatr 1983. 50. № 404 241—246

43. Levine L, Garcia coll C. T. Oh. w Determinants of mother-infant interaction in adolescent mothers. pediatrics 1985. 75

44. Margavet Roberts. play, language and experience the role of the adults Раде 119—124 В кн Тезисы докладов 1—й Международной конференций по охране здоровья детей в Риге М. 1978

ХҮҮХДИЙН УУШГИНЫ СТАФИЛОКОКТ АНХДАГЧ  
ҮРЭВСЛИЙН ҮЕИЙН ДАРХЛАЛЫН ӨӨРЧЛӨЛТ

Д. Малчинхүү

Манай улсад хүүхдийн уушгины стафилококт үрэвслийн эмгэг жам, эмнэлзүй, өмчилгээний асуудал нэлээд судлагдсан боловч бага насны хүүхдийн өвчлөл, эндэгдлийн шалтгаанд стафилококт халдварын эзлэх байрт онцгой өөрчлөлт гарсангүй.

Бид уушгины стафилококт анхдагч цочмог үрэвслийн явцад дархлаа тогтолцоо хэрхэн өөрчлөгдөхийг тодруулах зорилгоор уул үрэвсэлтэй 58 хүүхдийн тунгалааг эс (ТЭ), үүсгэвэр эс (ҮЭ)-д аяндаа шилжих урвал, өвөрмөц бус идэвхжүүлэгч фитогемааглютинин (ФГА) стрептококк, стафилококк (СТА), пневмококк, туберкулин гэх мэт нянгийн өвөрмөц, эсрэг төрөгчөөр нөлөөлөхөд ТЭ, ҮЭ-д шилжих урвал, ТЭ-ийн хонины улаан (ҮЭ)-тэй цэцгэн хүрээ үүсгэх урвал, цусны сийвэнгийн И<sub>г</sub> А, И<sub>г</sub> Ж, И<sub>г</sub> М-ийн хэмжээ, стафилококкийн хорын эсрэг биеийн таньцийг тодорхойлж, нянгийн харшил төрөгчөөр арьсны сорил тавих зэрэг шинжилгээ хийж, эрүүл 20 хүүхдийн мөн үзүүлэлтүүдтэй харьцуулан судалсан юм. (20)

Судалгааны дүнг хүснэгт 1-ээр үзүүлэв.

Судалгаанаас үзэхэд:

1. Уушгины стафилококт анхдагч үрэвслийн ид үед ТЭ хонины ҮЭ-тай цэцгэн хүрээ үүсгэх чадвар, ТЭ-ийн абсолют тоо, ТЭҮЭ-д аяндаа шилжих болон ФГА-ний нөлөөгөөр шилжих идэвх эрс буурч, эдгэрэлтийн үед эл үзүүлэлтүүд сайжирсан боловч эрүүл хүүхдийн хэмжээнд хүрч чадаагүй байна. Харин ФГА-ний нөлөөгөөр ТЭҮЭ-д шилжих чадвар хэвийн байдалд орж байгаа нь Т—ТЭ-ийн үйл ажиллагааны идэвх түрүүлж сэргэж буйг харуулж байна. Ийнхүү уушгины стафилококт анхдагч үрэвслийн үед Т-тунгалааг эсийн

харьцаангүй ба туйлын тоо эрс багасч, түүний үйл ажиллагааны идэвх магадтай буурч байгаа нь стафилококкийн халдварт эсийн дархлааг дарангуйлсанас эсвэл Т-тогтолцоо дайчлагдан зарцуулагдаж байгаатай холбоотой байж болох юм. Ингэж эсийн дархлаа дарангуйлагдсан үедээ хүүхэд амьсгалын замын вирусийн халдварт өртөмтгийн байдгийг бидний ажиглалт нотолж байна.

2. Страфилококк, пневмококк, туберкулин зэрэг эсрэгтөрөгчийн нөлөө мэдэгдэхгүй байхад стафилококкийн эсрэг төрөгчийн нөлөөгөөр ТЭҮЭ-д хувирах идэвх нэмэгдэж буй нь стафилококкийн халдварт бие маҳбодын мэдрэгжилт ихэсч байгааг үзүүлж байна. Нянгийн мэдрэгжлийн энэ үзүүлэлт арьсны харшлын сорилын үр дунтэй тохирч байв. Өвчтөний 53,3%-д арьсны сорилоор стафилококкийн мэдрэгжил эзэрэг (+) гарсан байна. Өвчтөний цусанд стафилококкийн хорын эсрэг эсрэгбие нэмэгдэхийн хирээр энэ мэдрэгжил ба-гасч байна. Харин өвчний хүнд хэлбэр, уушгины бүтэц эздрэл гарах болон өвчин ужиграх үед стафилококк, пневмококк, стрептококт билемахбодын мэдрэгжил нэгэн зэрэг ихэсч байгаа нь эл өвчний эмгэг жамд нянгийн хавсармал үйлчилгээ болон харшил чухал рольтойг харуулж байна.

3. Страфилококкийн хорыг эсрэг эсрэг биеийн таньц өвчний ид үед бага байснаа аажим нэмэгдэж эдгэрэх үед 3—4 дахин ихэсч байхад хорын эсрэг эсрэгбие агуулдаг И<sub>г</sub> Ж-ийн цусны сийвэн дэх хэмжээ өвчний ид үеийнхээс эдгэрэх үед 50% нэмэгдсэн байна.

Ийнхүү уушгины стафилококк үрэвслийн явцад шингэний дархлаа идэвхжин дайчлагдаж байгаа нь цусны сийвэнгийн И<sub>г</sub> Ж, И<sub>г</sub>

**Уушгины стафилококт аихдагч үрэвслийн  
үед дархлааны үзүүлэлт өөрчлөгджэх нь**

Хүснэгт 1

Дархал шинжилгээний ҮЗҮҮЛЭЛТ	ЭРҮҮЛ ХҮҮХДИЙН ХЭМЖЭЭ	уушгины аихдагч ста- филоококт ҮРЭВСЛИЙН	
		ид үе	эд гэрэх үед
ТЭ, ҮЭ-д аяндаа шилжих урвал (%)		3,0±0,4	1,6±0,3
ТЭ, хонины ҮЭ-тэй цэцгэн хүрээ ҮҮСГЭХ урвал		60,1±1,7	40,3±1,7
ТЭ-ийн тоо (1 мкл-д мянгаар)		1,8±0,2	1,0±0,2
ФГА-ийн нөлөөгөөр ТЭ ҮЭ-д шилжих урвал (%)	1—7 нас	66,2±1,1	48,1±2,2
	8—12 нас	71,8±1,7	55±1,8
СТА-ийн эсрэгтөрөгчийн нөлөөгөөр ТЭ, ҮЭ-д шилжих урвал (%)		1,7±0,3	6,6±1,6
СТА-ийн хорын эсрэг эсрэгбненийн таньц (AE)		1,2±0,2	2,7±0,3
Дархан бөөмлүүрийн хэмжээ (г/л)			
ИгЖ.	1—6 нас	12,13±0,5	13,24±1,1
Иг А	7—12 нас	13,9±0,8	14,4±0,8
	1—6 нас	0,97±0,04	1,03±0,15
Иг М	7—12 нас	1,52±0,08	1,25±0,1
	1—6 нас	1,08±0,05	0,91±0,1
	7—12 нас	1,11±0,06	0,69±0,15*
			1,27±0,15

*Тайлбар:* \*Эрүүл хүүхдийн үзүүлэлтээс магадтай ( $P<0,05$ ) багассан, ихэссэн үзүүлэлт.

А-гийн магадтай ихсэлтээр нотлогдож байна. Харин Иг М-ийн хэмжээ өвчиний эхний үед л бага, өвчиний явцад Иг Ж, Иг А-гийн түвшин мэдэгдэхүйц өсөхгүй, стафилококкын хорын эсрэг эсрэг биеийн таньц нэмэгдэхгүй байх нь хүүхдийн тавиланд таагүй нөлөөлж хүндрэл гарах, өвчин ужиграхад хүргэж байна.

#### АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. Жамъянжав Д. Лечение стафилококковой деструктивной пневмонии у детей. Автореф. дисс. канд. мед. наук. Улан-Батор. 1982 г.

2. Д. Малчинхүү Клинико-иммунологическая характеристика острой пневмонии у детей. Автореф. дисс. канд. мед. наук. Ленинград 1979 г.

Д. Малчинхүү, О роли бактериальной сенсибилизации в патогенезе острой пневмонии у детей. В кн: Актуальные вопросы педиатрии акушерства и гинекологии. Улан-Батор. 1980. с. 66—68.

4. Д. Малчинхүү, С. И. Смирнова, М. Г. Чухловина, Состояние клеточного иммунитета при острой пневмонии у детей. В кн: Иммунологическое исследование в клинике и эксперименте. Ленинград. 1981 г. с. 67—71.

Отклонение показателей иммунологических исследований при первичной стафилококковой пневмонии у детей

Проведено иммунологическое исследование 58 детям со стафилококковой пнев-

монией. В результате проведенного исследования выявлена зависимость тяжести течения стафилококковой пневмонии от нарушения клеточного и гуморального иммунитета (выражавшиеся в угнетении активности и количества Т-лимфоцитов в нарастании уровня ИгЖ, ИгА, титра антитела к токсину стафилококка в динамике болезни) и степени сенсибилизации к бактериальным аллергенам.

Гиперактивность Т-системы, повышение сенсибилизации к бактериальным аллергенам, низкий титр антитела к альфатоксигену стафилококка, незначительное нарастание уровня ИгЖ, ИгА сопровождались тяжелым, осложненным и затяжным течением болезни.

Хүлээн авсан 1990. V. 23.

## САХУУ, ТАТРАНГИЙН ЭСРЭГ НЭМЭЛТ ДАВТАН ВАКЦИНЖУУЛАЛТЫН ҮР ДҮН

С. Цоодол, Н. Цэнд (Эрүүл ахуй, халдвартай судлалын улсын институт)

Сахуу өвчний халдвартай судлалын төлөв байдал өөрчлөгдөж өвчлөл бүртгэгдээж, зарим суманд дэгдэл гарч эхэлсэн нь практик арга хэмжээнд тавих хяналт, шалгалтыг улам эрчимжүүлэх, уг өвчинээс сэргийлж арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагатай болгов.

Сахуу өвчний эсрэг дархлалын статусыг хүн амын янз бүрийн насыны бүлэгт тодорхойлсон байдлаас узэхэд хүүхдийн насы ахиж тутам өвчлөмгийг насыны хүүхэд, өсвөр үеийнхэн (8—16 нас), насандаа хүрэгчдэд сахуугийн эсрэг дархлалын түвшин эрс буурсан байв. Ийм нэхцэлд сахуугийн өвчлөлийг цаашид бууруулах, тархалтыг таслан зогсоохын тулд өвчилэлд илүү өртөмгийг насыны бүлгийн хүмүүсийн дархлалын түвшингээ болгино хугацааны дотор дэшшилүүлэх, үүний тулд сахуугийн эсрэг нэмэлт давтан вакцинуулалт явуулах арга хэмжээг гол тактик болгон сонгож хэрэгжүүлсэн юм.

Нэмэлт, давтан вакцинуулалтыг улсын хэмжээний 8—15 насыны бүх хүүхдэд (11 насандаа ээлжит давтан тарилт хийх тул оруулаагүй) урьд нь АКДС, АДС тарилгаар хэдэн удаа таригдсан, схемийн дагуу хийгдсэн эсэхийг ул харгалзан АДС—М хоргүйсүүрээр (0,5 мл-ээр) эхний ээлжиннд бүх сумдын, хоёрдуугаар ээлжиннд аймгийн төв, хотуудын хүүхдийг хамруулан 1 удаа тарьсан. Энэ арга хэмжээг тусгайлан гаргасан хүч болоцоого ашиглан зохион байгуулсан.

Нэмэлт, давтан вакцинуулалтад эдгээр насыны нийт хүүхдийн 85% орчим нь хамрагдаж, үлдсэн хэсэг нь янз бурийн шалтгаанаар тарилтаас хоцорсон.

Бид энэ судалгаанаар нэмэлт давтан вакцинуулалтад дархлал судлалын үр дүнг дүгнэх, цаашид өсвөр насыныханд давтан вакцинуулалт хийх схемийг боловсруулах үндэслэлийг гаргах зорилго тавьсан юм.

Судалгаанаар арга, материал Судалгааг явуулахлаа нэмэлт давтан вакцинуулалт хийснээс хойшид сарын дараа Хөвсгөл, Дорнод, Овхорхангай аймгийн тус бүр 2 сумын 8—15 насыны 189 хүүхдийн цусны ийлдсэнд сахуу, татрангийн эсрэг дархлалын түвшин хүчдэлийг тодорхойлж,

узүүлэлтийг нэмэлт, давтан вакцинуулалт хийхээс өмнө тодорхойлогдсон дархлалын узүүлэлтэй харьцуулж, хоорондын ялгааны үнэн магадтай стьюентын шалгуураар ( $t$ ) тодорхойлж дүгнэлт гаргасан. Сахуу татрангийн эсрэг дархлалыг тодорхойлох ийлдэс судлалын шинжилгээг энэ чиглэлээр бидний урьд хийж, хэвлэлд мэдээлсэн (1) аргаар явуулсан болно.

Үр дүн, шүүмж. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдэд тодорхойлогдсон сахуу, татрангийн эсрэг дархлалын узүүлэлтээс үзвэл (Нэгдүгээр хүснэгт) нэмэлт давтан вакцинуулалт хийсний дараа 8—15 насыны хүүхдийн 62,6—82,4 хувь нь сахуугаас хамгаалах дархлалтай болсон байгаагийн дотор 13—15 насыны хүүхдүүдэд хамгаалагдсан хувь хамгийн ондөр, 10 насандаа хамгийн бага байна. Ондөр таньцад (1:160 ба дээш) дархлалтай хүүхдийн хувийн жин мөн 13—15 насандаа хамгийн их (42,0—60,7%) байна.

Эндээс дүгнэж үзвэл нэмэлт давтан вакцинуулалт нь дархлал судлалын үүднээс үр ашигтай болсон дотор 13-аас дээш насыны хүүхдүүдэд илүү тод илэрч байна.



Дархлалын түвшин, хүчдэл хэрхэн өөрчлөгдсөн нь нэмэлт, давтан вакцинуулалт хийхээс өмнөх үеийн узүүлэлтэй харьцуулсан дүнгээс (1,2 дугаар зураг) тодорхой байна.

Нэгдүгээр зургаас үзэхэд нэмэлт давтан вакцинуулалт хийсний дараа 8—10 насыны хүүхдэд татрангийн эсрэг дархлалгүй хүүхэд 2 дахин буурч, хамгаалах таньцад дархлалтай хүүхдийн хувийн жин 3 дахин нэмэгдсэн байна. Гэтэл 12—13 насыны хүүхдэд зөвхөн ондөр таньцад дархлалтай хүүхдийн хувийн жин буурч, бусад өөрчлөлт нь статистикийн шалгуураар батлагдаагүй буюу бүхэлдээ насыны энэ бүлэгт давтан тарилт үр дүн муутай болсон нь харагдаж байна.

Дархлалын өөрчлөлтийн байдал 14—15 насыныханд хамгийн их ашигтайгаар өөрчлөгдсөн байна. Үнд дархлалгүй хүүхдийн хувийн жин 3 гаруй дахин багасч, ондөр таньцад дархлалтай хүүхдийн хувийн жин 2 дахин нэмэгдсэн нь ондөр магадлалтай батлагдаж байна.

**8—15 насны хүүхдэд сануу, татрангийн эсрэг нэмэлт, давтан вакцинуулалт  
хийсний дараах дархалын үзүүлэлт (АДС-м анатоксин)**

Hac (күнжээп)	Ulnijkirtcseh xlyxjannih 100	Санууний эсрэг биений танц						Татрангийн эсрэг биений танц														
		0			< 1 : 40			1 : 40—1 : 80			1 : 160 ба дээш			< 1 : 20			1 : 20—1 : 80					
		Doint too	%	±	Doint too	%	±	Doint too	%	±	Doint too	%	±	Doint too	%	±	Doint too	%	±			
8	28	5	17,8	7,2	3	10,7	5,8	10	35,7	9,0	10	35,7	9,0	6	21,4	7,7	10	35,7	9,0	12	42,8	9,3
9	30	6	20,0	7,3	4	13,3	6,1	11	36,6	8,7	9	39,2	8,9	9	30,0	8,3	11	36,6	8,7	10	33,3	8,6
10	24	7	29,1	9,2	2	8,3	5,6	6	25,0	8,8	9	37,5	9,8	6	25,0	8,8	10	41,6	10,0	8	33,3	9,6
12	32	9	28,1	7,9	3	9,3	5,1	7	21,8	7,2	13	40,6	8,6	11	34,3	8,3	9	28,1	7,9	12	37,5	8,5
13	30	4	13,3	6,1	2	6,6	4,5	7	23,3	7,7	17	,6	9,0	7	23,3	7,7	10	33,3	8,6	13	43,3	9,0
14	28	4	14,2	6,5	1	3,5	3,4	6	21,4	7,7	17	60,7	9,2	5	17,8	7,2	5	17,8	7,2	18	64,2	9,0
15	17	3	17,6	9,2	—	—	—	6	35,2	11,5	8	42,0	11,9	4	23,5	10,2	8	47,0	12,1	5	29,4	11,0



Хоёрдугаар зурагт үзүүлсэн сахүүгийн дархлалын эөрчлөлтийн ерөнхий хандлага ч дээрхтэй адил байна. Тухайлбал 8—10 насанд дархлалгүй хүүхдийн хувийн жин эрс багасч, хамгаалах болон өндөр таньцад дархлалтай хүүхдийн хувийн жин статистикийн хувьд үнэн магадтайгаар 2—5 дахин нэмэгдэжээ. Гэтэл 12—13 насны хүүхдэд өндөр таньцад дархлалтай хүүхдийн хувийн жин нэмэгдсэнээс бусад өөрчлөлт

нь статистикийн шалгуураар батлагдахгүй байна.

Нэмэлт, давтан вакцинуулалт 14—15 насны хүүхдүүдэд хамгийн ур ашигтай болсон нь давтац тарилгын дараа дархлалгүй хүүхдийн хувийн жин 5 дахин буурч, өндөр таньцад дархлалтай хүүхдийн хувийн жин 50 хувьд хүрсэнээс харагдаж байна.

## ДҮГНЭЛТ

1. Нэмэлт, давтан вакцинжуулалт явуулсан нь 8—15 наасны хүүхдийн сахуу, татаргийн эсрэг дархлалын түвшинг дээшлүүлэхэд ач холбогдолтой нь тогтоогдов. Ялангуяа сахуугаар өвчлэгсдийн наасны бүлэгт давамгайлах хандлагатай байгаа ёсвэр чийинхэнд (14—15 наасанд) дархлал судлалын үүднээс өндөр үр ашигтай арга хэмжээ боллоо гэж үзэж байна.

2. 12—13 наасны хүүхдийн дархлал судлалын үр дун сул байгаа нь 11 наасанд эзлжит давтан тарилт хийснээс хойш өнгөрсөн хугацаа бага (1—2 жил) дархлалын сурье түвшин харьцаангүй өндөр байсан нь нэмэлт, давтан тарилгын дархлал судлалын үр ашигт серөг нөлөө үзүүлснээс шалтгаалж байж болох юм.

3. Сахуу өвчний халдварт судлалын төлөв байдал хүрцдаж байгаатай холбогдуулж ёсвэр чийинхэнд нэмэлт вакцинжуулалт хийхээр АДС тарилгын схемд оруулах өөрчлөлтэд 14—15 наасанд хийхээр тусгах нь үр дүнтэй гэж үзэж байна.

## АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. С. Цоодол, Н. Цэнд, В. М. Болотовский, В. Ю. Крюков БНМАУ-ын хүн амд сахуу, татран өвчний эсрэг дархлал тогтоцыг судалсан урьдчилсан дун. Ана-таах ухаан 1988, №1, хуудас 18.

## ИММУНОЛОГИЧЕСКАЯ ЭФФЕКТИВНОСТЬ ДОПОЛНИТЕЛЬНОЙ РЕВАКЦИНАЦИИ ДЕТЕЙ АДС-М АНАТОКСИНОМ.

С. Цоодол, Н. Цэнд

Учитывая низкий уровень противодифтерийного иммунитета особенно у школьников при резком нарушении эпидемиологической обстановки дифтерийной инфекции, мы осуществили дополнительную всех детей страны в возрастах от 8 до 15 лет, независимо от их прививочного и иммунного статусов.

Сравнительное изучение величины противодифтерийного и противостолбячного иммунитетов до и после ревакцинации показало в целом высокую ее иммунологическую эффективность (Табл. 1). При этом процент лиц, имевших протективного уровня дифтерийного антитоксина увеличился до 62,6%—82,4% с самым высокие показателями у 13—15 летних.

Рис. 1 показывает, что у ревакцинированных в возрастах 8—10 лет удельный вес с защитными от дифтерии титрами вырос 3 раза, но у 12—13 летных статистически значимые сдвиги оказались лишь уменьшение доли детей с высокими титрами антитоксина. Таким образом, в данных возрастных группах дополнительная ревакцинация была малоэффективной.

Самая высокая иммунологическая эффективность наблюдалась у 14—15 летних. При этом процент незащищенных от дифтерии уменьшается более 5 раз, а доля лиц с высокими титрами у увеличивается до 50 процентов.

## ХҮҮХДИЙН ДУНД ЧИХНИЙ ИДЭЭТ ҮРЭВСЛИЙН ҮЕД ХЭНГЭРГИЙН БА ХЭНГЭРГИЙН АРЫН ӨӨРЧЛӨЛТИЙГ ОНОШЛОХ АСУУДАЛ

Б. Эрдэнэчuluun, Б. Оюун, А. Сайнжаргал (Эх хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах эрдэм шинжилгээний улсын нэгдсэн төв. Хотын клиникин төв эмнэлэг)

**Үдиртгал:** Хүүхдийн дунд чихний архаг идээт үрэвслийн үед дуу дамжуулах аппарат, хэнгэргийн агааржилтын байдалд гүнзгий өөрчлөлт үүссэнтэй холбоотойгоор сонсгол буурч, удаан хугацаагаар идээ (булаг) гоожло.

Дунд чихний архаг идээт үрэвслийн үед үүссэн бичил өөрчлөлтийг байрлалаар нь хэнгэргийн (хэнгэртэн хальс, хэнгэргэн хөндий, сонголын яснуудын), хэнгэргийн ар (гонхын хонгил, гонх-хөхөнчөрийн хөндий)-ын гэж ангилна (5).

Дунд чихний архаг идээт үрэвслийн эмчилгээний тавилан эдгээр өөрчлөлтийн хэмжээ, хэлбэр, шинж чанараас шууд шалтгаална. Сүүлийн үед хэнгэргийн ба хэнгэргийн арын өөрчлөлтийг хэнгэргийн

бичил дуран, компьютерт томографийн шинжилгээг ашиглан амжилттай оношлож байна. (1, 2, 8, 9).

Бид хэнгэргийн бичил дурандалт, компьютерт томографийн шинжилгээг үндэслэн дунд чихний архаг идээт үрэвслийн үед хэнгэргийн ба хэнгэргийн арын хэсэгт үүссэн бичил эмгэгийн бутгэц, хэлбэр, сонголын аппаратын байрлал, хэнгэргийн агааржилтын байдлыг тодорхойлох замаар чихний бичил мэс заслын заалт гаргах зорилт тавилаа.

### Аргазүй, материал:

а) ХБНГУ-ын «Sfort» нэгдэлд үйлдвэрлэсэн 30°, 70°, 90°-ын налуутай «Tumpraposcope Тур Wullstein» дурангт ашиглан хэнгэргийн ба хэнгэргийн арын хэсгийг

## Хэнгэрэгний шууд дурандалтаар илэрсэн хэнгэрэгийн өөрчлөлтүүд

Үндсэн өөрчлөлт		(С бүлэг) Цэвэрлэх мэс заслын заалтад хамарагдсан	(В бүлэг) Цэвэрлэх болон нөхөн сэлбэх мэс заслын заалтад хамарагдсан	А бүлэг Нөхөн сэлбэх мэс заслын заалтад хамарагдсан			
		тоо	хувь	тоо	хувь		
Хэнгэрэгн хальсны цоорынгийн үзүүлэлт	жижиг (3 мм хүртэл) дунд (8 мм хүртэл) том ба нилэнхүй	1 2 3	16,6 33,4 50	5 8 14	18,5 29,5 51,9	5 5 4	35,7 35,7 28,5
Хэнгэрэгн хальсны үзүүлэлт	хуурай, хөдөлгөөнтэй соривжиж хатуурсан Хавантай, улаан идээтэй, наалдацтай	— — 1 5	— — 16,6 83,4	6 1 16 1	22,2 3,7 59,3 14,8	13 1 —	92,8 7,2 —
Алх	бариул, богино сэргэн эрүүл бариул, богино сэргэн хавантай	1 5	16,6 83,4	20 7	74,0 26,0	14 —	100 —
Хэнгэрэгн хөндийн үзүүлэлт	ягаан, хуурай улаан, зузаандан идээтэй холестеотом мөхлөгтэй ДҮН	— — 1 5 6	— — 16,6 83,4	2 6 17 2 27	74,0 22,3 62,9 7,4	12 2 — 14	85,7 14,3 — —

дурандав. Хэнгэрэгийн бичил дурандалтыг шууд, арын гэж ангилав. 90°-ын налуутай хошуу ашиглан, хэсгийн мэдээ алдуулалттай хэнгэрэгийн шууд дурандалт хийж, хэнгэрэгийн өөрчлөлт (хэнгэрэгн хальсны үлдэгдэл, хэнгэрэгийн ёроол, алхны барил, хэнгэрэгийн дотор хана)-ийг тодорхойлов.

30°, 70°-ын налуутай дурангаар ерөнхий мэдээ алдуулалтын доор хэнгэрэгийн арын дурандалт хийж хэнгэрэгийн арын өөрчлөлт (дугуй цонх, дөшний урт сэргэн даш дөрөөний холбоо, хэнгэрэгийн арын ховил, хэнгэрэгийн дээвэр)-ийг ашиглаж Zhol дурангаар төхөөрөмжлэгдсэн «Olympus-40» аппаратаар 16—32 дахин өстөж, 70—140 мм-ийн зайнаас гэрэл зураг авав (6).

б) Компьютерт томографийн шинжилгээ (Япон улсын Hitachi пүүсэд үйлдвэрлэсэн III үеийн CT—W4 төхөөрөмж ашиглан)-г хэвтээ (аксиаль), босоо (коронари) хавтгайгаар стандарт «О» шугамаас 1—2 мм-ийн зузаантай 8—16 зүслэг хийж, хэнгэрэгн хальс, хэнгэрэгийн ёроол ба дээвэр, алх, даш, дөрөө, гонхны хонгил, гонх-хөхөнцөрийн хөндийн дүрслэлийг олон улсын батлагдсан нэгж  $\pm H$  (плотность)-ийг ашиглан тодорхойлов (3. 4. 7).

Хэнгэрэгийн бичил дурандалтаар илэрсэн өөрчлөлт, компьютерт томографийн дурслэлийн нэгжийг хоородд нь харьцуулан авч үзэв. Бид 1986—1989 онд ЭХЭМХЭШҮНТ-ийн чих, хамар хоолойн клиникт дунд чихний архаг идээт урэвслэлтэй 58 хүүхдэд хэнгэрэгний бичил дурандалт (үүний 47 нь шууд, 11 нь арын). 112 хүүхдэд компьютерт томографийн шинжилгээ хийж, хэнгэрэгийн ба хэнгэрэгийн арын өөрчлөлтийн байдлал хэмжээг харьцуулан тодорхойлж, бичил мэс заслын заалт гаргалaa.

Залт гаргаж байгаа үзүүлэлтийг дотор нь:

1. Цэвэрлэх мэс заслын (санирующий этап тимпанопластики)

II Цэвэрлэх нөхөн сэлбэх мэс заслын (одномоментная тимпанопластика)

III. Нөхөн сэлбэх мэс засал (пластиический этап тимпанопластики)-ын заалтад хамарагдах үзүүлэлтүүд гэж турван хувилбарт ялгав.

Судалгааны үр дүн:

I. Хэнгэрэгийн шууд дурандалт: 16 дахин өсгөж, хэнгэрэгн хальсны үлдэгдлийн ирмэг, өнгөц давхрын бүтэц эмгэг мэхлэг, шохойжилт наалдац, хэнгэрэгн хөндийн салст бүрхэвч, алхны барил, богино сэргэн

тэнгийн эрүүл, эмгэг байдлыг илрүүлж бичил мэс заслын заалтыг гаргав (Хүснэгт № 1-ээс үзнэ үү).

Түүнчлэн хэнгэргэн цагирагны бүтцийг тодорхойлсноор хэнгэргэн хальс суулгах мэс заслын ямар хувилбар сонгох боломжийг олгож байна.

2. Хэнгэргийн арын дурандалт: Чихний гадна сувгийн тэнхлэгээс  $30^{\circ}$ ,  $70^{\circ}$ -ын налууд дурангийн харах талбайн тусгалт ойдог учраас ердийн аргаар харах бололцотуй дугуй цохи, дэш-дөрөөний холбоо, хэнгэр арын ховилд байгаа эмгэг өөрчлөлтийг илрүүлж байгаагаараа давуу юм. Арын дурандалтын 21%-д хэнгэргэн хальсны цоорлолтоор атлаа хэнгэр ховил, хэнгэр ёроолд идээт-эмгэг мөхлөг илэрч, цэвэрлэх болон нөхөн сэлбэх мэс засал хийлтэсэн байна (Хүснэгт №2-оос үзнэ үү).

Эрүүл хэнгэргийн агааржилт: хэнгэргэн хөндийд  $-400\text{H}$ , гонхны хонгиид  $-150\text{H}$  гонхны хөндийд  $-500$ — $-600\text{H}$ -ээс дээш (агааржилт хэвийн) байна. Сонсголын яснууд  $+400\text{H}$ -аас  $+1360\text{H}$  хүртэл нягтралттай дурслэл өгч байна. Сонсголын ясны дурслэлийн хэмжээг (урт ба өргөн) нэг адил тодорхойлов. Эрүүл дурслэлийг үндэслэн дунд чихний архаг идээт үрэвслийн үед үүссэн хэнгэргийн арын өөрчлөлтийг хүснэгт №5, 6-д тодорхойлов.

Юуны өмнө хэнгэргийн агааржилт буурун. Агааржилтын бууралтыг хөөр (I II) төвшин болгон хуваав. Хэнгэргийн ёроол, дээвэр, гонхны хонгиид, гонх-хөхөнцөрийн хөндийн агааржилт нь  $+20\text{H}$  $+60\text{H}$  байвал агааржилтын бууралтын I төвшинд хамааруулсан бөгөөд ихэнхдээ идээт-мөхлөгт үрэвсэл байлаа. Эдгээр хэлбэрт чихний цэвэрлэх мэс засал хийллэ.

## Хүснэгт № 2

### Хэнгэрэгний арын дурандалтаар илэрсэн хэнгэргэн ба хэнгэргийн арын өөрчлөлтүүд

Үндсэн өөрчлөлтүүд		(С бүлэг) Цэвэрлэх мэс заслын заалтад хамаагааргдан		В бүлэг Цэвэрлэх болон нөхөн сэлбэх мэс заслын заалтад хамаагааргдан		А бүлэг Нөхөн сэлбэх мэс заслын заалтад хамаагааргдан	
		тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Хэнгэргийн хөндийн ёроол	цайвар ягаан улаан хөөнгө идээ, мөхлөг, хавантай	— 1 3	— 25% 75%	1 1 1	33,3% 33,3% 33,3%	4 — —	100% — —
Хэнгэргийн арын ховил	цайвар ягаан улаан хөөнгө идээ, мөхлөг	— 1 3	— 25% 75%	— 2 1	— 66,6% 33,4%	3 1	75% 25%
Дөрөөний холбоо	эрүүл идээ хавантай тасарсан тодорхойгүй	— 2 2	— 50% 50%	1 1	33,3% 33,3%	3 1	75% 75%
Гонхны хонгиидын бөглөө		3	75%	1	33,3%		
ДҮН		4		3		4	

3. Компьютерт томографийн шинжилгээ: Бид эрүүл хүүхдийн дунд чихний бүтцийн компьютерт томографийн дурслэл ( $\pm \text{H}$ ) болсоо зуслэгийн зузааны хэмжээ ( $\pm \text{mm}$ )-г тодорхойлов (Хүснэгт №3-аас үзнэ үү)

Компьютерт томографийн шинжилгээ тээр сонсголын аппаратын бүтэц, хэнгэргийн агааржилтын төвшинг тодорхойлов.

Хэнгэргийн агааржилт нь ( $-10 + 20\text{H}$ -ээс) хасах тал руугаа ихэссэн (II төвшин) хэнгэргэн хөндийд салслаг-зууралдсан ялгадас байсан ба цэвэрлэх нөхөн сэлбэх мэс засал хамтруулан хийв. Хэнгэргийн дурандалтаар илэрсэн өөрчлөлт нь компьютерт томографийн дурслэлтэй тохирч байлаа.

Компьютерт томографийн босоо зүслэгийн эзваан ( $\pm$  mm)

HAC	TOXONOMIAH 100	Хэнгэргэн хөндийн шар	Хэнгэргэн хөндийн дээвэр	Алх	Дөш				Дөрөө				Гонхны хонгил				Гонх хө- хөнгийн хөндий					
					M	$\pm m$	$\pm \eta$	M	$\pm m$	$\pm \eta$	M	$\pm m$	$\pm \eta$	M	$\pm m$	$\pm \eta$	M	$\pm m$	$\pm \eta$			
6—7	6	3,0	$\pm 1,4$	$\pm 1,4$	1,5	$\pm 3,5$	$\pm 1,0$	0,5	$\pm 1,4$	$\pm 2,5$	3,0	$\pm 1,4$	$\pm 2,0$	2,8	$\pm 0,9$	$\pm 1,7$	2,0	$\pm 1,4$	$\pm 1,4$	—	—	
8—9	11	—	—	3,0	$\pm 0,7$	$\pm 2,1$	4,7	$\pm 1,5$	$\pm 3,7$	3,7	$\pm 0,6$	$\pm 2,3$	2,83	$\pm 0,5$	$\pm 1,3$	—	—	—	8,5	$\pm 2,1$	9,3	$\pm 2,0$
10—11	31	4,0	$\pm 2,4$	$\pm 3,4$	4,2	$\pm 0,7$	$\pm 3,5$	5,00	$\pm 0,7$	$\pm 3,6$	3,5	$\pm 0,6$	$\pm 2,3$	3,5	$\pm 0,4$	$\pm 2,1$	3,0	$\pm 1,4$	$\pm 1,4$	6,0	$\pm 0,4$	
12—13	33	—	—	5,0	$\pm 0,7$	$\pm 3,4$	4,0	$\pm 0,7$	$\pm 3,4$	4,5	0,4	$\pm 2,7$	3,75	$\pm 0,6$	$\pm 2,$ 59	3,6	$\pm 0,7$	$\pm 1,5$	11,5	$\pm 2,4$	$\pm 2,1$	
14—15	90	4,9	$\pm 2,4$	$\pm 3,4$	5,0	$\pm 0,4$	$\pm 3,3$	3,6	$\pm 0,3$	$\pm 2,3$	4,67	$\pm 0,3$	$\pm 1,3$	3,45	$\pm 0,5$	$\pm 3,7$	3,3	$\pm 1,6$	$\pm 2,3$	11,0	$\pm 2,1$	
15-аас дээш	25	—	—	4,0	$\pm 0,7$	$\pm 3$	3,7	$\pm 0,8$	$\pm 3,2$	4,6	$\pm 0,4$	$\pm 2,1$	4,9	$\pm 0,9$	$\pm 3,1$	3,0	$\pm 1,4$	$\pm 1,4$	8,0	$\pm 0$	$\pm 0$	

Хүснэгт № 4

**Сонсголын эрүүл аппаратын компьютерт томографийн дүрслэл ( $\pm H$ )**

Сонсголын аппаратууд	Тохиол дол.	Дундаж үзүүлэлт		
		M	$\pm m$	$\pm \sigma$
Хэнгэргэн хальс	6	+99,8	$\pm 15,5$	$\pm 34,7$
Хэнгэргэн хөндийн ёроол	22	-409,7	$\pm 43,3$	$\pm 198,7$
Хэнгэргэн хөндийн дээвэр	22	-467,6	$\pm 50,3$	$\pm 231,2$
Алх	15	+761,0	$\pm 78,4$	$\pm 293,3$
Дөш	18	+923,8	$\pm 64,2$	$\pm 264,8$
Дөрөө	2	+447,0	$\pm 16,7$	$\pm 136,7$
Гонхны хонгил	2	-147,0	$\pm 26,8$	$\pm 26,8$
Гонх хөхөнцрийн хөндий	25	-546,4	$\pm 31,4$	$\pm 154,2$

Хүснэгт № 5

**Дунд чихний архаг идээт үрэвслийн үед цэвэрлэх мэс заслын өмнөх компьютерт томографийн дүрслэл  $\pm H$**

Сонсголын аппарат	Тохиол дол.	Дундаж үзүүлэлт		
		M	$\pm m$	$\pm \sigma$
Хэнгэргэн хальс	—	—	—	—
Хэнгэргэн хөндийн ёроол	27	-186,8	$\pm 20,1$	$\pm 102,6$
Хэнгэргэн хөндийн дээвэр	34	+16,6	$\pm 1,70$	$\pm 9,9$
Алх	15	+592,8	$\pm 62,9$	$\pm 235,6$
Дөш	22	+959,9	$\pm 53,9$	$\pm 247,0$
Дөрөө	3	+420,0	$\pm 15,9$	$\pm 222,7$
Гонхны хонгил	5	+65,6	$\pm 18,11$	$\pm 36,2$
Гонх-хөхөнцрийд хөндий	42	+76,7	$\pm 6,95$	$\pm 45,0$

Хүснэгт № 6

**Дунд чихний архаг идээт үрэвслийн үед цэвэрлэх, хэнгэргэн хальс суулгах мэс заслын өмнөх компьютерт томографийн дүрслэл**

		Дундаж үзүүлэлт		
		M	$\pm m$	$\pm \sigma$
Хэнгэргэн хальс	—	—	—	—
Хэнгэргэн хөндийн ёроол	73	-524,4	$\pm 39,4$	$\pm 336,7$
Хэнгэргэн хөндийн дээвэр	79	-364,4	$\pm 23,1$	$\pm 206,3$
Алх	62	+735,0	$\pm 44,3$	$\pm 349,2$
Дөш	63	+920,1	$\pm 46,9$	$\pm 372,3$
Дөрөө	10	+440,6	$\pm 83,3$	$\pm 250,1$
Гонхны хонгил	5	-132,8	$\pm 29,0$	$\pm 58,0$
Гонхны-хөхөнцрийн хөндий	94	-286,7	$\pm 17,1$	$\pm 166,7$

**ДҮГНЭЛТ**

маар бичил мэс заслын оновчтой заалт гаргах бүрдмэл арга юм.

- Хүүхдийн дунд чихний архаг идээт үрэвслийн үед хэнгэргийн (шууд ба арын) дурандалт хийж, илэрсэн өөрчлөлтийг компьютерт томографийн шинжилгээтэй харьцуулах нь хэнгэргийн ба хэнгэргийн арын бичил өөрчлөлтийн хэлбэр, хэмжээ, шинж чанарыг нарийвчлан тогтоож, ул-
- Компьютерт томографийн дүрслэлийг стандарт «0» шугамаас 1—2 мм зузаантай 6—8 зуслагээр бүтцийн 6,9 цэгт төвлөрүүлж, сонсголын аппаратын бүтэц, хэнгэргийн агааржилт гэсэн хөөр чиглэлээр судлах нь ашигтай байна.

## АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. Коновалов Н. А., В. Н. Корниенко Компьютерная томография в нейрохирургической клинике М. Медицина. — С. 7—19
2. Коссовой А. Л. Компьютерная томография и пространственная фильтрация изображения в диагностике заболеваний высокой кости. Вестн. оторинолар. 1985. — С. 77—80
3. С. В. Кузнецова, В. И. Апряткина Компьютерная томография в диагностике заболеваний среднего уха и высокой кости. Журн. уши, нос и горловых болезней. 1987. №5. — С. 51—54
4. С. В. Кузнецова, В. И. Апряткина —Компьютерная томография: особенности рентгеноанатомии высокой кости. Вестн. оторинолар. 1989. №4. — С. 66—69.
5. О. К. Патякина Блокада адитуса и тимпанального перешейка при хр. гн. сред. отитах. Журн. уши, нос и горл. бол. 1982. — С. 5—7.
6. М. С. Плужников, А. А. Усанов, Л. Н. Васин, Ю. А. Фролов Возможности применения особо тонких эндоскопов в оториноларингологии. Журн.—уши, нос и горл. боль. 1982. №2. — С. 34—37
7. Пресбраженскии Н. А. И. Х. Рабкин, В. Е. Добротин Компьютерная томография при оториноларингологических заболеваниях. В. кн. к зональной научно-практической конференции оториноларингологий и выездной научной ассамблеи МНИИ уха, горла и носа. Иркутск. 24—25 сентября 1987. М. 1987. — С. 91—92.
8. Köster O  
Di Hochauflösende Computer tomographie des Mittel- und Jnnenehoves Laryng. Rhinol otol 63 (1984) 488—492

9. Hittinger G. Kalendev W Computer-tomografie bei Erkrankungen des HNO-Beckens HNO (1981) 9. 364—369

## РЕЗЮМ

Проблема к диагностике тимпанальной и ретротимпанальной патологии при хроническим гнойным средним ститом у детей.

Б. Эрдэнэчулуун, Б. Оюун, А. Сайнжаргал Единственными методами, дифференциальной и топической диагностики, с помощью, которого можно увидеть тимпанальную и ретротимпанальную патологию являются компьютерная томография и тимпаноскопия.

Нами обследовано 170 детей. Всеми больными помимо отоскопии, аудиологических и традиционных рентгенологических исследований, выполняли компьютерную томографию на аксиальной и коронарной проекциях со срезом 1—2 мм шага и тимпаноскопию с микрофотографией.

При компьютерной томографии грануляции и холесстетомы отмечены изображение с плотностью от +20Н до +70Н, также снижена аэрозация тимпанального пространства от —20Н до 0Н.

Компьютерная томография и тимпаноскопия позволяют диагностировать многие патологические изменения в тимпанальной и ретротимпанальной области и уверены планировать адекватное лечение детей с заболеваниями среднего уха, что, в свою очередь способствует улучшению результатов их лечения.

## ЛИЗОЦИМИЙГ ХҮҮХДИЙН ТЭЖЭЭЛД ХЭРЭГЛЭХ БОЛОМЖ

Ч. Ишханд (Анагаах ухааны дээд сургууль)

Ш. Жадамбаа (Эх нялхсын эруул мэндийг хамгаалах  
эрдэм шинжилгээний хүрээлэн)

**Удиртгал.** Орчин үед эхийн сүүний биологийн үнэт чанарыг үндсэн бодисоор нь биш, хамгаалах үйл ажиллагаа бүхий биологийн идэвхт бодис агуулж байгаагаар нь үнэлж байна. Түүний нэг нь лизоцим юм. Хөхний сүүнд байгаа лизоцимийн хэмжээ үнээний сүүнийхээс даруй 300—3000 дахин илүү байдаг учраас 0—1 насны хүүхдийн тэжээлд өргөн хэрэглэдэг сүү, сүүн бүтээгдэхүүнийг лизоцимээр баяжуулах асуудлыг шийдвэрлэж байна.

Лизоцим нь гуравдагч бүтэцтэй өвөрмөц уураг бөгөөд бактерийн

эсийн бүтцэд оролцдог нийлмэл нүүрс усыг N—ацитилглюказамины 1,4-глюкозидын холбоогоор тасалж, ацетилмурамины хүчил үүсгэдэг учраас мурамидаз (фермент) гэж нэрлэдэг. Сүүлийн жилүүдэд нярай хүүхдийн билемахбодод лизоцимийн гүйцэтгэж байгаа үргийг нарийвчлан судалж билемахбодын өвөрмөц бус урвалж чанарыг идэвхжүүлдэг (Бухарин О. В (1974)) Сафонова Т. В. Афанасьева Т. И. (1981), нянтийн эсрэг үйлчилгээтэй Biscollottos (1961), сүүний уураг шингэхэд таатай нөлөө үзүүлдэг (Perlazzo E),

гэдэсний микрофлорын хэвийн үйл ажиллагааг нөхцөлүүлдэг (Аршавская Э. И.), вирусийн эсрэг нөлөө үзүүлдэг (Biscolattoc) болохыг тогтоожээ. Иймээс бид өөрийн орныхоо нөөц бололцоонд түшиглэн тахианы өндөгнөөс лизоцим бүхий хольц бэлтгэн туршсан нь зохих үр дүнгээ өгч байна.

**Судалгааны арга.** Тахианы өндгийг ариутгаж, угаагаад цагаан уургийг авч ферментэн гидролизод шатлан оруулах замаар лизоцим бүхий хольц бэлтгээд шар уургийг нь эмульсжуулэгч болгон наран цэцийн үснэ эмульс бэлтгэнэ.

**Судалгааны дүн.** Судалгааны үр дүнгээс үзэхэд 1:8 гэсэн шингэрүүлэлттэй лизоцимийн хольц *E. coli* стафилакоккийн өсөлтийг 1—1,2 цагт зогсоож байгаа бөгөөд тэжээлийн доройтол, сульдаатай хүүхдийн цусны иммуноглобулины түвшинг хэвийн хэмжээнд оруулж, хүүхдийн хоногийн дундаж жинг нэмэгдүүлж, сүүн хольц болон сүүний хүчлийн савханцар бүхий таргны (истэлэнг) хүчиллэгийг бууруулж, тааламжтай үнэр, амттай болгож байна. Ийм учраас судалгааг нарийгсан хүүхдийн тэжээлийн болон эмчилгээ сувилгааны зорилгоор бэлтгэж байгаа сүү, сүүн бүтээгдэхүүнийг лизоцимжуулах асуудлыг шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулах нь хойшилуулшгүй зорилт болж байна.

**Дүгнэлт 1.** Лизоцим бүхий хольц бэлтгэх нь аргын хувьд хялбар,

эдийн засгийн хувьд хямд, түүхий эдийн нөөц ихтэй юм.

2. Хүүхдийн сүүний үйлзвэрийг түшиглүүлэн лизоцим бэлтгэх жижиг цехийг байгуулах бололцоотой. 3. Эрдэм шинжилгээ туршилтын ажлыг эрчимжүүлэх нь чухал юм.

**АШИГЛАСАН ХЭВЛЭЛ** 1. А. К. Акатов и соавт. Лизоцим как критерий патогенности стафилококков. Журн. микробиол., эпидемол. и иммунобиологии 1979, № 9 с. 34—35.

2. Ч. Кантор, П. Шиммел Биофизическая химия Т-1 подред. А. А. Богданова, М., Мир, 1984. с. 34—35

3. Рахимова К. Р., А. И. Демидова. Углеводы и механизмы их усвоения Ташкент «Фан» УССР 1986 с 7—12.

4. Фатеев Е. М. Э. Г. Щербакова и др. Использование молочной смеси, обогащенной лизоцимом, при вскармливании новорожденных детей. Воп. охр. матер. и детст. № 6 1986 г 7—12.

#### ВОЗМОЖНОСТЬ ПРИМЕНЕНИЯ ЛИЗОЦИМНОЙ СМЕСИ ДЛЯ ПИТАНИЯ ДЕТЕЙ

Ч. Ишханд, Ш. Жадамбаа

Лизоцим в значительном количестве содержится в грудном молоке, который обладает выраженным антимикробным и антивирусным действием. Поэтому для обеспечения детей, лишенных материнского молока, полноценным питанием в настоящее время разрабатывают различные адаптированные смеси с биологическими активными веществами, среди них, лизоцимом.

В связи с этим мы приготовили лизоцимную смесь из яйчного белка путем ферментативного гидролиза.

Результат работы показал, что лизоцимная смесь положительно влияет на рост стафилококков и *E. coli* гибель их наступает в течение 1—1, 2ч. при разведений (полученной смеси) до 1:8.

# ЛЕКЦ, ТОЙМ, ЗӨВЛӨГӨӨ

## ХҮҮХДИЙН ХООЛ БОЛОВСРУУЛАХ ЭРХТЭНИЙ ЭМГЭГ СУДЛАЛЫН ТУЛГАМДСАН АСУУДЛУУД

Доц. Э. Лувсандагва, Ч. Өлзийбүрэн, Л. Н. Цветкова  
(Анагаах ухааны дэд эрдэмтэн)

Хүүхдийн хоол боловсруулах эрхтэний (ХБЭ) эмгэг судлал нь хүүхдийн өвчин судлалын шинжлэх ухааны нэг чухал хэсэг юм. ХБЭ-ний өвчин тархалт нь ЗХУ-ын яз сүрьеийн районд нэгэн түвшинд буюу 1000 хүүхдэд 80—100 тохиолдол байгаа бөгөөд ойрын 15—20 жилд дэлхийн хүн амын дунд 30—50% өсөх хандлагатай тогтоожээ. ЗХУ зэрэг оронд поликлиникин үзүүлэгсийн тоогоор энэ төрлийн эмгэгтүүд эмсгалын замын өвчиний дараа буюу 2-р байранд орж байна. Хүн амын өвчлөлийн бүтээд ихээхэн хувийг эзлэн, нийгмийн эдийн засагт тодорхой хохирол учруулж, дэлхийн олон оронд тархалт нь өсөх хандлагатай зэрэгээс шалтгаалан ХБЭ-ний эмгэгийн нарийн мэргэжлийн тусламжийг хөгжүүлэх, боловсронгуй болгохын чухал нь харагдаж байна. ЗХУ-д хүүхдэд үзүүлэх 8 төрлийн нарийн мэргэжлийн тусламжийн тоонд хүүхдийн ХБЭ-ний эмгэгийн төрөлжсөн тусламж зүй ёсоор ордог.

ХБЭ-ний эмгэгтүүд нь хүүхэд насанд эх үүсвэрээ олж, цаашид архагшин, насанд хүрэгсдийн өвчлөлд хүргэдэг нь тогтоогдсон тул эдгээр эмгэгийг эрт илрүүлэн, цаг тухайд нь эмчлэх, хянах нь насанд хүрэгсдийн өвчлөлөөс тодорхой хэмжээгээр урьдчилсан сэргийлэх, хөдөлмөрийн чадвар алдалтыг баагасах шийгэм-анаагаах ухааны ач холбогдолтой арга хэмжээ юм.

ХБЭ-ний эмгэг нь хүүхдийн эмч нарын анхарлыг эртнээс татаж байв. Манай зуучын эхний хагаст хүүхдийн өвчлөл, үхэлд зонхилох байр эзлэж байсан ходоод гэдээслийн хүрц халдварт өвчиний судлалд илүү автарч байсан бол эдгээр өвчиний тархалт бүурах чадварын бус гаралтай аргах эмгэгтүүдэд судлагчдын анхаарал төвлөрөх боллоо. Хүүхдийн анагаах ухааны практикт шинжилгээний орчин үеийн үр дүнтэй, оновчтой аргууд нэвтэрсэн явдал нь ХБЭ-ний урьд өмнө хүрч шинжилгэгүй байсан хэсгүүдийг судлах боломжийн нээж өглөө.

ХБЭ-ний архаг өвчинүүдийн тархалтыг судлаж үзэхэд уг системийн дээд хэсгийн эмгэг зонхилох байр эзэлж байна. Ходоод, дээд гэдэс хаймсуурдах нь эдгээр эрхтэний үйл-оношийн орчин үеийн аргуудын эхэлж байв. Энэ аргыг боловсронгуй болгосноор улаан хоолой, ходоод дээд гэдэсний дотосд орчны хүчил болон ферментийн идээхийн тодорхойлох, халуун хүйтэн хөдөлгөөн, даралтыг хэмжих зэргээр уг эрхтэнүүдийн үйл ажиллагааны олон хэмжигдэхүүнүүдийг судлах бололцоо бий болжээ. Эдгээр нь улаан хоолой, ходоод,

12 хуруу гэдсэнд бутцийн өөрчлөлт үүсэхээс өмнө үйл ажиллагааны алдагдлыг оношлох боломж олгохын зэрэгцээ эрүүл хүүхдийн ходоод шүүс-хүчил-фермент ялгаруулалтын хэвийн хэмжээг насны онцлогтой нь уялдуулан тогтоох судалгааны гол арга юм.

Саяхан болтол ХБЭ-ний дээд, доод хэсгийн болон цэсний замыг шинжлэх гол арга нь рентген шинжилгээ байв. Харин дуран шинжилгээ нэвтэрснээр ХБЭ-ийн эмгэг судлалын хөгжилд «гайхамшигт дэвшилт» болсон юм. Энэ аргыг зөв эзэмши, техникийн журмын дагуу хийхэд аюулгүй бөгөөд салст бүрхэвчийн байдал, олон тооны сфинктерийн үйл ажиллагааг нүдэр хараад зогсохгүй, салст бүрхэвчээр өчүүхэн жижиг хэсгийг авч гистологийн болон биохимийн аргаар шинжилж, эмгэгийн тархалт, өөрчлөлтийн үе шат, хэлбэр хэмжээг эсийн түвшинд тодорхойлох оношлолын онцгой ач холбогдолтойгос гадна, эмчилгээний үр дүнг бодитойгоор хяналтамгийн наидвартай арга болж байна. Уг шинжилгээний явцад ходоодны хучлийн байдлыг тодорхойлох боломжтой юм. ЗХУ-ын хүүхдийн анагаах ухааны практикт дуран шинжилгээний аргыг нярай, дутуу нярай (биийн жин 950 граммаас дээш үед) хүүхдэд хэрэглэж, нярай үед элбэг тохиолдог ХБЭ-ийн хөгжлийн гажиг болон бутц-үйл ажиллагааны хямралыг оношлох, эмгэгзүйт танин мэдэх, тайлбарлах, тухайлбал: улаан хоолой ходоод, ходоод дээд гэдэсний сфинктерийн бутц-үйл ажиллагааны төгс бус байдлыг оношлоход ашиглаж байна. Шинжилгээний энэ арга нь бугтийн өөрчлөлт бүхий олдмол өвчинүүд: үрэвсэл, шархлаа, хавдрыг эрт илрүүлээд зогсохгүй төрөлхийн гаралтай хөгжлийн гажгийг зөв оношлох, заримдаа уг эмгэгийн үед зайлшгүй хийж байсан мэс заслын эмчилгээний аргаас зайлсхийх боломжийг бий болгов. Улаан хоолайн эмгэгийг эрт илрүүлсэнэр өмнөнд хүргэлгүй эмчлэх боломж бий болжээ.

Хүүхдийн эмнэлгийн практикт дуран шинжилгээний зэрэгцээ хэт богино авианы шинжилгээ нэвтэрсэн нь элэг, цэс, нойр буличирхайн эмгэгүүдийн оношлолд онцгой ач холбогдолтой болов, ХБЭ-ийн яз бурийн хэсгийн эмгэгийн онцлог нь дангаар бие даан тохиолдох нь ховор, харин ойр орчмын, хил залгаа хэсгүүдийн өөрчлөлтэй хавсрان явагддагт оршино. Энэ нь эдгээр эрхтэний гарал үүсэл нэг, бутц-үйл ажиллагааны нягт уялдаа, цус, тунгалгийн

**Системийн бүлэг мэдрэл-шингэний зохицолгооны онцлогтой холбоотой.**

Орчин үед ХБЭ-ий эмгэгийн байршлыг ондоож төгссөн, шалтгааны олох, эмгэгээгийг тайлбарлах явдал онцгой анхаарал татаж байна. ХБЭ-ий эмгэгийн бүтцэл ходоод дээд гэдэсний хавсарсан үрэвэлт-тастродуудаас хамгийн олонтаа тохиолдолгог бол ходсод, дээд гэдэс болон улаан хоолойн дагнаас үрэвлүүд (гастрит, дуоденит, эзофагит), «харьцангуй» ховс болох нь ажиглагджээ. Ходоодны архаг үрэвсэл нь уг эрхтэний шархланы урдаач ижилцэл мөн эсэх нь шийлгэдээгүй асуудлын нэг болж байна. Ходоод, дээд гэдэсний ширхэлзээ нь (95%) дээд гэдэсний луковицийн хэсэгт 2/3 хувийн тохиолдолд олноор үүсэн байх бөгөөд цөөн тохиолдолыг уг эрхтэний аль нэг хэсэгт, ганц хөроор байрладаг болох нь тогтооглажээ. Дуран шинжилгээ нь ходоод, дээд гэдэсний ширхэлзээг эрт үлрүүлээд зогсохгүй, эмчилгээний түр дунг няавах хамгийн найдвартай арга юм.

ХБЭ-ий эмгэгүүдээс нойр булчирхайн эмгэг нь нээлээд бага судлагдсан хэсэгт орно. Нойр булчирхайн эмгэг нь дангаар тохиолдох нь ховор бөгөөд, элэг-цэсний замын болон дээд гэдэс-ходоодны эмгэгтүүдтэй хавсарсан байдлаа олонтаа тохиолдово. Ихээж хавсраад нэг талаас нойр булчирхайн эмгэгийн илрэх шинж тэмдэг бүрхэгддэг, нэгээ талаас уг эрхтэний бүтэц-үйл ажиллагааны алдагдлыг илрүүлэх шинжилгээний оновчтой арга дутагдалтай зэргийн улмаас уг эрхтэний эмгэг гүйцэтгэсэнд оношилгэдэгтүй байна. Нойр булчирхайн яз нийтийн бурийн гаралтай үрэвсэлт өвчинүүд элбэг тохиолдог боловч оношилгэдэгтүй удаан хугацаагаар явж архагшин, зэрэгдээх эрхтэний үрэвсэлт өөрчлөлтийг даамжууруулж, эдгэрэлтийг нь удаашруулах зэрэг муу талтай байдгыг харуулж байна. Нойр булчирхайн үйл ажиллагаа-бүтцийн өөрчлөлтийг илрүүлэх зорилгоор амилааз болон түүний изоферментүүдийн идэвхийг шус, шээсээд тодорхойлох, дээд гэдэсний шүүсийг бисхимиин аргаар, булчирхайг хэт богино авиаагаар шинжлэх аргыг анаагаах ухааны практикт хэрэглэж байна.

Элэг-цэсний замын архаг өвчинүүдийг судлах нь хүүхдийн ХБЭ-ий эмгэг судлалын чухал зорилтын нэг. Энэ системийн өвчиний оношлолд дээд гэдэсийг хаймын таднах, хураатуур судсан толотгогч болис тарьж, рентгенээр цэсний гэрийн зураг авах, элэгийн реографийн арга, радионизотопийн болон хэт богино авианы аргуудыг хэрэглэж байна. Хэт богино авианы арга нь хялбар, өвчтөний зүгтээс онцлын бэлтгэл шаардахгүй бөгөөд оношлох хучин чадал сайтайгаараа бусад аргаас давуутай. Цэсний гэр, замын үйл ажиллагааны хамралыг эрт үед, нь оношлох эмчлэх нь элэгний таднах цэсний зогсонахиши, цэсний гэрийн архаг үрэвсэл, чулуу зэрэг бүтцийн өөрчлөлт бүхий архаг өвчинүүдээс урьдчилан сэргийлэх гол арга болж байна.

Нарийн, будуун гэдэсний эмгэг нь хүүхдийн ХБЭ-ий эмгэгүүдээс харьцангуй бага судлагдсан бүлэг юм. Энэ нь рентген, шулзуун гэдэс дурандахаас өөр арга байх-

гүй байсантай холбоотой. Нарийн гэдэсний салст бүрхэвчийн шимэх үйл ажиллагааны хямралын хамшиникууд, тухайлбал: түүний удмын гаралтай хэлбэрийн гол төлөөлөгч-целиаки болон лактоз ферментийн дутмагшлын хамшинж нь шийдвэрлэгүй асуудлын иэг юм. Саяхан болтол бүдүүн гэдэсний эмгэгийн гол хэлбэр нь будуун гэдэсний өвөрмөц бус шархлаа. Кроны өвчин гэж узэж байв. Улс орон бурд үрэвслийн бусад хэлбэрүүдийг яз янзаар тайлбарладаг. Архаг явцтай өвөрмөц бус суултлагыг зарим оронд «будуун гэдэсний салстын цочролын хамшинж» гэж үздэг бол ЗХУ-д «нарийн, будуун гэдэсний халдварын дараах үрэвсэль (постинфекционный энтероколит) гэж тооцлог бөгөөд үүний үндэс нь салст бүрхэвч дэх тэжээл хямрал-үрэвслийн процесс юм. Энэ маргаантай асуудлыг дуран шинжилгээгээр нарийн-будуун гэдэсний дуран хүрэхүйц хэсгийн салстыг харах, биопси авч бүтэцүйл ажиллагааны хямралын шинж чанар, хэлбэр, тархалтыг тогтоосны үндсэн дээр шийдэх юм.

Манай оронд хүүхдийн ХБЭ-ий эмгэг судлалын хөгжил нь хүүхдийн өвчиний судлалын бусад салбарын түвшингөөс харьцангуй хоцрогдолтой байна. ЗХУ зэрэг орны судлагчдын тогтоосон нийгэм-анагаах ухааны хучин зүйлс, мөн тэдгээр оронд хүүхдийн ХБЭ-ий эмгэг судлалын салбарыг олсон амжилт зэрэгтэй тооцон, энэ салбарыг зохион байгуулалтын хувьд бэхжүүлэн, тодорхой төлөвлөгөө, зорилтой хөгжүүлэх хэрэгцээ гарч байна. Тухайн салбарын цаашдын ажиллагаанд нарийн мэргэжлийн боловсон хучний бэлтгэл зохих техник, тоног төхөөрөмж, шинжилгээний орчин үеийн хэрэгслүүдийн оновчтой сонголт ихэхээн ач холбогдолтой.

Онош эмчилгээ, урьдчилан сэргийлэх болон сувиллын газруудыг зөвөөр зохион байгуулах, судалгаанд шинжилгээний нэгдсэн аргазүйг хөвшүүлэх нь чухал юм. Манай орны нөхцөлд хэрэглэж байгаа ХБЭ-ий эмгэгийн оношлох аргуудыг боловсронгуй болгох, элбэг тохиолдож байгаа өвчинүүдийн шалтгаан-эмнэлзүйн оңцлогийг байгаль-цаг уурын өвөрмөц байдал, монгол хүүхдийн анатоми-физиологийн болон хоол тэжээлийн оңцлог зэрэгтэй уялдуулан судлах явдал шаардлагатай байна.

Онош эмчилгээ, хяналтын эрэмбээ дараа, шатчилсан байдлыг няйт няմбай баримтлах нь энэ төрлийн эмгэгтэй өвчтөнийг эмчлэн эдгэрүүлэх үндсэн нөхцөл болдог. Юуны өмнө Улаанбаатар хотын райондын ба аймгуудын хүүхдийн поликлиник, амбулаторийт гастроэнтерологийн кабинетийг, райондын ба аймгийн нэгдсэн, сум дундын эмнэлгүүдэд төрөлжсөн палат, хүүхдийн хоолны сувилал байгуулах, мэргэжилтнэр хангах ажлыг зохих журмын дагуу хийх нь эн тэргүүний зорилт болж байна. Нийслэл болон төвлөрсөн хотуудын хоолны сувиллын газрууд хүүхдэд зориулсан ширээг гарган үйлчлэх нь зүйтэй юм.

ХБЭ-ий архаг өвчиний идэвхтэй илрүүлэх зорилгоор нийтийг хамарсан урьд-

чилан сэргийлэх узлэгийг сургууль, цэцэрлэгээр зохион байгуулах, шаардлагатай хүүхдийг цаашид бүрэн шинжлэх, илэрсэн архаг өвчтэй хүүхдийг диспансерийн хяналтад авах, өвчний үе шат, хэлбэрт тохирсон эмчилгээг цаг алдалгүй хийх нь өвчлөлийг бууруулан, насанд хүргэсдийн ХБЭ-ий өвчлөлөөс урьдчилан сэргийлэх гол арга юм.

ХБЭ-ий эмгэгийн үүслийг нөхцөлдүүлдэг олон тооны «өгзэгтэй хүчин зүйлсийг» тооцоолж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг онолын үндэстэйгээр явуулж байх нь уг төрлийн эмгэгүүдээс сэргийлэх гол нөхцөл болдог. ХБЭ-ий өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, бууруулахын тулд шинжлэх ухааны үндэстэй зөв хооллох, явдал ний-

тийн анхаарлыг татаж байна. ЗХУ зэрэг орны эрүүлийг хамгаалах болон боловсрулын системийн практик ажиллагааны жишигээр сургуулиудыг цайны газартай болгох, хүүхдийн насын онцлог, цаг улирлын байдалд тохирсон чанар сайтай хоол ундаар үйлчлэх нь сургуулийн насын хүүхдийн хоол боловсруулах эрхтэний эмгэгээс урьдчилан сэргийлэхэд зайлшгүй хэрэгтэй Архаг өвчний үүсэлд хүргэдэг гол хүчинг зүйлсийн тоонд ХБЭ-ий хурц халдварт өвчинүүд: гэдэсний яз бүрийн гаралтай хурц халдвартууд, вирусийн гаралтай элэгийн хурц урвсэл зэрэг орно. Иймд эддээр өвчний өвчлөлийг бууруулах, өвчилвэл төгс эмчлэх, дараах үеийн хяналтыг зөв явуулах нь урьдчилан сэргийлэх арга хэмжээний салшгүй хэсэг юм.

### УЛААНБААТАР ХОТЫН НАСАНД ХҮРЭГЧДИЙН ГУУРСАН ХООЛОИН ТЭЛЭГДЭЛТИЙН ӨВЧЛӨЛ

Ш. Жигжидсүрэн Б. Гомбосүрэн

Сүүлийн жилүүдэд уушгины өвөрмөц биш архаг өвчинеөр (ҮӨБАӨ) өвчлөх нь гадаадын олон оронд мэдэгдэм ихсэх хандлагатай байна. (Н. В. Путов, В. Л.

Толузаков, Ю. Н. Левашов, 1984; Н. Р. Палеев, Л. Н. Царькова, А. И. Борохов, 1985; А. А. Бейсебаев, Л. И. Иоффе, 1982)

Манай оронд ҮӨБАӨ-өөр өвчлөх нь

Хүчинтэй I

Улаанбаатар хотын насанд хүрэгчдийн дунд ҮӨБАӨ-ний тархалт 1000 хүн амд  
(1989 оны байдлаар)

Насны бүлэг	ҮӨБАӨ 1000 хүн амд				Хүйс			
	Шинжийн шээдлийн орсон бүх хүн	Илэрсэн ҮӨБАӨ	1000 хүн амд ногдох ҮӨБАӨ (P±m)	P	Хүйс эр эм	ҮӨБАӨ	1000 хүн амд (P±m)	P
16—19	2197	127	57,8±4,9	—	эр 908 эм 1289	72 55	79,2±8,9 42,6±5,6	<0,00 05
20—29	4985	418	83,8±3,9	<0,0001	эр 1656 эм 3329	183 235	110,5±7,7 70,5±4,4	<0,00 01
30—39	3325	500	150,3±6,1	<0,0001	эр 1339 эм 1986	299 201	223,8±11,3 101,2±6,7	<0,00 01
40—49	1894	410	216,4±9,4	<0,0001	эр 784 эм 1110	227 183	289,5±16,1 164,8±11,1	<0,00 01
50—59	1851	445	240,4±9,9	>0,05	эр 780 эм 1071	221 224	283,3±16,1 209,1±12,4	<0,00 05
60-с дээш	2425	923	380,6±9,8	<0,0001	эр 1125 эм 1300	412 511	366,2±14,3 393,0±13,5	<0,00 05
БҮГД	16677	2823	169,2±2,9	—	эр 6592 эм 10085	1414 1409	214,5±5,0 139,7±3,4	<0,00 01

**Улаанбаатар хотын насанд хүрэгчдийн дунд ГХТӨ-ний тархалт үзлэгт хамрагдсан 1000 хүн амд  
(1999 оны байдлаар)**

Насны бүлэг	ГХТӨ 1000 хүн амд				Хүйс			
	илэрсэн УБАӨ	илэрсэн ГХТӨ	1000 хүн амд ногдох ГХТӨ (P ± m)	P	Хүйс эрэм	ГХТӨ	1000 хүн энэ ийн (P ± m)	P
16—19	2197	29,4	13,38 ± 2,4	—	эр 908 эм 1289	20 10	22,0 ± 4,8 7,75 ± 2,4	<0,01
20—29	4985	75,9	15,22 ± 1,7	> 0,05	эр 1656 эм 3329	42 33,6	25,3 ± 3,8 10,0 ± 1,7	<0,0005
30—39	3325	58,4	17,56 ± 2,2	> 0,05	эр 1339 эм 1986	30 27,4	22,4 ± 4,0 13,79 ± 2,6	> 0,05
40—49	1894	32,9	17,37 ± 3,0	> 0,05	эр 784 эм 1110	23 7,5	29,33 ± 6,0 6,75 ± 2,4	<0,0005
50—59	1851	29,4	15,88 ± 2,9	> 0,05	эр 780 эм 1071	21 11,5	26,9 ± 5,7 10,73 ± 3,1	<0,01
60-с дээш	2425	33,0	13,60 ± 2,3	> 0,05	эр 1125 эм 1300	16 17	14,22 ± 3,5 13,0 ± 3,1	> 0,05
бүгд	16677	25,9	15,33 ± 0,95	—	эр 6592 эм 10085	152 107	23,22 ± 1,8 10,02 ± 0,95	<0,0001

харьцангуй өндөр байгаа бөгөөд (Г. Цогт 1987, Е. Бодьхүү, Ц. Мухар, М. Т. Максимова, А. Г. Марченко, 1988) түүний дотор гуурсан хоолой тэлэгдэх өвчин (ГХТӨ) хөдөлмөрийн насны хүмүүст нэлээд элбэг тохиолдож тэдний хөдөлмөрийн чадварыг удаан хугацаагаар алдагдуулах, тахир дутуу болгох нь элбэг юм.

УБАӨ-ний дотор ГХТӨ нь ЗХУ-д 1,5—3,2 % (В. Н. Молотков, О. М. Иванюта, 1985) байхад манай пульмонологийн нэг тасагт хэвтэн эмчлүүлэгчдийн дотор 16,2% (А. Н. Лаптев, Ж. Цэрэсханд, Г. Цогт, Н. Түвшинбат 1987) эзэлж байна. Иймээс ГХТӨ-ний тархалтыг тогтоож, эмчилгээ оношлолыг боловсронгуй болгох нь цаг үеийн чухал асуудлын нэг болж байгаа учраас Улаанбаатар хотын насанд хүрэгчдийн дунд ГХТӨ-ний тархалтыг тогтоох оролдлого хийсэн юм.

Флюорографийн шинжилгэээр илэрсэн УБАӨ-тэй бүх хүмүүст бронхографийн шинжилгээ хийх боломжгүй байдал учраас ГХТӨ-ний тархалтыг үзэн зөвөөр тодорхойлох боломж хомс байдал. (Н. Р. Палеев, Н. Л. Царькова, А. И. Борохов 1985).

Улаанбаатар хотын насанд хүрэгчдийн дунд ГХТӨ-ний тархалтыг тогтоох судалгаанд орсон хүмүүсийг нас, хүйсийг харгалзан гурван үе шатаар судлав.

1. Флюорографийн шинжилгээнд орсон бүх хүний флюорограммыг мэргэжлийн (рентгений) эмчтэй хамтран үзүүлж УБАӨ-тэй хүмүүсийг илрүүлэн тогтоох, эдгээр хүмүүсээс ГХТӨ-г нь ялган авч хоёр дахь үе шатны судалгаанд оруулав.

2. Флюорографийн шинжилгээнд ГХТӨ-тэй гэж тогтоогдсон бүх хүмүүсийг судалгааны тусгай картын дагуу анамнезын аргаар дахин тодотгож үзэхэд тодорхой тооны хүмүүст ГХТӨ илрээгүй болно.

3. Флюорографийг анамнезын аргатай хослуулан судлаад ГХТӨ-тэй тодорхой тооны хүнд бронхографийн шинжилгээг түүвэрлэн хийж, онош нь бүрэн батлагдсан хүндээ статистикийн боловсруулалт хийх замаар тархалтыг тогтоов.

Флюорографийн шинжилгээнд бүгд 16677 хүн орсноос 2823 (169,2 ± 2,9%) хүн УБАӨ-тэй гэж тогтоогдсоноос эрэгтэй 1414 (214,5 ± 5,0%), эмэгтэй 1409 (139,7 ± 3,4%) буюу эрэгтэй нь эмэгтэй-гээсээ 1,5 дахин илүү өвчилж байна ( $P <$

Улаанбаатар хотын насанд хүрэгчдэд илэрсэн УӨБАӨ-ний дотор  
ГХТӨ-ний эзлэх хувь. УӨБАӨ илэрсэн 1000 хүнд.  
(1989 оны байдлаар)

Насны өвлийн хүчин үеийн нээлтэдийн ГХТӨ-ийн ногдох ГХТӨ (P ± m)	1000 УӨБАӨ-д ногдох ГХТӨ				ХҮЙС			
	УӨБАӨ-ийн ногдох ГХТӨ (P ± m)	1000 УӨБАӨ-д ногдох ГХТӨ (P ± m)	P	ХҮЙС эрэм ээр эм	ГХТӨ	1000 УӨБАӨ хүнд (P ± m)	P	
16—19	127	29,4	231,5 ± 37,4	—	эр 72 эм 55	20 10	277,7 ± 52,7 181,8 ± 52,0	>0,05
20—29	418	75,9	181,5 ± 18,8	>0,05	эр 183 эм 235	42 33,6	229,5 ± 31,0 142,9 ± 22,8	<0,05
30—39	500	58,4	116,8 ± 14,3	<0,05	эр 299 эм 201	30 27,4	100,3 ± 17,3 136,3 ± 24,2	>0,05
40—49	410	32,9	80,2 ± 13,4	>0,05	эр 277 эм 183	28 7,5	101,3 ± 20,0 40,9 ± 14,6	<0,05
50—59	445	29,4	66,0 ± 11,7	>0,05	эр 221 эм 224	21 11,5	95 ± 19,7 51,3 ± 14,7	>0,05
60-с ээш	923	33,0	35,7 ± 6,1	<0,05	эр 412 эм 511	16 17	38,8 ± 9,5 33,2 ± 7,9	>0,05
БҮГД	2823	259	91,7 ± 5,4	—	эр 1414 эм 1409	152 107	107,4 ± 8,2 75,9 ± 7,0	<0,001

0,0001) (1-р хүснэгт). Нас ахих тутамд УӨБАӨ-ний илрэлт нэмэгдэж байв ( $V_{xy} = 0,98$ ), ( $P < 0,0001$ ).

Флюорографийн шинжилгээгээр УӨБАӨ-тэй гарсан 2823 хүнээс 415-д ГХТӨ тогтоогдож эдгээр хүмүүсийг анамнезын аргаар дахин судлахад 323 хүнд ГХТӨ батлагдаж, 92 хүнд угүйсгэгдэв.

Флюорографийг ачамнезийн аргатай хослуулан судалсаны дунд ГХТӨ-тэй нь батлагдсан 323 хүний нас, хүйсийг нь хартгалзан 76 (23,5%) -д бронхограммын шинжилгээ хийхэд 61 (80,2%) -д нь ГХТӨ буурэн батлагдсан болно. ГХТӨ-тэй байвал зохих хүний тоо эхний хоёр аргаар батлагдсан бүх хүний 259 буюу 80,2%-ийг өзөлж байна.

ГХТӨ-ний тархалтыг тогтоох зорилгоор 3 уе цагтаар судалгаа явуулахад 259 (15,33 ± 0,95%) хүнд ГХТӨ батлагдав. Үүнээс эрэгтэй 152 (23,22 ± 1,8%), эмэгтэй

107 (10,02 ± 0,95%) буюу эрэгтэй нь эмэгтэйгээс 2,3 дахин илүү олон ( $P < 0,0001$ ) байна. (хүснэгт 2) ГХТӨ-өөр өвчлөх нь насны бүлэгтэй ямар нэг холбогдолгүй  $V_{xy}=0,05$ , ( $P > 0,05$ ) байна.

УӨБАӨ-тэй 2823 хүнээс 259 (91,7 ± 5,4%)-д ГХТӨ тогтоогдов. Үүнээс эрэгтэй 152 (107,4 ± 8,2%), эмэгтэй 107 (75,9 ± 7,0%) байв. (Хүснэгт 3).

ГХТӨ-ний тархалтыг тогтоох 3 аргыг хооронд нь харьцуулан аль арга нь илүү давуутайг тогтоов. ГХТӨ-ийг илрүүлэхэд флюорографийн аргыг анамрезын аргатай хослуулан хэрэглэх нь дан ганц флюорографийн аргаар судлахаас үнэхээр давуутай сайн арга болох нь батлагдаж байна. ( $X^2=963,5$ ), ( $P < 0,0001$ ). Энэ 2 аргыг зөв сайн хэрэглэвэл ач холбогдолсороо бронхографийн шинжилгээний аргад ойртолж ( $X^2=0,21$ ), ( $P > 0,05$ ) байна.

**Улаанбаатар хотын насанд хүрэгчдэд илэрсэн УӨБАӨ-ний дотор  
ГХТӨ-ний эзлэх хувь. УӨБАӨ илэрсэн 1000 хүнд.  
(1989 оны байдлаар)**

насны бүлэг	1000 УӨБАӨ-д ногдох ГХТӨ				Хүйс			
	илэрсэн УӨБАӨ	илэрсэн ГХТӨ <sup>②</sup>	1000 УӨБАӨ-д өвлий ГХТӨ (P ± m)	P	Хүйс эр эм	ГХТӨ	1000 УӨБАӨ хүнд (P ± m)	P
16—19	127	29,4	231,5 ± 37,4	—	эр 72 эм 55	20 10	277,7 ± 52,7 181,8 ± 52,0	> 0,05
20—29	418	75,9	181,5 ± 18,8	> 0,05	эр 183 эм 235	42 33,6	229,5 ± 31,0 142,9 ± 22,8	< 0,05
30—39	500	58,4	116,8 ± 14,3	< 0,05	эр 299 эм 201	30 27,4	100,3 ± 17,3 136,3 ± 24,2	> 0,05
40—49	410	32,9	80,2 ± 13,4	> 0,05	эр 277 эм 183	23 7,5	101,3 ± 20,0 40,9 ± 14,6	< 0,05
50—59	445	29,4	66,0 ± 11,7	> 0,05	эр 221 эм 224	21 11,5	95 ± 19,7 51,3 ± 14,7	> 0,05
60-с 9 эш	923	33,0	35,7 ± 6,1	< 0,05	эр 412 эм 511	16 17	38,8 ± 9,5 33,2 ± 7,9	> 0,05
БҮГД	2823	259	91,7 ± 5,4	—	эр 1414 эм 1409	152 107	107,4 ± 8,2 75,9 ± 7,0	< 0,001

0,0001) (1-р хүснэгт) Нас ахих тутам УӨБАӨ-ний илрэлт нэмэгдэж байв ( $V_{xy} = 0,98$ , ( $P < 0,0001$ )).

Флюорографийн шинжилгээгээр УӨБАӨ-тэй гарсан 2823 хүнээс 415-д ГХТӨ тогтоогдож өдгээр хумуусийг анамнезын аргаар дахин судлахад 323 хүнд ГХТӨ батлагдаж, 92 хүнд угсгэгдэв.

Флюорографийн анамнезийн аргатай хослуулан судалсан дунд ГХТӨ-тэй нь батлагдсан 323 хүний нас, хүйсийг нь харгалзан 76 (23,5%)-д бронхограммын шинжилгээ хийхэд 61 (80,2%)-д нь ГХТӨ бүрэн батлагдсан болно. ГХТӨ-тэй байвал зохих хүний тоо эхний хоёр аргаар батлагдсан бүх хүний 259 буюу 80,2%-ийг зөвлж байна.

ГХТӨ-ний тархалтыг тогтоох зорилгоор 3 уе шатаар судалгаа явуулахад 259 ( $15,33 \pm 0,95\%$ ) хүнд ГХТӨ батлагдав. Үүнээс эрэгтэй 152 ( $23,22 \pm 1,8\%$ ), эмэгтэй

107 ( $10,02 \pm 0,95\%$ ) буюу эрэгтэй нь эмэгтэйгээсээ 2,3 дахин илүү олон ( $P < 0,0001$ ) байна. (хүснэгт 2) ГХТӨ-өөр өвчлөх нь насны бүлэгтэй ямар нэг холбогдолгүй  $V_{xy}=0,05$ ), ( $P > 0,05$ ) байна.

УӨБАӨ-тэй 2823 хүнээс 259 ( $91,7 \pm 5,4\%$ )-д ГХТӨ тогтоогдов. Үүнээс эрэгтэй 152 ( $107,4 \pm 8,2\%$ ), эмэгтэй 107 ( $75,9 \pm 7,0\%$ ) байв. (Хүснэгт 3).

ГХТӨ-ний тархалтыг тогтоох 3 аргыг хооронд нь харьцуулан аль арга нь илүү давуутайг тогтоов. ГХТӨ-ийг илрүүлэхэд флюорографийн аргыг анамнезын аргатай хослуулан хэрэглэх нь дан ганц флюорографийн аргаар судлахаас унзхээр давуутай сайн арга болох нь батлагдаж байна. ( $X^2=963,5$ ), ( $P < 0,0001$ ). Энэ 2 аргыг зөв сайн хэрэглэвэл ач холбогдолоороо бронхографийн шинжилгээний аргад ойртож ( $X^2=0,21$ ), ( $P > 0,05$ ) байна.

## БӨӨРНИЙ ТҮҮДГЭНЦЭРИЙН ҮРЭВСЛИЙН ШАЛТГААНЫГ СУДЛАХ АСУУДАЛД

Ц. Цэцэгмаа (*АУДС-ийн аспирант*)

Сүүлийн жилүүдэд хүүхэд залуучууд, хөдөлмөрийн насын хүмүүсийн (ихэвчлэн эрэгтэйчүүдийн) дунд бөөрний түүдгэнцэрийн үрэвсэл (БТҮ) улам ихсэх хандлагатай болж сургуулиас завсардах, хөдөлмөрийн чадвар алдалт, эндэгдлийн гол шалтгааны нэг болсон нь эмч, судлагчдын анхаарлыг ихээхэн татах боллоо.

БТҮ-1963 онд 10000 хүнд 11,2 тохиолдож байсан бол 1976 онд 14,8 болж (5, 16, 21) 1986 оны байдлаар 4130 хүүхдийн 12,3%-д уг эмгэг илэрсний зэрэгцээ (9), БТҮ-тэй өвчтөний 86% нь залуучууд, дунд хирийн насын хүмүүст (28) тохиолдож, сүүлийн үед настай хүмүүс ч өвчлөх болжээ (10).

Улаанбаатар хотын хүүхдийн клиникин төв эмнэлэгт 1965—1969 онд хэвтэж эмчлүүлсэн бөөрний эмгэгтэй хүүхдийн 67,5% (26), 1974—1979 онд 61,8% нь БТҮ-тэй (3) байжээ. 1985 оны БНМАУ-ын хүн амын өвчлөлийн судалгаагаар БТҮ, хавагнах хам шинжийн хамт бөөр, шээс, бэлгийн замын өвчиний дотор 34,5%-г эзэлж байгаа нь уг өвчин манайд ихээхэн элбэг тохиолдож байгааг гэрчилж байна.

Ийнхүү элбэг тохиолдог БТҮ нь бүрэн төгс эмчилгээгүй, бөөрний архаг дутмагшлын (БАД) үндсэн шалтгааны нэг болдог (15, 17). БТҮ-ийн ямар хэлбэр байгаагаас хамааран 2—20 жилийн дотор БАД-үүсдэг (13) бөгөөд БАДын 50% нь БТҮ-тэй холбоотой гэж (11) үзэж байна.

Сүүлийн жилүүдэд БТҮ-ийн эмгэг жамын эмчилгээг бүрэн шийдэх боломжгүйт харгалзан уг эмгэгийг үүсгэх шалтгааныг судлаж урьдчилан сэргийлэх арга замыг эрж хайх нь зүйтэй гэж 1986 оны Бүх холбоотын нефрологчдын III их хурал, 1986 оны социалист орнуудын хүүхдийн эмч нефрологч нарын IV их хурал, мөн 1987 оны Бүх хол-

боотын дотрын эмч нарын XIX их хурлаас үзжээ.

БТҮ нь халдварт харшлын гаралтай бөгөөд үүсгэдэг шалтгаанаас нь хамааруулан түүнийг халдварын ба халдварын бус гаралтай гэж хоёр хуваадаг.

Халдварын гаралтай БТҮ-г үүсгэгч гол шалтгаанд цус задлах стрептококк (А булэг), стафилакокк, пневмококк болон бусад микробуудаар үүсдэг архаг голомтот халдварууд болох гүйлсэн булчирхайн архаг үрэвсэл, шуд хорхойтох өвчин, арьсны идээт үрэвслүүд, амьсгалын дээд замын үрэвсэлт өвчнүүд, буглаа, дунд чихний архаг идээт үрэвсэл зэрэг өвчнүүд зонхилох хувийг эзэлдэг (14, 7, 11, 24, 26, 29, 30).

Энэхүү архаг голомтот халдваруудаар өвчилснөөс хойш 7—21 хоногийн дараа БТҮ үүсдэг.

Ер нь янз бүрийн халдварууд нь БТҮ-г үүсгэх шалтгааны 90 гаруй хувийг эзэлдэг (4).

Вьетнамд БТҮ-н 56,8% нь арьсны идээт өвчинөөр, 28,6% нь чих хамар хоолойн архаг голомтот өвчинөөр (11), Москвад 32% нь амьсгалын дээд замын үрэвслээр, 18% нь гүйлсэн булчирхайн үрэвслээр (7), Ленинградад 59,6% нь архаг голомтой халдвараар, (4), Карагандад 33,3% нь гүйлсэн булчирхайн хурц архаг үрэвслээр (24) тус тус үүсчээ. Үүнээс үзэхэд БТҮ-г үүсгэх янз бүрийн халдварууд харилцан адилгүй байгаа нь ажиглагдаж байна. Манайд 1973 онд БТҮ-тэй 150 хүүхдэд хийсэн судалгаанаас (26) үзэхэд 13,3% нь гүйлсэн булчирхайн хурц, 23,9% нь архаг үрэвслэлтэй, 27,3% нь шуд цоорох өвчтэй байжээ. Энэ нь халдварын гаралтай БТҮ манайд ямар байгааг эргэж харах шаардлага байгааг харуулж байна.

БТҮ үүсэхэд вирусийн гаралтай халдварууд (халдварт шар, салхин

цэцэг, улаанбурхан, гахай хавдар гэх мэт) ихээхэн нөлөөлдөг (24,23). БТҮ-тэй 162 хүүхдийн 2/3 нь амьсгалын дээд замын вирусын гаралтай өвчинтэй байжээ (24). 1973 онд манайд хийсэн судалгаагаар БТҮ-тэй 150 хүүхдийн 27% нь салхин цэцгээр өвчилсны улмаас бөөрний эмгэгт өртжээ (26,27).

БТҮ нь сурьеэ, тэмбүү зэрэг халдварт өвчний уед илрэхийн зэрэгцээ Шенлейн Генохын өвчний уед хавсран тохиолддог, БТҮ-ийн шалтгааны 17%-ийг халдварт өвчин эзэлж байна (7). 1973 онд БТҮ-тэй 150 хүүхдийн 1,3% нь Шенлейн Генохын өвчин гаралтай байжээ (27). Тэгтэл 1967 онд Шенлейн Генохын өвчин Улсын хүүхдийн клиникин эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн хүүхдийн 0,34%-г эзлэж байсан бол 1987 онд 2,6% болтлоо өсчээ (25). Үүнээс үүдэн Шенлейн Генохын өвчин БТҮ үүсэхэд хэрхэн нөлөөлж байгааг тогтоох асуудал зүй ёсоор шаардагдаж байна.

Өнөөдөр манайд халдварт шар, сурьеэ, тэмбүү зэрэг халдварт өвчнүүд буурахгүй байгаа нь БТҮ үүсэхэд ямар нэг хэмжээгээр нөлөөлж байна гэдэг нь эргэлзээгүй.

БТҮ-ийн 10% орчим нь тухайлбал цус, сийвэн юулэх, урьдчилан сэргийлэх тарилга хийхэд болон төрөл бурийн харшлын үед үүсдэг.

БТҮ-ийн 7% нь янз бурийн харшилтай (7), 2% нь вакцин хийлгэсэнтэй холбоотой (4) үүсдэг. Мөн төрөл бурийн хордлого, архи уух, тамхи татах, бөөр шээсний замын төрөлхийн гажиг хөгжил, бие галбир, удамшлын шалтгаантай холбоотой БТҮ үүсдэг (18, 2, 19).

Бөөрний эмгэгтэй 805 хүүхдийн 33% нь БТҮ байнсны гуравны хээр нь бөөр шээсний замын эрхтэний, 4% нь бөөрний судасны гажиг хөгжилтэй байжээ (6). 1986 онд Ленинградын хэсэг судлагчид (19) 112 өрхийг удмын зургаад нь судлаж үзэхэд БТҮ-тэй 87 хүүхэд илэрсний 25 нь хүүхдийн эцэг, эх, төрөл, төрөгсөд нь БТҮ-тэй байжээ. ЗХУ, БНАГУ, БНСЧСУ, БНУАУ, БНМАУ-ын сүүлийн 10 жилд явуулсан хамтарсан судалгаагаар

(8) БТҮ-н удамшлын шалтгааныг нарийвчлан судлах шаардлагатай байгаа нь тогтоогджээ.

БТҮ үүсэхэд төрөлтийн болон эмэгтэйчүүдийн эмгэгүүд нэлээд нөлөөтэй (12). Манай оронд энэхүү эмгэгүүд БТҮ үүсэхэд хэрхэн нөлөөлж байгаа нь одоогоор судлагдаагүй байна. Гэвч амьдралд өргөн тохиолддог дээр дурдсан халдварт болон халдварт бус шалтгаануудын нөлөөгөөр хүн бүр БТҮ-ээр өвддөггүй. Энэ нь юуны түрүүнд хувь хүний ажил амьдралын нөхцөл, нас, хүйсний онцлог, биений эсэргүүцэл, мэдрэх чадвараас хамаардаг. Тухайлбал хэтэрхий даарах нь БТҮ-н шалтгааны 12,2%-ийг эзэлдэг (4). БТҮ-ээр эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 2—3 дахин их өвчилдөг (21, 22, 28).

В. К. Серкова, Т. Ф. Мазур болон бусад судлагчдын (20) үзсэнээр БТҮ-тэй 300 хүний 20% нь мэргэжлийн хортой нөлөөнөөс (хэт даарах 65%, доргион 15%, удаан хугацаагаар зогсож ажилласнаас 6%) болж уг эмгэг үүсчээ.

Цаг уур, газарзүйн янз бурийн бүсэнд орших 17 мянган хүүхдэд эпидемиологийн судалгаа хийж үзэхэд дунд болон нам уулын бүс, тал газар, үйлдвэрийн районд амьдардаг хүүхдүүдэд бөөрний эмгэг илүүтэй тохиолдож байна (1).

Нөгөө талаар бөөрний түүдгэн-цэрийн хурц үрэвслийн (БТХҮ) 50% нь архаг хэлбэрт шилжиж хөдөлмөрийн чадвар алдалтын болон зидэгдлийн нэг шалтгаан болдог (22). БТХҮ-ээр өвдөөд насанд хүрсэн хүн 1 жилийн турш (хүүхэд 2 жилийн турш) хавагнан, цусны даралт нь ихсэж, шээсээр уураг (1 г/л дээш) ялгарч байвал архаг хэлбэрт шилжлээ гэж үздэг (22)..

БТХҮ архагших нь өвчний эхлэл явц, эмнэлзүйн хэлбэр, өвчин үүсгэгчийн хоруу чанар, хурц үеийн эмчилгээний үр дүн, дэглэм сакилт зэрэг олон шалтгаанаас хамаардаг. БТХҮ-г архагшуулах шалтгаан майд одоогоор судлагдаагүй байна.

Эрс тэс уур амьсгалтай, хангай, говь, тал хээр хосолсон өргөн, уудам нутагтай, хот хөдөөгийн хүмүүсийн амьдралын нөхцөл ихээхэн

ялгаатай манай орны хувьд БТУ-ийн шалтгаан, түүнийг архагшуулах хүчин зүйлийг судлан урьдчилан сэргийлэх оновчтой арга боловсруулах асуудал эрүүлийг хамгаалахын тулгамдсан зорилтын нэг болж байна.

### АШИГЛАСАН ХЭВЛЭЛ.

1. Д. В. Албегова, Е. Г. Темуриди. Эпидемиология и картограммы распространенности нефропатии в различных климато-географических регионах В кн: Тезисы докладов IV симпозиума педиатров-нефрологов социалистических стран. -Москва, 1986. с. 3.

2. У. Б. Балтаев, Б. Г. Тусупкалиев — Распространенность структура болезней мочевой системы у детей г. Актюбинска. В кн: Тезисы докладов IV симпозиума педиатров-нефрологов социалистических стран. -Москва, 1986, с. 4.

3. О. В. Виноградский Принципы профилактики и диспансеризации больных с заболеваниями почек. Всесоюзный съезд нефрологов 3-й: Тезисы докладов. Киев, 1986, Т. 1., С 16.

4. Басоиш Батмухийн. К характеристике диффузного гломерулонефрита у детей г. УБ. в процессе динамического наблюдения и лечения: Дис. канд. мед. наук. УБ, 1979, с. 4—60.

5. В. Г. Григорьев, К. И. Журавлева, С. И. Рябов. К организация этапной специализированной помощи нефрологическим больным Сов. мед. 1977. № 11, с. 123—126.

6. Э. М. Дегтярёва, В. В. Фокеева, О. Ю. Турпятко. Значение факторов предрасположенности в развитии гломерулонефрита у детей Всесоюзный съезд нефрологов, 3-й: Тезисы докладов-Киев 1986, Т. 1, с. 78.

7. А. А. Ефимова, С. Э. Шляхтина, В. П. Непомнящий и др. Эпидемиология болезней мочевой системы среди детского населения СССР. В кн: Тезисы докладов IV симпозиума педиатров-нефрологов социалистических стран. -Москва, 1986, с. 6—7.

8. М. С. Игнатова (СССР), П. Гросман (ГДР) О. Павковчикова (ЧССР), М. Мельтения и Д. Шулер (ВНР), Э. Лувсандаагва (МНР). Проблемы и перспективы научных исследований по детской нефрологии в ряде стран социалистического содружества. В. Кн: Тезисы докладов IV симпозиума педиатров-нефрологов социалистических стран. М. 1986, с. 7.

9. С. М. Кабулова, Х. Д. Аминов Распространенность наследственных и врожденных нефропатий по данным массового обследования детей города Душанбе. Всесоюзный съезд нефрологов, 3-й: Тезисы докладов. -Киев, 1986. Т. 1. с. 27.

10. О. П. Кузнецова, П. А. Воробьев, Л. И. Дворецкий и др. Лечение острого гломерулонефрита у лиц пожилого возраста. Тер. арх. 1987. № 8. с. 128—130.

11. Ле-Нам-Ча, Чан-Динь-Лонг, Дан-Нгуэт-Бинь. Течение и исход нефропатии по данным центрального института охраны здоровья детей Вьетнама в периоды 1974—1978 и 1981—1984 годы.

В кн: Тезисы докладов IV симпозиума педиатров-нефрологов социалистических стран. -Москва, 1986, с. 52.

12. И. И. Логвинова. Математическая оценка факторов риска возникновения заболеваний почек у детей. Всесоюзный съезд нефрологов, 3-й: Тезисы докладов. Киев, 1986. Т. I, с. 100.

13. В. И. Наумова, И. Н. Потапова, М. М. Исаева. Выживаемость детей больных хроническим гломерулонефритом, в зависимости от клинико-морфологических проявлений. Всесоюзный съезд нефрологов. 3-й: Тезисы докладов, Киев, 1986, Т. 1. с. 38—39.

14. А. П. Пелещук Практическая нефрология. Киев, 1974.

15. М. Я. Ратнер, В. В. Серов, В. А. Варшавский и др. Клинические и морфологические предикторы прогрессирования хронического гломерулонефрита Тер. арх. 1989, № 6, с. 14—18.

16. К. И. Рябов. Болезни почек Л., 1982. 427 с.

17. Н. Е. Савченко, В. С. Пилотович. Лечение больных хроническим гломерулонефритом в стадии почечной недостаточности В кн: Нефриты. Серия Медицины, 1982, № 11, с. 40—55.

18. В. П. Смуррова, А. В. Папаян, В. И. Лисатова и др. Диспансеризация детей из семей с нефропатиями. В кн: Тезисы докладов IV симпозиума педиатров-нефрологов социалистических стран, Москва 1986, с. 13.

19. А. П. Серга, А. В. Папаян, В. П. Смуррова. Изучение семей, где имеются больные гломерулонефритом. Всесоюзный съезд нефрологов, 3-й: Тезисы докладов. Киев, 1986. Т. 1, с. 123.

20. В. К. Серкова, Т. Ф. Мазур, Н. И. Пилявская и др. Влияние некоторых факторов риска на течение гломерулонефрита. Всесоюзный съезд нефрологов. 3-й: Тезисы докладов. Киев, 1986, Т. 1. Киев, 1986, С. 122—123.

21. Е. М. Тареев Хронический гломерулонефрит, В кн: Основы нефрология под, ред. Е. М. Тареева. М. 1972, с. 350—404.

22. Е. М. Тареев. Клиническая нефрология. М., 1983, т. 1, 413 с.

23. Р. Г. Фидимонова, -Е. Г. Невраева, З. Г. Апросина. Инфекция вирусом гепатита. В как возможный фактор риска развития гломерулонефрита. Всесоюзный съезд нефрологов, 3-й: Тезисы докладов. Киев, 1986, Т. т. с. 135

24. В. А. Цай, Н. Е. Подгайная, И. А. Егорова. Факторы риска, заболеваний почек у детей. Всесоюзный съезд нефрологов. 3-й: Тезисы докладов. Киев, 1986, Т. 1. С. 137.

25. Д. Цэдэнбал, Д. Алтанцэцэг. Хүүхдийн судасны цусархалт үрэвслийн тар-

- халт, эмнэлзүйн зарим асуудал, АУДЭС-ийн багш нарын эрдэм шинжилгээний 31-р бага хурлын илтгэлийн хураангуй УБ. 1989. хууд. 151—153.
26. Цэдэнбал Дүгэржавын: Некоторые клинико-биохимические особенности течения острого диффузного гломерулонефрита у детей в Монголии. Дис. канд. мед. наук., -Л., 1973. с. 178.
27. Д. Цэдэнбал. Хүүхдийн гломерулонефрит. УБ 1980. 150 х.
28. Г. П. Шульцев, Н. И. Гилунова, Л. И. Кроткова Клиническая оценка структуры гломерулонефрита. XIX Всесоюзный съезд терапевтов: Тезисы докладов. Москва, 1987, с. 421—422.
29. Glassocr. R. J. Immunologic mechanisms of Renal Disease (Eds C. B. Nilson, B. M. Brenner, J. H. Stein Newyork 1979. p 255—322
30. Heptinstall R. H. Pathology of the kidney (ED. R. H. Heptinstall-Boston) 1983. vol I, p 479—518

## УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААН

МОНГОЛ АНАГААХ УХААНЫ ХИЙ, ШАР, БАДГАНЫ  
ТУХАЙ УХАГДАХАУНЫГ ТАЙЛБАРЛАХ АСУУДАЛД

М. Амбага

Энэтхэг, төвд зэрэг дорчо дахинь орны анагаах ухаанаас уламжлан, монгол анагаах ухааны гол тулгуур онол болон баяжсаар ирсэн «хий, шар, бадганы» тухай ухагдахууны мөн чанарыг зөв тайлбарлан ухаарах нь олон талын чухал ач холбогдолтой билээ. Сүүлийн жилүүдэд энэ асуудлаар гадаад, дотоодын олон судлагч, ажиглагчид сонирхолтой санаа дэвшүүлсэн нь бий (4,5,22).

Дээрхи судлагчдын санаа бодлыг анхааран хүлээн авахын хамт зарим нэг дутагдалтай талыг дурдвал:

1. Хий, шар, бадганы ухагдахууныг орчин үеийн анагаах ухааны ангилал ойлголтой юм уу, ямар нэг тодорхой химийн бодисын үйлчлэлтэй шууд тулган холбогхыг оролдсон; 2. Хий, шар, бадганы өөр хоорондын харилцан нягт уялдаат байдлыг алдагдуулан, хэт салгаж сарнимал байдлаар тайлбарласан нь бүхэлдээ энэ асуудлаар судалгааны нэгдмэл аргачлал, үзэл баримтлал бий болж чадаагүйтэй холбоотой юм.

Бид мочгол анагаах ухааны сурвалж материалд тулгуурлан хий, шар, бадганы (Х.Ш.Б.) мөн чанарыг тогтоох судалгаа, аргачлалын холбогдолтой нийтлэг асуудалл доорх үндсэн зарчмыг баримтлах нь зүйлэй болов уу хэмээн үзэж байна.

1. Хий, шар, бадгана нь бүтцийн нэг ерөнхий байгууламжинд шутэн байрласан үйл ажиллагааны харилцан адилгүй хэлбэр, илрэл буюу «бүтэц-үйл ажиллагааны нийлмэл цогц» болох уг цогц нь гадаад, дотоод орчин, улирал, цаг уурын нөлөөг хүлээн авч хариу өгөх, даган өөрчлөгдөх, дасан зохицохын хамт өөр хоорондоо нягт холбоотой, харилцан бие биедээ хувирсан шилжих чадвартай уян хатан, динамик процесс гэдгийг нэн тэргүүнд анхаарах.

2. Х.Ш.Б.-ны ухагдахуун нь амьд билемхбодын гадаад, дотоод орчны харилцан

үйлчлэлийн ерөнхий хийгээд өвөрмөц тал хандлагыг харуулсан түгээмэл ухагдахуун болохын хувьд тэдгээрийн бодит тусгал мөн чанар нь тухайлсан нэг бүтцийн нэгж болох амьд эсээс авахуулаад бүхэл бүтэн билемхбодын түвшинд илэрдэг зүй тогтолцой байх эстий гэдэг зарчмыг баримтлах нь зүйтэй. Иймээс бид Х.Ш.Б.-ын бүх талын мөн чанарыг илэрхийлж чадах тийм «бүтэц-үйл ажиллагааны» түгээмэл тогтолцоо бол билемхбодын нийт эсүүдийн мембранных багтаасан бүхэл бүтэн «байгууламж» байж болох тухай санааг дэвшүүлж байна. Бид асуудлыг ингэж тавихдаа тусгайлсан нэг эсийн мембранны хэлээгүй бөгөөд харин мембранийн байгууламжгүй нэг ч эс байдалгүй, мембранны зохицуулгагүйээр явагддаг нэг ч эрүүл, эмтэг процесс угүй. аливаа эд, эс нь мембранны бүтэц, найрлага, рецептор, ферментийн цогц, тэнд явагдах физиологийн процессын эрчим, чиг хандлагаасаа л хамаарч өөр хоорондоо эрс ялгагддаг болон мембранийн «гадаад орчин-эс» «эс-эс» гэсэн мэдээллийг хүлээн авч нэгтгэж зөөн дамжуулах, энергиэр хангах бүтцийн найдваагтай байгууламж болдог өвөрмөц чанарыг анхааран тусгасан юм (8.10.12.17.20.21.24).

Эсийн мембранны бүтцийн хэсгүүдийн дотроос тэнд явагдах биологи биофизикийн процесст шууд нөлөөлөн (17) гадаад орчны (температур, даралт, чийглэг, хоол тэжээлийн найрлага) нөлөөг мэдэрч дасан зохицоц өвөрмөц уян хатан чадвар бүхий бодис бол өөхөн тосны бодис юм (12). Эсийн мембранны байгууламжид өөхний бодис нь үндсэн хоёр хэлбэрээр буюу тосны ханасан, ханаагүй хүчлийч байдлаар орших бөгөөд уг хүчлийн тооши харьцаа нь мембранны нягт эзлэхүүн, жин, уян хатан, чанар, урсамтгай чанар-хөдөлгөөн, ферментийн идэвх, «хатуу-шишгэн» төлөв, хайлах царцах температур зэрэг амин чу-

хал шинж чанарыг нөхцөлдүүлнэ (20). Өөрөөр хэлбэл мембрани тосны ханасан, ханаагүй хүчлүүдийн тооны ялимгүй боловч өөрчлөлт нь харилцан эсэрэг тэсрэг төлөв байдалд хүргэнэ (20, 24). Эсийн мембрани хоёрч давхаргад тосны хүчлүүд нь хатуу нягт-эмх цэгтэй, эсвэл шингэн буюу няятаршил султай хоёр төлөв байдалд орших бөгөөд нэгдүгээр нь транс-конфигурацитай, хоёрдугаар нь гош-конфигурацитай холбоотой буюу тосны ханасан хүчлүүд өөр хоорондоо амархан харилцан үйлчлэлцэж няятарснаар хатуу төлөвийг (хатуу мембрани) үүсгэдэг бол тосны ханаагүй хүчлийн хоёрчийн холбоо нь тосны хүчлийн дэс дараалал, няятрылыг сулруулж сийрэгжүүлэх учир шингэн буюу уян хатан чанартай төлөвийг (уян хатан мембран) үүсгэнэ (20). Хэвийн нөхцөлд мембрани тосны ханасан, ханаагүй хүчлийн зөв зохиристой тоон харьцаатай байгаагаас нөхцөлдөн хэт хатуу, хэт зөөлөн бус төлөв байдалд оршиж, тэнд ферментийн урвал, физиологийн процесс хэвийн явагдах нөхцөлийг бурдуулж бөгөөд эрхтэн бүр эсийн мембрандлаа дээрхи хүчлүүдийг харилцан адилгүй тооны харьцаатай агуулдаг нь ойлгомжтой (7, 12, 20).

Судалгааны дээрхи материал дээр үндэслэн хий, шар, бадганааны эсийн мембрантай байгууламжтай холбогдол хий (лун) хэмээх ойлголтын дор физиологи үндэс нь ионы дамжуулалт, физик төлөв нь мембрани хатуу-шингэн байдлын зохиристой харьцаа, биохимийн үндэс нь мембрани даах тосны ханасан-ханаагүй хүчлийн тоон харьцаагаар нөхцөлдөн, эсийн мембрани сэрэмтгийн чанараар гадаад илрэлээ олсон үйл ажиллагааны олон талт үзэгдлийг хэлж болох байна.

Шар нь: мембрантай байгууламжийн шингэн төлөв тосны хоёрч давхрага даах ханаагүй хүчлийн, бадганааны түүний хатуу төлөвтэй холбоотой буюу тосны ханасан хүчлийн шинж чанараар нөхцөлдөн явагддаг процесс болох тухай төсөөлөл мөн бий болж байна. Учир нь мембрани хатуу-шингэн төлөв нь тухайн эрхтэн, эсийн амин чухал фермент, уураг, рецепторийн буюу эсийн үйл ажиллагааны эрчимжилтийн түвшинд шууд нөлөөлөн зохицуулдаг зүй тогтолцоюүд юм (20, 24). ХШБ-ны өөр хоорондын харилцан уялдаат байдал, тухайлбал хий нь арга, билэг (халуун-хүйтэн) тэгш чанартай буюу бадганааны шарын дунд оршиж, тэдгээрийн аль алинаас хамааран өөрчлөгдөх эргээд нөлөөлөх зохицуулгатай тухай ардын эмнэлгийн ухагдахуун нь (9) бидний дэвшүүлсэн шинэ санаанд хий нь мембрантай байгууламжийн хатуу (бадганааны) шингэн (шар) төлөв, тосны хүчлийн ханасан, ханаагүй холбооны тооны тэгш харьцаанаас нөхцөлдөнэ гэсэн томъёоллоор бүрэн тусгагдаж чадаж байгаагаараа бусад судлаачдын дэвшүүлсэн санаанаас (4, 6, 22) илүү давуу талтай юм.

ХШБ-ыг мембрани байгууламжтай холбон тайлбарлах гэсэн бидний төсөөлөлт хэр зэргийн үнэний үндэстэй байх нь ХШБ-ны тухай монгол анагаах ухааны онол, практикийн олон хүрээт асуудлыг энэ дагуу

хэр зөв зохиристой, голыг нь олж тайлбарлах чадаж байгаагаас харагдах ёстой. Нэг зүйлийг зориуд тодруулан хэлэхэд амьд биенеахбодын мембрантай байгууламжийн бүтцийг өөх тосны бодисор төлөөлүүлэн ийнхүү үзүүлж байгаа нь уураг, нүүрс ус, бичил элемент зэрэг мембрани бүтцийн бусад чухал хэсгүүдийн гол ач холбогдлыг угүйгэн орхиждуулж байгаа хэрэг огт биш бөгөөд тэдгээр нь дангаар болон өөхний бодистой нэгдэл үүсгэсэн байдаар зохицуултын үүргээ гүйцэтгэх нь мэдээж юм.

Мембрани бүтцийн эх бие (матрица) болж, бусад бодисууд түүнтэй холбогдон, үйл ажиллагаагаа явуулдгийн хувьд нь өөх тосны бодисы нэлээд тодорхой байдлаар харуулахын оролдов.

Ингэж хэлэхийн өөр нэг үндэслэл бол эсийн мембрани өөхний бодис хэт нээлдэн задарч, эс гэмтэж, ухжих нь аль ч эрхтэн, эсийн түвшинд илрэдэг түгээмэл зүй тогтолцоу өмгэгт процесс гэдгээс урган гарч байна (5, 7, 10).

Бид юуны өмнө хүн амьтны биеийн бүх эрхтэн эсийг сэрэмтгийн чанар мембрани шингэн, хатуу төлөвт орших тосны ханасан, ханаагүй хүчлийн тоо, чачарын онцлог, ялгарах байдлыг нь харгалзан ангилах оролдлого хийсэн юм. Үнд:

— эсийн мембрани сэрэмтгийн чанар ондортай буюу «хийн» төрх амархан илрэдэг эрхтнүүд (зурх, тархи г. м.)  
— эсийн мембрани шингэн төлөв голлосон ханаагүй хүчлүүдийг харьцаангуй их агуулсан (зөөлөн мембрантай) шар голдуу илрэх эрхтэн (элэг, цэс, гэдэс, өөхний эд)

— эсийн мембрани хатуу төлөв давамгайлан тосны ханасан хүчил харьцаангуй их агуулсан (хатуу мембрантай) бадганааны голлосон эрхтнүүд (ходоод, дэлүү, уушги)

Ингэж ангилсаны дагуу ХШБ-ын тухай Монгол анагаах ухааны онол-практикийн гол гол үзэл баримтлалыг тус тусад нь тайлбарлах оролдлого хийе.

1. Хий, шар, бадганааны билэг чанар, тэдгээрийн харилцан уялдаат байдал хийгээд биенеахбодын мембрани байгууламж  
«..Шар, бадганааны хоёулаа бол шар халуун чанартай, бадганааны хүйтэн чанартай эсэрэг тэсрэг байдалтай байхад, хий нь тэр хоёрын дунд халуун-хүйтэн хоёулаанд нь тушиж хоёрдмог чанартай байна. Ерөндэгийн үүднээс хэлбэл шар арвitsныг дарах эм (ерөндөг) усан махбодтой, бадганааны арвitsныг дарах эм гал махбодтой эсэрэг тэсрэг гал, ус байх болно».

Гурван махбодыг (ХШБ) тус тусын билэг чанарын үүднээс авч үзвэл: бадганааны хүйтэн шарын халуунтai, бадганааны хүнд шарын хөнгөнтэй, бадганааны мохдог нь шарын хүртгай бадганааны хүйтэн чанартай тослогын шарын халуун чанартай тослогтой тус тус харилцан эсэргүүцэх харилцаатай байх тут хүний бие цогцост бадганааны шар хоёр харилцан эсэрэг, тэсрэг харьцаатай оршино.

Хийн билэг чанарын бүрэлдэхүүнийг шар, бадганааны хоёрын билэг чанартай харьцаулж үзвэл хийн хөнгөн, бадганааны хүндтэй

Эсрэг боловч шарын хөнгөнтэй нэгдэж, хийн сэруүн нь шарын халуунтай Эсрэг боловч бадганы хүйтэнтэй нэгдэж, хийн ширүүн нь бадганды тослогтой эсрэг боловч шарын халуунхаа хатаах, хуурах, болгох үйлдэлтэй нэгдэж, хийн хөлбөрөнхийн бадгана, шартай Эсэргүүцэлдэх нэгдэх хоёр талт чанарыг илтгэж байх тул хий махбод бол хоёрдомон чанартай юм. Шар, бадгана хоёр эсэргүүцэлдэхээ харилцан түшиглэж, харилцан хязгаарлаж байдаг. Эсэргүүцэлдэх байх нь шар, бадгана хоёрын аль нэг тал боловч нөгөө талаасаа ангижирч, тусгай оршиж чадахгүй. Халуунгүй бол хүйтэнгүй, шар галын илч болж галын үйлийг үйлдэж байхад бадгана түүний эсрэг усны үйлийг үйлдэж, шарын халуун нь бадганды хүйтнийг хэтэрхий дээшлэхийг хязгаарлан, бадганды хүйтэн нь шарын халуун хэтэрхий дээшлэхийг хязгаагралах мэтээр харилцан хязгаарлаж байх тул хэвийн үед аль нэг нь хэтэрхий дээшлэх, дорийтох угүй тэнцвэртэй байдаг,,, хэмээжээ (3.9).

Шар багданы харилцан түшиглэх хийгээд харилцан эсргүүцэх чанарын талаарх зэдгээр зүйл нь мембранийн байгууламжинд тосны ханаасан, ханаагүй хучлүүд харилцан шүтлэцээтэй оршиж мембранийн хэвийн төлвийг үсгэздэг тухай дээр бидний өгүүлсэнтэй тохирох байдал харагдаж байна.

ХШБ-ны билиг чанарын бүтээгдэхүүний тухай Монгол анагаах ухааны ухагдахууныг мембранийн байгууламжтай холбосон байдлаар өнгөт харахад гэнэн мэт боловч цаанаа гүн үндэслэлтэй байж болох дүгнэлт хийж болох юм. Бадгана, шар хоёулаа тослог билиг чанартай. Гэхдээ шгрын тослог нь халуун, бадганы тослог нь хүйтэн чанартай гэсэн нь шар бадгана хоёулаа «тосны бодистой» (ханасан, ханаагүй хүчил) нарийн шүтэлцэстэйг харуулах бөгөөд шарын тослог халуун. Бадгандын тослог хүйтэн гэдэг нь тосны ханаагүй хүчлиүүдийн хайлах температур  $+15 - +18^{\circ}\text{C}$  буюу халуун чанартай, ханасан хүчлүүд  $+53^{\circ}\text{C} - +69^{\circ}\text{C}$ -т хайлдаг буюу тэлдээр нь гагцхуу ханаагүй хүчилдээ уусч байж бодисын солилцоонд (11) оролцдог харьцаангуй «хүйтэн» чанартай гэж хэлж болох хүйц байдал харагддаг. Энэ нь ерөөсөө шар, халуун, бадгана хүйтэн билиг чанартай гэдэгт ч мөн нэгэн адил хамаатай юм. Гадаад орчны температурыг  $38^{\circ}\text{C}$ -аас дэш болгоход мембрани зөвхөн шингэн уелбэр (ханаагүй хүчил) үлддэг.  $12^{\circ}\text{C}$ -аас баагасх уел хатуу уелбэр (ханасан хүчил) үлддэг,  $12^{\circ}\text{C} - 33^{\circ}\text{C}$ -д хоёул тэнцүү оршидог тэсэн нь ч (24) дээрхитэй шууд холбоотой юм.

Шар хөнгөн бадгана хүнд билиг чанартай тухайд бол мембраний байгууламжинд тосны хүчлийн ханасан холбоо ихэсэх тутам мембранийг тогточ, хувийн нягтгэж (жин) нь ихэсдэг, ханаагүй холбоо олшироход мембранийг сэвсийж, нягт нь суурин, хөнгөрдөг тухай материалыг дурьдаж болно (24).

но (24). А. Шарын хурц, бадганды мохдог билиг чанарын тухайд бол тосны ханаагүй хүчлүүд (шар) нь ханасан хүчлээ бодвол урвалдах залрах чадвараараа хэдэн арав дахин их

байдагтай холбоотой байж болох юм. Элэг буюу бидний ангиллаар мембррандаа тосны ханаагүй хүчлүүдийг зонхилон агуулдаг шарын оронд оршдог эрхтэнд, дэлүү, ушиги, ходоод зэрэг багдан голлосон (мембррандаа ханасан хүчил голдуу) эрхтнээс өөхний хэт исэлдэлтийн ( $\Theta\text{ХИП}$ ) хэвийн түвшин харьцаангуй их байдгийг бусдын (14.15.16) болон өөрсдийн ажиглалт дээр тулгуурлан үнэмшилтэй үзүүлж болох юм. Тухайлбал: бидний судалгаагаар цагаан хулгана, цагаан харханд хүчтэй исэлдүүлэгч бодис болох  $\text{CCL}_4$ -ийг тарихад дэлүүний эдэд  $\Theta\text{ХИП}$ -ийн бүтээгдэхүүн диений конъюгатийн концентраци үхвийн үеийнхээс 1,2 малондиальдегид 1,2, шифрийн суурийн концентрация 19 дахин нэмэгдэж байсан бол элэгний эдэд хэвийн үеийнхээс диений конъюгат 2,4, малондиальдегид 1,6, шифрийн суурь 3,2 дахин буюу элэгний эдэд дэлүүний эдээс өөхний хэт исэлдэлтийн эрчим бараг 2—3 дахин их байгаа нь элгэнд хэт исэлдэн урвалдах чанартай тосны бодисууд (ханаагүй хүчил) хавьгүй илүү байгааг харуулах бөгөөд ийм  $\Theta\text{ХИП}$ , хэт исэлдэлтийн бүтээгдэхүүн, язгуурүүд нь өөр хоорондоо урвалдах, рекомбинацид орох явцдаа хэт сүл гэрэл, квант, дулаан ялгаруулдаг онцлогтой нь (5, 10) гэсэн Монгол анагаах ухааны онцлой тохирно (9).

Бид яз бүрийн эрхтний эсийн мөмбраныг хатуу шинчээн улсбэр байдал, ханасан, ханаагүй тосны хүчлийн алиных нь тоо дийлэнхүй байгааг харгалзан хоёр хуваахдаа нэгдгүээр буюу ханасан хүчил ихтэй мөмбранны бүтэцтэй, бадганы оронд оршдог эрхтнуудэд холинорецептор, хоёрдугаар буюу ханаагүй хүчил ихтэй мөмбранны бүтэцтэй шарын оронд оршдог эрхтэнд адренорецептор тооны хувьд давуутай оршидог гэсэн санааг мэн гаргасан юм. Холинорецепторийн нэлэөгөөр амьсгалын дээд замын салст, шүүрэл цэр, ходоодны шүүс, хоол боловсруулах ферментийн ялгаралт ихэсдэг бол адренорецепторийн нэлэөгөөр вөх тооны бодисын задрал хурдаас бодисын солилцво эрчимжин, дулаан ялгаралт ихэсдэг нь (21) ингэж хэлэхийн бас нэп үндэс болсон юм.

..Шарын өвөрмөц чанартай хунд шарын хүрч билиг чанаараас нөхцөлдөн биеийн хөдлөгөөн, зан ааш зэрэгт нь бадгана, хийн өвөрмөц чанартнаас харьцаангуй хурцлагад түргэн байдал (9) гэсэн нь адренорецепторийн үйлдэлтэй холбоотой байж ч болох юм.

Монгол анагаах ухааны онолын дагуу ХШБ-ын үндсээг таван хэлбэр, түүний өвчилсөн байдлын онцлогийг дээрхийтэй холбогдуулж, туслахад нийтийн төслийн  
хувьтас

А. Хийн таван хэлбэрийн өвчлөлийн үед амь баригч хий хямварвал толгой эргэж яриасаг болох, амьсталахад төвөгтэй, дээш гүйгч хийн өвчний үед бие суларч, ярьж чадахгүй ой муудах, түгээгч хийн өвчний үед аймхай болох, яриа цөөрөх гал тэгши хийн өвчний үед хоолонд дургүй, шингээлт сулрах, доош гүйгч хийн өвчний үед бие засч үл чадах, шээс ялгарахгүй эзрэг бүхэлдээ эсийн мембранны сэрэмтгий чанар

алдагдсантай холбоотой явагдах өвчний шинж тэмдгийг дурджаа (9,26).

**Шарын таван хэлбэрийн өвчний үед** шингээгч шарын өвчний үед гал тэгш хий нь ходоодонд тунглаг цөвийг ялгаруулж үл чадсанаас ходаод дүүрч, баас хатах, өнгө урвуулагч шарын өвчний үед арье шарлах, бүтээгч шарын өвчний үед о. ухдан муудах, нойр ихдэх, узүүлэгч шарын өвчний үед нар луу харж үл чадах, цагаан юм шар харгдах, өнгө тодруулагч шарын өвчний үед арье ширүүн, шар болох хумс шарлах зэрэг шинж тэмдэг илрэх (9,26) бөгөөд энэ нь шарын орны гол эрхтэн болох элэгний эсийн митохонд, микросом зэрэг мембрран байгууламжид тосны хучил, холестрин, цөсний хүчлийн нийлэгжилт явагддаг, элэгний эсийн мембрран байгууламжийн тосны ханаагүй хүчлүүд нь бусад эрхтэцүүдтэй харьцуулахад хайлах температур багатай, исэлдэн задрах хурд, ялгарах дулаан, хэт исэлдэлтийн эрчмээр илүү байдаг тухай орчин үеийн ухагдахуунтай дүйж байна (14, 15, 16).

Бадгаач үндсэн таван хэлбэр тэдгээрийн өвчлөлтийн шинж тэмдгийг Монгол анагаах ухааны сурвалж материалд: шүтүүлэгч бадганы өвчний үед хоол идех дур муудах, гашуунаар гүлгидаг, ялзлагч бадганы өвчний үед хоол боловсруулт муудан, юу идсэн ч бөөлжине, хэхрэнэ, хэвлэлийн дүүрүү хатууруна, амьсгалуулагч бадганы өвчний үед юмын амт мэдэхгүй хэл хүйтэн оргино, дуу хоолой сөөнө, хангагч бадганы өвчний үед толгой хүндэрх чараа муудна, найтааж ханицаа, сонсогт муудна, барилдуулагч бадганы өвчний үед че мөч буудуурч хавдана, цэр нус, амьсгалын салс гадагш ялгарч чадахгүй гэсэн нь (9) бидний давшүүлсэн бадгана дийлэнх эрхтэнд мембрран байгууламжид нь холинорецептор давамгайлан байрладаг байж болох тухай санаатай тохирч байтаа юм. Өөрөөр хэлбэл энэ үед холинорецепторийн мэдрэмтгий чанар суларснаас амьсгалын дээл замын шүүрэл, ходоод зэрэг хоол боловсруулах эрхтний шүүрэл, фермент, гормоны ялгаралт багассан өвчний шинж тэмдгийг өгүүлсэн нь харагдана. Энэ нь бадгандыг хоол боловсруулах ферменттэй холбож Б. Цэрэндэндэвшийн (22..) бичсэнтэй тохирч байгаа боловч бид бадгандыг зөвхөн гармон ферменттэй бус, харич бүхэл бүтэн рецептор, язз бүрийн эрхтэй мембрраны байгууламжтай холбоочоор асуудлыг арай өргөн хүрээтэй тавьж байна гэж үзэж байна.

Хоол боловсруулах замын олон тооны хүчтэй үйлдлэлтэй ферментуудийг чийлэгжүүлж, агуулдаг эсүүлийн (ходоод, нойр, булчирхай) мембрраны байгууламж нь хэт исэлдэн задрах болон гадаад орчны тааламжгүй нэлөөнд тэсвэрлэх чалвар слитай тосны ханасан хүчлээс (бадганы талын) голчлон тогтдог нь эс задлан хайлуулах хүчтэй фермөнт нийлгэжүүлдэг лизосом зэрэг бүтцийн жижиг хэсгүүдийн мембрран дээрх хүчлийг баялаг агуулдаг хамгаалалтын нарийн зохицуулгатай байлаа тухай судалгаанаас ч хярагдана (13, 16).

**Б. Цаг улирлын үечлэл ХШБ, мембрраны байгууламж**

Монгол анагаах ухааны сурвалж материалд: «хий өвчин зүн цагт үдэш, үүрээр босно. Шар намар цагт өдөр дунд, шөнө дунд босно! Бадган хавар цагт бурий, өглөө эрт босно» гэснийг (12. 18) хийсвэр сийголт хэмээн үзэх үндэсгүй бөгөөд харин ч олон зуун жилийн **ажиглалтын явцад** батлагдан гарцаагүй үнэн зүүл гэлтэй. Уг асуудлыг амьд билемхбодын мембранны ерөнхий байгууламж, гүүний бүтцийн хэсгүүдийн динамик өөрчлөлттэй холбоо харуулсан зарим судалгааны материалтай жишвэл хөхтөн амьтлын биед тосны ханаагүй хүчлийн хэмжээ (олени, лицолен зэрэг) хаврын улирлаас зүн намрын улирал гийш аажим ихсеч, намарт 3—5 дахин чэмэгддэг болоа (11) тосны ханасан хүчлүүд амьтны хүйтэнд тэсвэрлэх чадварыг сурлуулдаг, харин ханаагүй хүчлүүд нь уг чадварыг мэдэгдэхүйц нэмэгдүүлдэг тухай судалгаа (11) нь бидний давшүүлсэн бадгана тосны ханасан хүчилтэй, шар ханаагүй хүчилтэй харицлан шүтэлцдэг байж болох тухай санааг давхар баталж байна.

Туршлагын амьтлыг тосны ханаагүй хүчлээр баялаг хоолоор тэжээхэд зүрхий ажиллагаа 7,2°C-д зогсож байсан бол хастуу буюу ханасан хүчил их агуулсан хоол хэрглэхэд зүрхийн агшилт 12°C-д зогсн хүйтэнд тэсвэрлэх чадвар эрс муудаж байсан (11) хийгээд гадаад орны температурыг 42°C-аас 27°C болтол бууруулахад хачасан, ханаагүй хүчлийн тооны харьцаа 1,6-аас 1,0 болот багасч, хүйтэн нөхцөлд мембранныг хэт хатуураас хамгаалж байсан (20) зэргээс үзвэл хаврын бадгача хэдлэх цагт тосны ханаагүй хүчлээр баялаг бүлээн халуун хоол тэжээллийг, намрын шар, босох цагт үүний зэрэг чанартай зүйлийг хэргэлдэг байсан монгол анагаах ухааны уламжлал (9, 25, 26) шинжлэх ухааны бүрэн үндэстэй байхуйц харагдзана. Харин зуны улиралд бол нийт билемхбодын мембрран байгууламжид ханасан хүчлээс ханаагүй хүчил шилжилтийн үе болж мембрраны бүтэй харьцангуй тогтвортой байдалд орж болох тул мембрраны сээрэмтгий чанарт өөрчлөлт гарч, монгол анагаах ухааны онолоор бол хий өвчич босох бодит нөхцөл бүрэлдэг байж болзшигүй юм. Зүрхийн шигдээс өвчний үед эсийн мембрраны өөх тосны бодис хэт исэлдэн задрах процесс, зүрхийн эсийн мембрраны сээрэмтгий чанар, биопотечциалийн өөрчлөлтийн хоопонд хүчтэй зэрэг координаци байдал тухай бидний ажиглалт ч үүнд толорхой баталгаа өгч байна (1).

**Товч нэтгэгэн дүгнэвэл.** Хаврын бадгыча хөдлөх цагт тосны ханасан хүчил ихтэй (хүйтэн чанартай) хоол тэжээл идэж үүн, биеийн гадаад, дотоод орчны температурыг бууруулаад байвал мембрраны хэт хатууруулах намрын шар хөдлөх цагт тосны ханаагүй хүчил ихтэй хоол хэрэглэж гадаад, дотоод орчны температурыг нэмэгдүүлбэл мембрраны шинжэн чөлбэрийн хувийн жир харьцангуй дэчинилснээр мембрбан бүтэц-чийг ажиллагааны тохиомжтой талөв байлаа алдааж эмзэг процесс үүсч болжтой нөхцөл тавигдлаг байж болох нь УШБ хөдлөх цаг, улирал, хсол, эм заслын тухай

Монгол анагаах ухааны онолтой тохирч байна.

#### В. ХШБ-ын орших орон, мембранийн байгууламж

Бадгана нь толгойд шүтэж биений дээдэд оршино. Шар нь элгэнд шүтэж завсарт (зүрхнээс хүйс хүртэл) байрлана. Хий нь сүүж, бэлхүүсэнд шүтэж, биенийн доодод байрлана гэснийг зарим талаар тайлбарлах оролдлого хийвэл завсар буюу дунд хэсэг нь гэдэс, элэг зэрэг халуун үүсгэх чадвартай эрхтнүүдийн гол байрлалыг зааж байгаагаараа хүн, амьтдын бүдүүн гэдэсний хэсэгт биенхолын халуун хүйтний зохицуулгын тодорхой хэсгийн бүрэн хангаж чадахуйц дулаан үүсдэг тухай доктор Ж. Шагжийн (23) онолтой нийцэж байна. Хэвлэлийн хөндийн дотор эрхтнийг даган байрласан өөх тосны бодисууд нь хайлах температур багатай, ханаагүй хүчил голлон агуулдаг, харин биений гадаргуу (дээд) хэсгийн өөх тосны бодис нь голдуу хатуулаг ханасан хүчлээс (бадгана тогтдогийг ч (21) анхаарвал зохицно.

Үүнийг Монгол анагаах ухааны сурвалж материалыд «...бадгана» өвөрмөц чанартны бие дориун, өнгө цайруу байдаг, бадгана арвигалт таргалалт, өөхлөг эд арвигах зэрэг нь түүний тослогийн (хүйтэн) билиг чанараас болдог...» хэмээсэн нь (9) дээрхитэй (21) нийцэж байна.

#### «Г. Хүний нас. ХШБ, мембранийн байгууламж»

Монгол анагаах ухааны судар бичигт «хөгжид нь хийн хүн, идэр залуучууд нь шарын хүн, нялхас нь бадгана хүн» гэсэн байдаг (18). Үүнийг өөрсдийн дэвшүүлсэн төсөөллийн дагууд авч үзвэл хүүхэд, идэр залуу насын хүмүүст өөх тосны бодисын солилцоо эрчимтэй явагддаг (ханасан, ханаагүй хүчил алх, алх, харин нас ахиж хын хэрээр уг процесс алдагддаг байж болох тухай санааг бий болгох бөгөөд туршлагын амьтдад явуулсан судалгаагаар залуу амьтдад биений хүчин ачаллын нөхцөлд цусанд чөлөөт тосны хүчлийн концентраци 50—56%-иар, нэмэгдэж, харин хөгжин амьтдад бараг өөрчлөгдөхгүй буюу өөхний бодисын солилцоо илэрхийн суларсан байснаас (21) хөгжрэхийн хэрээр бадгана, шарын зохицуулга алдагдаж эцстээ хий хямрах нөхцөлийг бий болгодог тухай дүгнэлт өгч болох юм.

Д. Хий, шар, бадгана, эмийн амт, мембрант байгууламж

Хий шар, бадганаар үүссэн өвчний эмчилгээг эмийн зургаан амттай холбон үзүүлсэн байдлаар бол хийг амтлаг (шороо+ус), иргэлэн (гал+шороо), давслаг (ус+гал) амттай, шарыг амтлаг (шороо+ус), гашуун (ус+хий), эхүүн (шороо+хий), бадганаыг иргэлэн (гал+шороо), давслаг (гал+хий), халуун (гал+хий), амттай эмт бодисоор эмчлэх зарчим баримталлаг нь хийл хөнгөн, балгын хүйтэн, шард халуун билиг чачар зонхилдог тухай Монгол анагаах ухааны онолд бат тулгуурлажээ (9, 25, 26).

Бид Монгол анагаах ухаанд ус+хий махбодсоц тогтсон гашуун амтан дээр нь тулгуурлан, элэгний халуун өвчний ана-

гаах зорилгоор өргөн хэрэглэдэг цэх галуун таваг ургамлын блэдмэлийн идэвхийг туршлагын амьтдад CCL<sub>4</sub>-аар үүсгэсэн элэгний чомог үрэвслийн загвар дээр судалсан юм (19).

Уг блэдмэл элэгний эсийн мембранийн тосны ханаагүй хүчилд, өдөөгдсөн хэтгээдэлтийн процессыг (ӨХИП) 2—3 дахин бууруулсан болон уг процесс хэт нам, гэрэл, квант дулааны энэрги ялгаруулан явагддагт (5, 10) үндэслэн уг эм сэруүн чанартай, элэгний халууныг дарах үйлдэлтэй гэж хэлж болох байна. Харин яг энэ туршилтын нөхцөлд уг эмийн бодис дэлүүний эсэд өдеөгдсөн ӨХИП-ийг харьцангуй сул дарангуйсан (1,5 дахин), ерөөс CCL<sub>4</sub>-ийн нөлөөгөөр дэлүүнд ӨХИП элэгний эдийг бодвол маш сул өдеөгдсөн зэрэг нь шар, бадгана мөн чанартай мембранийн тосны ханаасан, ханаагүй хүчил, тэдгээрийн ирэхимтэй холбон тайлбарласан бидний саналтай тохирч байгаа юм. Тосны ханаасан хүчилд ӨХИП маш сул өдеөгддөг, хүйтэн чанартай, гашуун амттай эмийн үйлдэл ч сул илэрдгийг илрүүлсэн нь бусад судлагчдын материалтай таарч байна (25).

#### ЭЦСИЙН ТОВЧ ДҮГНЭЛТ

Нийт бие махбодын «мембрант байгууламж» гэсэн өргөн хүрээнд хийсвэрлэн авсан ойлголтыг ХШБ-тай холбож, тухайлсан бодгаль хүн болон эрхтэн бүр мембрант байгууламжийн «бүтэц-үйл ажиллагааны» төрөлхийн өвөрмөц онцлогтой, тэр нийн мембранийн хатуу, шингэн төлөв хэмээх ойлголттой нягт уялдаатай, түүний биохимийн үндэс нь ханаасан, ханаагүй хүчлийн тоон харьцаа болох, тэдгээрийн ялимгүй боловч өөрчлөлт нь эсэд явагдах бүх ферментийн урвал, АТФ-ийн нийлэгжилт (эсийн амьсгал, энергийн солилцоо) ионы солилцоо, сэрэмгийн чанар, рецепторийн харилсан үйлчлэл, мембранд холбогдох байрласан бүх биологийн идэвхтэй бодисын (аденилатциклиза, ц. АМФ, ц. ГМФ) үйл ажиллагааны идэвхжилт, бууралтыг нөхцөлдүүлдэг уян хатан зохицолтой гэж үзсэн нь бидний дэвшүүлсэн «мембрант байгууламж-Х.Ш.Б.» гэсэн томъёолын гол мөн чанар нь юм. Энэ томъёолол нь Монгол ардын эмнэлгийн «Х.Ш.Б.»-ны тухайн ухагдахууны бүх хэлбэр, идээ, ундаа, явдал мөр, эм заслалын тухай сургаалтай яв цав тохирч байгаагаараа онцлогт юм.

#### АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. М. Амбага, А. Авирмаа — Зүрхний шигдээс өвчний үе дэх цахилгаан бичлэгийн өөрчлөлт, өөхний хэт ирэлдэлтийн эрчимийн үзүүлэлтийн хосрондох корреляци. Монгол анагаах ухаан, 1990, №3, X 15—17.

2. М. Амбага, Таван цул эрхтний үйл ажиллагааны хоорондын харьцаа, цаг улирлын нөлөөллийн талаархи Монгол анагаах ухааны онолын уламжлалыг судлах асуудалд. — Анагаах ухаан, 1990, №2, X 29—31.

3. Ч. Баавгай, Б. Болдсайхан — Монголын уламжлалт анагаах ухаан. Улаанбаатар, 1990, 385 х.

4. Л. Баасанхүү. — Уламжлалт эмнэлгийн онолын үндсэн зарчмуудыг тайлбарлах асуудал. — Монгол анагаах ухаан 1990, № 1, х 53—54.
5. Биохемилюминесценция. Наука, 1983. 276 с.
6. Б. Бодсайхан, Л. Баасанхүү, С.М. Николаев — О регулирующих системах организма в традиционной восточной медицине. Тезисы докладов первой научной конференции молодых ученых-медиков МНР, г. Улан-Батор, 1985, с 29—31.
7. Ю. А. Владимиров, А. И. Арчаков. Перекисное окисление липидов в биологических мембранах. М. Наука, 1972. 252 с.
8. Дудел. Дж., Рюзгэг И., Шмидт Р и др. Физиология человека I том. 1985. 272 с.
9. Б. Жигмэд — Монгол анагаах ухааны үндсэн сиол, Эвэрмонголын хэвлэлийн хороо. 1988, 275 х.
10. А. И. Журавлев, А. И. Журавleva — Сверхслабое свечение сыворотки крови и его значение в комплексной диагностике. М. Медицина, 126 с.
11. Н. И. Калабухов. Спячка млекопитающих. М. Наука, 1985. 264 с.
12. Е. М. Крепс. Липиды клеточных мембран. Наука, 1981. 340 с.
13. Лизосомы и лизосомные болезни накопления, под редакцией Дж. В. Каллахана. Дж. А. Лоудена. М. Медицина 1984. 448 с.
14. А. С. Логинов, Б. Н. Матюшина, В. Д. Ткачев и др. Перекисное окисление липидов печени при ее патологии «Тер. архив». 1985, № 2, стр 63—68.
15. Ю. П. Никитин, С. А. Курилович, Г. С. Давидик. Печень и липидный обмен. М. Медицина, 1985. 151 с.
16. В. Ф. Нисевич, Н. И. Учайкин. Тяжелые и злокачественные формы вирусного гепатита у детей. М. Медицина, 1982, 288 с.
17. Р. П. Петров. Иммуногенетика и искусственные антигены. М. Медицина, 256 с.
18. Рашааны зүрхний найман гишүүт нутц увидсын үндэсний анхдугаар хэсэг язгуурын үндэс хэмээх оршвой.
19. Б. Саранцэцэг, М. Амбага, Т. Долгорсүрэн — Туршлагын амьтдад загварчилж үүсгэсэн элэгний үрэвслийн үед ОХИП эрчимжих байдал, түүнд цээ галууц тавгийн чийлбэр алкалоидийн үзүүлэх илэвх. Монголын анагаах ухаан, 1990, № 3, х 28—34.
20. Страйер, Биохимия. II том, 1984, 232 с.
21. С. Х. Хайдарлич. Функциональная биохимия, адаптации. Кишинев, Штиница, 1984, 272 с.
22. Б. Цэрэндэндэв — Монголын уламжлалт анагаах ухааны зарим тулгуур ухаждахуун. Монголын анагаах ухаан, 1990, № 1, х 46—49.
23. Ж. Шагж — Хүн ба хөхтөч эмчтэны гэдэсний будуун хэсэгт дулааны энэрги үүсэх үзэгдэл. Биологийн ухааны докторыч зэрэг горилсон диссертацийн хураангуй. УБ., 1989.
24. Ясую Кагава, Биомембранны. М. Высш. Шк. 1985. 303 с.
25. Bagwan Dash, Fundamentals of Ayurvedic Medicine, Bombay 1978.
26. Tibetan Medicine 1983. S. № 6 р 64—91

## ХОВОР ТОХИОЛДОЛ

### ЦЭЭЖНИЙ ХӨНДИЙД ТУНГАЛГИЙН ШИНГЭН ХУРАЛДСАН ТОХИОЛДОЛ

Цээжний хөндийд тунгалгийн шингэн хуралдахыг хилоторакс гэнэ. Энэ нь хилотораксын мэсажилбарын үед цээжний тунгалгийн цорго гэмтэхэд болон цээжний ил, битүү гэмтлийн үед тохиолддог. Зөвхөн 8,6—15,5% тохиолдолд ямар ч гэмтлийн шалтгаангүй үүсдэг (Ибатуллин И. А., 1983). Энэ нь ямар нэг өвчин эмгэгийн үр дагавар болж хоёрдогчоор, тухайлбал дундаж зайн болон уушгин хорт хавдрын үед тунгалгийн цорго буюу түүний салаа гэмтэж, сурьеэгийн гэмтэлд

өртөх, тунгалгийн урсгал хавдар болон сорвижсон зүйлээр дарагдах, тунгалгийн судасны өргөссөн хэсэг хагарах, тунгалгийн судасны төрөлхийн гажгуудын үед илэрдэг. (Ибатуллин И. А. 1974, Herzog K. A. Branscom L. L. 1974, Mirkku T. O. Piper C. A. 1977).

Эмчилгээ нь уг эмгэгийн үүсгэж буй шалтгаанаас хамаарна. Орчин үед гялтангийн хатгалтаар буюу цээжний хөндийд гуурс тавьж хөндий дэх шингэннийг соруулж авах замаар 2—4 долоо хоногийн турш

Эмийн эмчилгээ хийх нь зүйтэй гэж ихэнх эрдэмтэд үздэг. Үр дүн өгөхгүй бол мэс заслын эмчилгээ хийж гэмтсэн цоргыг оёх, эсвэл боох шаардлагатай. Тунгалгийн шингэний хамт уураг, өөх тос, давс, дархлалын эсүүдийг их хэмжээгээр алдаж амархан туралд ордог учир эртхэн мэс засалд оруулах нь ашигтай юм аа (A. M. Понемарев, P. Mulliez, G. Deblanwe 1979).

Өвчтөн Ц. Ж 54 настай эмэгтэй (Баянхонгор аймгийн Богд сумын харьяат. Хүүхдийн байгууллагад сахиулын ажилтай).

1990 оны V сарын 21-нд баруун талын гялтангийн шүүдэст үрэвслэл оноштойгоор уушгины мэс заслын тасагт хэвтсэн. Хэвтсэн үед цээжээр хөшин хүндэрч өвдөнө, амьсгаадна, ханиалгаж салсархаг өтгөн цэр гарна гэсэн зовиурттай байв. 1990 оны II сараас амьсгаадаж гүрээний судас хөөж эхэлсэн. Халуураагүй. IV сард орон нутгийнхаа эмнэлэгт хэвтэж баруун талын уушгины хатгалгаа, гялтангын үрэвслээр хүндэрсэн гэсэн оноштой сар гаруй эмчлэгдсэн. 2 удаа гялтангийн хатгалт хийж 2 литр орчим сүү шиг цагаан шингэн авч байжээ.

Бодит үзлэгт цээжний хэлбэр зөв, баруун тал амьсгалд хоцорч оролцно. Тогшилтоор баруун далнаас доош дүлий чимээтэй, амьсгал сонсогдохгүй. Зүрхний авиа тод, жигд, судас 1 минутад 92 удаа лугшина. Цусны даралт 120/80 мм МУБД. Цусны шинжилтээнд нь Б-74,2 г/л, цагааа эс 8,6·10<sup>2</sup>/л, улаан эс 3·10<sup>12</sup>/л, УЦТХ-34 мм/ц, эозинофиль 2%, с/б-4%, х/б-65%, лимфоцит-27%, моноцит 2%, сийвен дэх уураг 59 г/л, сахар 4,9 ммоль/л байв. Мантуугийн сорил 10 мл байлаа. Рентген зурагт баруун талын II хавирганаас доош тод, жигд сүүдэртэй, дундаж зайн эрхтэнгүүд зүүн тийш түлхэгдсэн, өрц бэлон уушгины хил ялгарахгүй. Гуурсан хоолойг дурандахад цагаан мөгөөрсөн болон гуурсан хоолойн салст бурхэвч бага зэрэг зузаарч нугалаас томорсон, цайвар ягаан онгтөтй байв. Гялтангийн хатгал-

таар 2 л орчим гялтганасан, тундасжаагүй, нэг төрлийн сүү шиг цагаан шингэн соруулж авав. Түүнд уураг 22 г/л, цагаан эс 5—6%, улаан эс 12—15%, лимфоцит 100%-тосны дусалтай байв. Цагаан эсийн дурст элементүүд тодорхойлогдоогүй.

Эндээс бид, тунгалгийн эргэлт алдагдаж цээжний тунгалгийн цорго гэмтсэнээс цээжний хөндийд тунгалгийн шингэн (хилус) хуралдаж гэсэн дүгнэлт хийж хуралдсан шингэнийг гялтангийн хатгалтаар байнга соруулан авч эмийн эмчилгээг хавсран хийсэн. Цээжний хөндийд тунгалгийн шингэн давтай хуралдаад байсан учраас 1990 оны VI сарын 18-нд эмчилгээ-ношлын зорилгоор цээж иэх мэс засал хийв. Цээжний хөндийг нээж 700 мл орчим тунгалгийн шингэн авч уушгины наалдцыг салгаж чөлөөлсөн. Уушгины уг дээр байсан томорч гэмтсэн тунгалгийн булчирхайг авав (1,0 x 0,5 x 6 см).

Тэндээс тунгалгийн шингэн урсан гоожиж байв. Өргөссөн тунгалгийн судсан дээр З оёдол тавьж боов. Шингэн гоожихоо бүрэн зогссон. Уушгины угийг шалгаад цээжний хөндийг үжлийн эсрэг бодисор (фурациллин, риванол) угааж антибиотик (пенициллин 1 сая, стрептомицин 1 сая) цацаад цээжний хөндийд VII хавирганы завсраар гуурс тавьж шархыг битүүлж хаав. Хагалгааны дараах үе - хүндрэлгүй өнгөрч гуурсаар дахин тунгалгийн шингэн гараагүй.

Гуурсыг З дахь хоног дээр рентген хяналтын дор авав. Уушги бүрэн тэлсэн. Өвчтөн 42 хоногийн дараа эмнэлгээс гарсан.

Энэ тохиолдлоос үүдэн мэргэжил нэгт нөхөддөө сануулж хэлэхэд дундаж зайд дахь тунгалгийн цорго гэмтсэнээс тэнд тунгалгийн шингэн хуралдаж болох бөгөөд цээжний хөндий рүү гэнэт нээгдсэнээс шингэн хүчтэй юулэгдэж өвчтөн оврогийн байдалд ордог. Хоногт 400 мл-ээс дээш тунгалгийн шингэн алдаж болно. Ингэж тунгалгийн шингэн их хэмжээгээр, удаан хугацааны турш алдах нь

цөөнгүй байдаг. М. С. Соболева нарын эрдэмтэд (1970 он) ийм өвчтөнд 71 удаа гялтангийн хатгалт хийж нийт 140 литр тунгалгийн шингэн авч байжээ.

Тунгалгийн шингэнийг ингэж их хэмжээгээр алдахад бичил элементийн солилцоо хямралд орохоос гадна уураг, өөх тос болон дархлалын эсүүд хамт алдагдаж биет махбодын шингэний зохицуулалт бүхэлдээ хямралд ордог.

Эмчилгээний хувьд анхаарах нэг зүйл бол зарим нэг өвчтөнд гялтангийн хатгалт олон удаа хийс-

нээс тунгалгийн шингэн халдвартлагдаж идээлдэг учраас эмчилгээний чиглэлийт өөрчлөх шаардлагатай болдог. Халдважсан эсэхийг тодорхойлоходоо гялтангийн хатгалаар тунгалгийн шингэн бүлэгнэсэн эсэхийг анзаарах хэрэгтэй. Хэрэв шингэн цэвэр байвал бүлэгнэдэггүй. Халдважсан тунгалгийн шингэн бүлэгнэсэн байдаг. Ийм өвчтөн хөдөө, орон нутагт тааралдаад эмчилгээний нөхцөл, бололцоогүй бол уушгины мэс заслын тасагт цаг алдалгүй илгээж байх нь зохистой.

Д. Цогт, Д. Энхцэцэг

## НАСНЫ ОЙ

### ПЭЛЖЭЭГИЙН ДОЛГОР



1990 оны 7-р сард БНМАУ-ын гавьяат багш, БНМАУ-ын төрийн шагналт, мэс засалч Анаатаах ухааны дээд сургуулийн тэнхимиин эрхлэгч анаатаах ухааны доктор, профессор П. Долгор 60 нас хурлээ.

П. Долгор 1930 онд Завхан аймгийн Жавхлант сумын нутаг Хайрхан булан гэдэг газар малчин ард Нацагийн гэрт мэндэлжээ.

Тэрээр 15 настайдаа МУИС-ийн бэлгэл ангид элсэн, 1947—1952 онуудад хүн эмнэлгийн факультетэд суралцан төгсчээ. Их сургуулийн 2-р дамжаанд суралцаж буй үеэс сургуульдаа анатомийн багшаар ажиллаж улмаар 1952—1956 онуудад МУИС-ийн хүн эмнэлгийн факультетэд багш, 1960 оноос МУИС-д мэс заслын багш, нэгдсэн I эмнэлгийн мэс заслын тасгийн эрхлэгч 1961 онд АУДэС-ийн багш, мэс заслын тэнхимиин эрхлэгчээр одоог хүртэл ажиллаж байна.

П. Долгор 1956—1960 онуудад ЗХУ-ын А. В. Вишневскийн нэрэмжит мэс заслын институтын аспирантурт суралцан «Ходоод тайрахад нойр булчирхайн шүүрэл өөрчлөгдхөх нь» сэдвээр анаатаах ухааны дэд эрдэмтний зэрэг 1979 онд «Өрциен дор байрласан бэтгийн оношлогоо, эмчилгээ» сэдвээр докторын зэрэг хамгаалсан юм.

П. Долгор манай нэрт мэс засалч, сурган хүмүүжүүлэгч, эрдэмтэн шинийг санаачлагч хүн юм.

П. Долгор 34 жилийн эрдэм шинжилгээ судалгааныхаа ажлын явцад 100 гаруй бүтээл хэвлүүлсний дотор шинэ бүтээл 5, оновчтой санал 10 гаруйт санаачлан нэвтрүүлсэн байна.

Сүүлийн 20 гаруй жилийн дотор түүний удирдлага, оролцоотойгоор хийгдсэн судалгааны үзлэснээ ажил нь, элэгний бэтгийн оношлогоо, мэс заслын эмчилгээ, элэг, цөсний замын өвчний онош мэс заслын үр дүнтэй аргыг боловсруулах, хodoод, гэдэс нойр булчирхайн хүнд, хүндэрсэн өвчний үед өвчтөний амь насыг аврах мэс заслын шинэ аргыг боловсруулах, нэвтрүүлэх, хэвлэлийг дураандах, хэт авианы оношлогооны аргуудыг төгс боловсrongуий болгох өргөн хү-

рээтэй асуудлуудыг хамарсан юм. Түүний санаачилсан «Бээтгэнд даргадсан хатанхайрсан өрцийг фиброз бурхуулээр нөхөх арга» «Бээтгийн үлээс хөндийрүү цорсон цөсний цоргыг нөхөх арга (Б. Гоошийн хамт) «Бээтгийг хэт авиаагаар оношлох нь» (Б. Гоош, С. Сонин, Б. Мөнхтогоо нарын хамт), Ходоод гэдэсний замд «Ү» хэлбэрийн залгалт хийх арга гэсэн дорвигийт бүтээлүүд нь БНМАУ-ын шине бүтээлд бүртгэсэн юм.

П. Долгор 1961 синд гол судсуудын хоорондох битүүрээгүй цоргыг боох мэс засал, 1966 оноос элэг хатуурах өвчиний үед үүдэн хураагуур судсыг, доод хөндийч хураагуур судсан, дэлүүний хураагуур судсыг, зүүн бөөрний хураагуур судсан, залгах мэс засал, 1967 оноос элэгийн зүүн ба баруун дэлбэнг тайрах цөсний ерөнхий цоргыг дээрх гэдэстэй холбох зэрэг нарийт төвөгтэй, олон мэс заслыг мачай оронд анх хийсэн юм.

П. Долгорын удирдлагаар анагаах ухааны доктор I дэд эрдэмтэй 8 төрсөн, тэдгээр шавь нар нь тэнхлийн эрхлэгч, ахлах багш, зөвлөх эмчээр ажиллаа гараж байна.

П. Долгор олон жилийн турши монголын эмч нарын нийэмлэгийн даргаар ажилласан бөгөөд, 1962 оноос ДЭХБ-ын хорооны цлтгэгч, орлогч даргъяа, даргаар сонгогдох ажиллаж байсан ба одоо зүүн өмнөд

азийн бүсийн хорооны эрдэм шинжилгээний зөвлөхөөр ажиллаж байна.

Тэрээр Эрүүлийг хамгаалах болон, ардын боловсролын тэргүүний ажилтан VI, VII таван жилийн гавшгайч бөгөөд ардын хувьсгалын ойн медалиуд, хөдөлмөрийн хүндэт медаль, алтай гадас, хөдөлмөрийн гавьяаны улаан түгийн одонгоор шагнагдсан, 1969 онд доцент, 1982 онд профессор, 1989 онд БНМАУ-ын гавьяят багш цолбор шагнагдаж 1990 онд «Элэг цөсний өвчиний оношилж, мэс заслаар эмчлэх асуудлыг хам шийдсэн нь» бүтээлээр шавь нарынхаа хамт БНМАУ-ын төрийн шагнал хүртсэн юм.

П. Долгорын монголын анагаах ухаан, үндэсний мэс заслын хөгжилд оруулсан их хувь нэмэр, түүний мэргэжлийн өндөр ур чадвар, багшлак эрдэм ажилч хичээнгүй, даруу зан чанар эмч эмнэлгийн ажилчид, багш, эрдэмтэн оюутнуудын дунд төдийгүй эмчлэгдэж эдгэрсэн олон хүмүүсийн хайр хундэтгэлийг хүлээдэг юм.

Профессор, П. Долгорт, түүний 60 наасны ойг тохиолдуулан баяр хүргэж урт удаан насалж хүний төлөө ариун үйлстээ их амжилт гаргахыг хүсэн өрөөе.

Монголын үндэсний мэс засалчдын нийтмэлэг АУИС-ийн мэс заслын I, II тэнхим «Эрүүл энх» хэвлэлийн газар

## ТАНИН МЭДЭХҮЙ, ЭМНЭЛЗҮЙН СЭТГЭЛГЭЭ

### ӨВЧИН, ӨВЧНИЙ ШИНЖИЙГ АНГИЛАХ НЬ

Д. Чойжил (Намын түүхийн институт)

Судлах зүйлийнхээ талаар учир зүйн хувьд цэгцэрсэн үндэслэлэгээ бүхий ангилал, жагсаалттай байвал судалгааны тухайн тэр салбар шинжлэх ухааны үндэс сайтай байгаагийн нэн чухал үзүүлэлт мөн.

Ангилал, жагсаалтын асуудал бол практик ажилд чухал төдийгүй, онолын ихээхэн ач холбогдолтой байна. Үнэн чартаа аливаа шинжлэх ухааны ангилал бол Ф. Энгельсийн тэмдэглэснээр үндсэн зүй тогтолцын холбоо уялдаа, дэс дараалал, эрэмбэ дэсээр нь илрэхийлсэн зүйл юм. Зөв бүлэглэх, ангилын асуудал бол В. И. Лениний өгүүлснээр: «...өнгөхэн ажиглахад санагддаг шигээ зөвхөн техникийн, зөвхөн мэргэжлийн явцуу асуудал хэрхэвч биш» билээ (В. И. Ленин. Зохиолууд, 22-р боть, 54 дэх талд).

Ангилал бий болгох явдал шинжлэх ухааны хөгжилд нэгэн бүхэл эринийг эзэлдэг (Б. М. Кедров, 1961, 1965). Шинж-

лэх ухааны ангиллын сонгодог үлгэр загвар нь Ф. Энгельсийн боловсруулсан шинжлэх ухааны салбаруудын ангилал, Ч. Дарвина санал болгосон амьтны зүйлсийн ангилал, Д. И. Менделеевийн элементийн үелэх систем мөн.

Судалж байгаа зүйлийнхээ тухай мэддээ баримтаар дутмаг, ангиллын үндэс болгож болохуйц өвөрмөц шинж тэмдгийг мэддэггүйн улмаас урьд мэдлэгийн олон салбарт шинжлэх ухааны ангилал байсангүй.

Орчин үеийн шинжлэх ухаанд ангилал бий болгох буюу өөрөөр хэлбэл судлах аливаа олонлогийг (ангийг) дэд олонлог (дэд ангийг) болгож яланг салгах асуудлыг таксономи хэмээх тусгай шинжлэх ухаан авч уздэг бөгөөд таксономи бол таксон, шинж тэмдээр ангилах тухай сургаал гэж тодорхойлдог байна (С. В. Мейен, Ю. А. Трейзер, 1976).

\* К. Е. Тарасов, В. К. Великов, А. Фролова. Логика и семиотика диагноза. М., «Медицина», 1989. номын 6-р бүлэг.

Анагаах ухаанд ангилал XVIII зууны дунд үеэр үүссэн бөгөөд тэр үеийн нэрд гарсан анатомич Д. Б. Морганийн (1682—1779) зохиол бүтээл лүгээ холбоотой. Д. Б. Морганий «Өвчний байршил ба шалтгааны тухай» зохиолдоо өвчний ангиллыг нэлээд бүрэн дүүрэн бөгөөд тухайн үедээ шинжлэх ухааны үндэстэй хийсэн байна. Өвчин явцыг хүний биений уе мөч сегментэд байрласан эрхтэн, системээр хязгаарлан шинжлэх эмгэг судлалын зарчмыг ангиллынхаа үндэс болгожээ. Д. Б. Морганий өөрөө анатомичийн (бие бүтцийн мөргөжилтийн) хувьд олон удаа задалгаа өвчин чухам ингэж байршил шинжийг олж мэдээд түүнийгээ үндэслэн өвчлөлтийг ялган салгах гэж оролдсон байна. XVIII—XIX зууны идеалист эмч нарын тогтоосон өвчиний субъективист хуваарилалтыг бодвол Д. Б. Морганий энэ ангилал нь өвчинийг эрхтнээр хязгаарлан шинжлэхэд үндэслэснээрээ өвчиний материалыг субстратыг итололжээ. Энэ ангилал цаашдаа өвчиний уг чанарыг материалист ёсоор судлахад тус дөхөм болж, эмнэлзүйн болон онолын салбар ухаанууд хөгжихийн суурь дэвсгэр болж өгчээ.

Үхэл, өвчиний шалтгааны олон улсын ангилал, жагсаалт зохиох санаачилгыг анх Фарр (1853) гаргаж, цаашид францын статистик Бартильон (1893) үргэлжлүүлжээ. 1910 оноос эхлэн үхэл, өвчиний шалтгааны Олон улсын ангиллыг 10 жил тутам хянан өөрчлөх болсон байна.

Орос оронд XIX зууны далаад оноос эхлэн Земийн ариун цэврийн байгууллага байгуулах үед өвчлөлтийг ариун цэвэр-статистикийн үүдиэс өргөнөөр судлах болсондойтойт уялдан олон нийтийн эмнэлгийн байгууллагууд өвчин, үхлийн шалтгааны ангилал, жагсаалт боловсруулах ажилд эхлэн оржээ. Пироговын нийгэмлэгийн жагсаалтад анагаах ухаан дахь этиологийн (өвчин үүсэх шалтгаан, нөхцөлийн судлах ухааны) чиглэлийг тодорхой тусгах гэсэн эрмэлзэл илэрсэн нь гадаадын ангилалтай жишгихэд урагш үлмэж ахисныг харуулж байна. Үүнд 1899 оны ангилал, жагсаалт хамгийн сайн боловсруулгадсан учир 1924 оны хүртэл бага сага өөрчлөөд хэрэглэж байв.

Зөвлөлт засгийн үед өвчиний жагсаалтыг 4 удаа хянан өөрчилжээ. Өвчиний суулчийн ангиллыг ЗСБНХУ-ын Эрүүлийг хамгаалах яамны коллеги 1952 онд баталсан байна. Энэ ангилалд өвчлөлийн ангийн (28), бүлгэг (51), багц (рубрик) буюу өвчиний нэрийн (338) жагсаалт оржээ. Гэхдээ энэ ангиллыг дан ганц этиологийн зарчимд үндэслэн зохиож чадсангүй. Одоо баримталж байгаа өвчиний ангилал бол этиологийн зарчим, патологи-анатомийн (бие бүтцийн эмгэг судлалын) зарчмын аль алинд үндэслэсэн юм. Гэвч өвчиний ангийг эрхтэн, системээр ялгахдаа урьдын байршилын зарчмыг шууд хуулбарлахаар хязгаарлаагүй, харин анги ангиар хуваарилахдаа анатом-физиологийн (бие бүтцийн ажиллагааны) зарчмыг илүү баримталсан гэхэд болно.

Өвчин, үхлийн шалтгааны талаар олоо дагаж өөрдөх байгаа улсын ангилал. жаг-

саалтын (1952) зэрэгцээгээр бас ес дэх удаа хянан өөрчлөх Бага хурлын (1975) зөвлөмжид үндэслэн зохиож, Дэлхийн эрүүлийг хамгаалахын 29-р ассамблейгээр баталсан өвчин, бэртэлт хийгээд үхлийн шалтгааны Олон улсын статистикийн ангилал бий. Энэхүү ангиллын I боть нь 1980 онд, II боть нь 1983 онд орос хэлээ гарсан юм. Үнийн зэрэгцээгээр ЗСБНХУ-ын Эрүүлийг хамгаалах яам 1983 онд ес дэх удаа хянан өөрчлсөн олон улсын өвчиний статистикийн ангиллыг эрүүлийг хамгаалахын ажил практикт ашиглах заавар хэвлүүлж, 1984 онд өвчин, бэртэлт ба үхлийн шалтгааны Олон улсын статистикийн ангиллыг (ЗСХУ-д ашиглахад зориулан дөхөмчилсөн олон улсын ангилал—9-ийн хувилбар) хэвлүүлсэн нь Зөвлөлт оронд ариун цэвэр-статистикийн ажлыг журамлас үндсэн баримт бичиг болж байна.

Дээр дурдсан ангилуудаас гадна ЗСБНХУ-ын статистикийн Төв Газрын хүн амын статистикийн хэлтсийн зохиосон үхлийн шалтгазны үсгийн дарааллын жагсаалт, Украян, Латвийн эрүүлийг хамгаалах яамдын ариун цэврийн статистикийн товчооны зохиосон өвчиний жагсаалтыг ашиглах гарын авлага, эрүүлийг хамгаалахын зохион байгуулалт, анагаах ухааны түүхийн институтийн бэлтгэсэн өвчиний үсгийн дарааллын жагсаалт, ЗСБНХОУ-ын Эрүүлийг хамгаалах яамын ариун цэврийн статистикийн эрдэм шинжилгээ-арга зүйн товчооны зохиосон оношийн изрлэн тэмдэглэх үсгийн дарааллын жагсаалт бий. Бас зарим өвчиний язз бүрийн ангилал байдаг. Жишээ нь: С. М. Рыссын хийсэн өвөрмөц шинжгүй шархлаат колитын (бүдүүн гэдэсний салт бүрхүүлийн үрэвсэл) ангилал (1966), Б. Е. Вотчалын хийсэн уушги зурхний ангилал (1964), Е. М. Тареевын хийсэн хөйрдогч хорт хэт даралтын хам шинжийн ангилал (1972), Л. М. Мальцевын хийсэн зүрхний булчинийн хөндүүрлэж өвддөггүй шигдээсийн (инфаркт миакарда) жагсаалт (1969) гэж бий. Түүнчлэн И. А. Кассирскийн зохиосон лейкозын ангилал, жагсаалт (1970), С. И. Ребовын хийсэн төмөр дутагдсанас цус багасах өвчин ангилал (1970), Г. А. Алексеевийн хийсэн цус багасалтын ангилал (1970), Ю. Александровичийн хийсэн цусны системийн өвчлөлийн ангилал (1960) гэх мэт өвчиний ангийн нийтлэг шинжийн хэрээр ялгасан ангилал байдаг.

Нэг л өвчиний өөр өөр зохиогч язз янааар ангилсан байдаг. Эмнэлзүйн практикт даралт ихсэх өвчиний б өөр ангиллыг нэгэн зэрэг ашиглаж байна (Г. Ф. Ланге, А. Л. Ясиников, Е. М. Тареев нарын ангилал, ЗСБНХУ-ын Эрүүлийг хамгаалах яамны ангилал, Дэлхийн эрүүлийг хамгаалах байгууллагын ангилал, ЗСБНХУ-ын Батлан хамгаалах яамны эмнэлгийн албаны ангилал). М. С. Кушаковский (1977) практикийн эмч нарт зориулан бичсэн даралт ихсэх өвчиний тухай нэг сэдэвт зохиолдоо эдээгээрийн дээрээс өөрийнхөө ангиллыг нэмсэн нь долоо дахь ангилал болов.

Сүүлийн арван жилд зарим өвчин, өвчиний ангийн олоо байгаа ангиллыг эмхтгэсэн тусгай ном гарч эхэллээ. Жишээ бол-

тон А. Н. Митропольский (1974), М. А. Хе-теев (1974) нарын эмч нарт зориулан бичсэн нэг сэдэвт зохиол, бас Я. С. Циммерманы (1972) оюутнуудад зориулан бичиж, Пермийн анагаах ухааны дээд сургуулийн хэвлэн гаргасан суралцах бичгийг дурдсангаар хязгаарлая. Өвчин тус бүр дээр хэд хэдэн ангилал зохиосон байдгийг дурдахад сонирхолтой. М. А. Хежев (1974) судас нягтран битүүрэх өвчиний (облитерирующий тромбангит) өвчлөлийн хэлбэрээр ялгасан 5 ангилал, өвчиний үе шатаар ялгасан 8 ангилал байдгийг иш татан дурдажээ. Мён зохиогч тараагуурын даралт багасахын (артериальная гипотония) анхдагч үеийн 12 ангилал байдгийг мэдээлж, ялдамд энэ өвчлөлийг ном зохиолд 15 ёор нэр томъёогоор тодорхойлон өгүүлсэн байдгийг жагсанаа бичжээ. Даанч дээр дурдсан ангилуудыг үзэж танилцахад тухайн эмзгийг судлаах талаар шинжлэх ухааны улам өсөн нэмэгдсэн ололтыг ашигласны үр дун мён байна даа гэсэн сэтгэгдэл төрүүлэхгүй байгаа нь харамсалтай.

Эрдэм шинжилгээний өдий төдий нийтлэлд эрдэм шинжилгээний ажилтан бүр дор дордоо эмнэлэүйн аль нэгэн салбар ухааны хүрээнд, судалж буй өвчинийхөө талаар туйлын олон янзын шинж тэмдэг, арга зүй, зарчмын үндсэн дээр өөрийн онцгой ангилал зохиогыг эрмэзэх хандлага үзэгдэж байгэр бөгөөд шинжлэх ухааны бодит хэрэгцээ, шинэ чухал үндэслэгээгээр шаардлагдаагүй байхад дан өөрийн мэргэжлийн явцуу эрх ашигт захируулан олондоо онын чухал биш тийм ангилал зохиож байна.

Шинжээч бүхэн заримдаа ч зөв зүйтэй гэмээр шинэ ангилал зохиодог нь бүр алба юм шиг, хийж гүйцэтгэсэн ажлын нь шинжлэх ухааны чанарыг харуулах үзүүлэлт юм шиг болжээ. Үүний улмаас ангиллын оронд өвчиний нэрийг зүгээр тоочсон жагсаалт гарч ирэх нь цөөнгүй байна.

Үүний дээр эмнэлгийн тайлан мэдээний бичиг баримтыг бүглэх үүрэгтэй практик эмч нар анагаах ухааны ёөр ёөр дээд сургуульд сурч байхдаа хагас зуу гаруй жилийн турш оршиж ирсэн ёөр ёөр чиглэлийн төлөөлгөгчдөөр хичээл заалтаж хүмүүжсэнэй нэмж хэлэх хэрэгтэй. Ийм учраас (явуут буюу хэвтүүзэн эмчлэх уед) өвчиний туххэнд бичсэн тэмдэглэл, нас барсны гэрчилгээ зэрэг тайлан мэдээний олон бичиг баримтад туйлын олон янзын ёөр ёөр нэр томъёо хэрэглэсэн байх нь цөөнгүй тохиолдоно.

Өдий төдий ёөр ангилал, үсгийн дарааллын жагсаалт, ангиллын бүдүүвч байгаа нь практик эмч нарын толгой эртуулж байна. Г. А. Рейнбергийн (1951) «Оношлох арга зүй» номдоо тэмдэглэснээр амбулатори, хэсэг, нэгдсэн эмнэлгийн олон эмч, ялангуяа сахнаас ажиллаж эхэлсэн залуу эмч нар нарийн ангиллыг сайн мэдэхгүй байна.

Эмч нарын практик ажилдаа хэрэглэдэг оношийн нэр томъёо хэдэн түм байдаг билээ. Тохиолддог олон төрлийн бүх өвчлөлийг бие биеэсээ өвөрмөц чухал шинж тэмдгээр ялгаатай анги, бүлэг болгон нарийн чанд системчилсэн өвчиний ангилал,

жагсаалтгүй бол өвчлөлийн тухай мэдээ баримтыг боловсруулах ямар ч арга байхгүй.

Ийм учраас больниц буюу нэгдсэн эмнэлэг бүр дор дордоо шинжлэх ухааны үүднээс тийм ч их тууштай биш ч гэсэн өөрийн гэсэн нэлээд хялбар дөхөм ангиллын схемтэй байх нь зүйтэй гэсэн Г. А. Рейнбергийн саналыг бид буруу гэж бодож байна. Нэгдсэн эмнэлэг, больниц, хот район, музкий эрүүлийг хамгаалах газар, Холбооны бүгд найрамдах улс, бүх холбоотын эрүүлийг хамгаалах яамдын хэмжээнд тус тусдаа тийм өвчиний ангилал зохио зарчмын нь ялгаатай болоход хүрнэ. Нэг тохиолдолд этиологийн шинж тэмдгийг ангиллын үндэс болгосон байхад өөр нэг тохиолдолд этиологийн болон патолог-анатомийн хоёр шинж тэмдгийг нэг зэрэг харгалзахад үндэслэсэн, гурав даах тохиолдолд хязгаарын эмгэг судалалын нозологиийн (өвчиний ангиллын тухай шинжлэх ухаан) онцлогийг нэмж харгалзсан байж ишишээтэй.

Практик эмч нар өвчиний тодорхойлолтод ихэнхдээ өөрсдийн шинжлэх ухааны мэдлэгийн явцуу хүрээ, тэр болгон хангалттай биш хувийн турцлагаар хязгаарлагдсан ангиллынхаа байр сууринеас хандаг нь бараг ёс юм. Үүнд «Цөөн бөгөөд хялбар тусмаа сайн» гэдэг зарчмыг баримтлах бололтой. Тэр ч байтугай ийм «зарчмыг» практик эмчийн оношлох үйл ажиллагаанд ангиллын схемийн заавал баримтлах үндсэн зарчмын болгон өргөмжилдэг байна. Энэ тухайд оношийн томъёолол нь аль болохуйц товч, 2—3 үгээр бүрдсэн, тэгээд:

1. өвчиний байдал төлөв,
2. өвчлөлийн байршил, бас шинжлэх ухаанад мэдэгджэй байгаа бол,

3. өвчлөлийн шалтгаан, үүслийг харуулсан байх ёстой гэж Г. А. Рейнберг (1951) үзэж байна. Үүнийхээ үлэр болгож «уушгитас» («пневмония») гэдэг маш почтв очишиг дурддээж. Гэтэл «уушгитас» гэдэг ойлголт нь олон улсын ангиллаар 7 багц буюу зөвлөлтийн ангиллаар 3 багцад хуваагддаг бүхэл бүтэн бүлгийг (ангийг) хамардаг бөгөөд Эрүүлийг хамгаалахын зохион байгуулалт, анагаах ухааны тухийн институтийн 1959 онд зохиосон үсгийн дарааллын жагсаалтаар 80 ёөр янзын уушгитасыг багтаасан, эсвэл Холбоот Орос Улсын Эрүүлийг хамгаалах яамны ариун цэврийн статистикийн товчооны 1960 онд зохиосон оношийт нэрлэн тэмдэглэх үсгийн дарааллын жагсаалтаар 36 ёөр нэр бүхий уушгитасыг хамарсан байдаг юм.

Эмч нар энэ өвчиний өвөрмөц хувилбараар нь «голомтолсон уушгитас», «хэлтэрийн уушгитас», «архаг уушгитас» гэх мэтчилэн ялгахын оронд бүгдээрээ «уушгитас» гээд ганцхан угзэр тэмдэглэдэг боллоо гэж бодьё. Тэгвэл нэгдүгээрт, оношийн томъёолол нь оновчтгүй болж, өвчиний таниагийг харуулж, тээхэлээр эмчилгээ нь хангалтгүй болно, Хоёрдугаарт, статистикчид тайландадаа «тодорхой заалтгүй уушгитас» гэсэн нэг л хүснэгтийг бөглөх бөгөөд үүнийг дутуу зэмдэг тодорхойлолт гэж үзэг юм.

Ингээд жигтэй хачин байдал бий болно. Эмчийн сэгтэлээний соёлд хатуу шаардлага тавьж, практик эмчийн оношийн шинжлэх ухааны түвшин дээшлүүлэн үнэн зөв болгохын оронд эмчийн оюун дүгнэлтийг бүдүүн тойм төдий байлгах, өвчиний ангиллын схемийг хялбарчлахыг зөвшөөрөн өөгшүүлсэн хэрэг болно. Г. А. Рейнбергийн «Оношийн арга зүй» зохиолыг эмч нарын мэргэжлийг дээшлүүлэх төв институт эрхлэн хэвлүүлсэн боловч ниймэрхүү зөвлөмж эмчийн сэгтэлзэг боловсронгуй болгоход тус дэм болох нь юу л болдоо.

Нөгөө талаар практик эмч нар өвчиний ангилахдаа өөрсдийн хялбарчилсан схемийг баримтлах юм бол Эрүүлийг хамгаалахын статистикч, зохион байгуулагч нар тус оронд байгаа өвчлөлийн тухай үнэн зөв төсөөлөл зохиож чадахгүй, ялангуяа шинжлэх ухааны үндэс бүхий өвчиний ангилал боловсруулж чадахгүй болно.

Одоо байгаа өвчиний ангиллыг «хялбарчилъя», анагаах ухааны практикийн хэрэгцээнд илүү тохиуулна гэдэгээр шалтаглан өвчиний шинэ жагсаалт хийс гэсэн уриа Зөвлөлт оронд төдийгүй, гадаадад ч дуулдаж л байна.

1978 онд Д. Фрайн «Их дэлгэрсэн өвчнүүд» гэдэг ном орос хэлээр хэвлэгдэн гарчээ. Номыг зохионч нь 25 жилийн турш гэрийн эмчээр (ЗХУ-ын хэсгийн эмчтэй ойролцоо гэж болно) ажилж байсан, одоо Дэлхийн Эрүүлийг хамгаалах байгууллагын (ДЭХБ) мэргэжилтэн юм. Тэгээд номдоо «нэг талаар эмнэлзүйч нарын практик ажиллагаа ба гэрийн эмч нарт тулгардаг асуудлууд, нөгөө талаар өөрсдийн явцуу, заримдаа сайтар бодож боловсруулаагүй үзлийн үүднээс өвчиний ангилж, нэр өгдөг академийн эрдэмтэм, мэргэжилтэн нарын практикаас хол хөндий ханллагын хооронд» асар их зөөрөө байгааг бичжээ. Тэр ч байтгугай «уушгины үрэвсэл», «гуурстас» («бронхит») гэх мэттэй их дэлгэрсэн нэр томьёог хүртэл эсэргүүцэж: «Энэ бол тохиромжтой ч гэсэн чухамдаа өвчиний ангилах, бололцоо олгохгүй байгаа ерөнхий практикт тохиолдлог эмгэгийн хэв шинжжээр өвчиний явцыг тайлбарлахад ашиг багатай «шошго» төдий юм» гэжээ. Д. Фрайн энэ мэтээр өгүүлсний эцэст уушгины цочмог өвчиний шинэ ангиллыг санал болгосон нь:

1. Цээжний хөндийн цочмог хэржигнуур: гол шинж нь цээжний хөндийн хоёр талд нэвчнig хуурай хэржигнууртэй, заримдаа сарнимал нойтон хэржигнууртэй.

2. Байршсан нойтон хэржигнууртэй өвчтөн: нэг буюу хоёр уушгини угийн нэг хэсгийн дээд талаар уйссэн юмуу нарийн хэржигнууртэй, эсэвл шарчигнах чимээтий. Заримдаа иймэрхүү үзэгдэл нэгээс илүү хэсэгт ажиглагдана.

3. Гялтан (плевра) юмуу гялтангийн холбоос үрэлдэх шуугиан сонсогддог, уушгини хэсэг нь шүүурсэлтэй буюу амьсгалд оролцохгүй болсон өвчтөн. Ийм өвчтөн цөөн байдаг.

4. Байдлыг бүрэн дүүрэн харуулахын тулд (эмчийн үзлэгийн үед илрүүлж болохууц) өвчиний физик шинж тэмдэг байх-

гүй ч халдварт авсан байж болох рентген шинжилгээний шинж илт' мэдэгдсэн тийм тохиол байж болохыг дурдах хэрэгтэй гэжээ.

Шинжлэх ухааны үнэнийг хялбарчлах гэж оролдвол ийм болдог байна шуу! Энд нэрд гарсан хүүхдийн эмч А. А. Кисаль: «Шинжлэх ухааны анагаах ухаан гэж ганц л анагаах ухаан байдаг, үүнээс жичдээ практикийн анагаах ухаан гэж огт байхгүй гэсэн санааг би үргэлж давтан хэлж байдаг. Эмч хүн өвчтөн бүрд орчнүүдийн шинжлэх ухааны мэдлэгээр өвч зөвсэглэн хандах ёстой» (В. А. Еренков, Л. Д. Фастовец, 1977) гэж хэлсний энд иши татах нь зүйтэй.

Эмч нар бүгдээрээ заавал дагаж баримтлах ёстой нэгдмэл нэгэн мөр өвчиний ангилал боловсруулах явдал зайлшгүй чухал зорилт мөн бөгөөд энэ зорилтыг шийдвэрлэхгүй бол практикийн ба онолын анагаах ухааныг амжилттай хөгжүүлэх, эрүүлийг хамгаалах ажлыг зохион байгуулах боломжгүй нь илрүхий байна. Өвчиний жагсаалт ангиллыг тогтоосход холбогдох нэр томьёог дээрээс өгсөн удирдамжаар нэг мөр болгох аргагүй нь ойлгомжтой. Өвчиний тэмдэглэх тохиролцсон нэр боловсруулах хэрэгтэй бөгөөд энэ нь зөвлөлтийн эрүүлийг хамгаалах аливаа системийн эмч нар аль нэг хэмжээгээр ижилхэн утгаар ойлгож, нийтээр хүлээн авч болохууц нэр байх ёстой.

Анагаах ухаагын суулийн үеийн оолот, зөвлөлтийн эрүүлийг хамгаалахын практик эрэлт хэрэгцээг тусгасан, аргазүйн шаардлагыг харгалзсан шинжлэх ухааны үндэстэй өвчиний нэгдмэл системчлэл, ангилал зохионий тулд төрөл төрлийн салбарын хөргөн хүрээний мэргэжилтэн нарыг хамраан оролцуулж, байнга ихээхэн ажил хийх хэрэгтэй байна. Энэ бол нийт улсын хэмжээний маш чухал зорилт мөн гэж бид бодож байна.

Анагаах ухааны эрдэм шинжилгээний байгууллагууд голлох уүрэг гүйцэтгэх ёстой. Бүх Холбоотын хэрэх өвчиний эсэргүүцэх хорооны (антиревматический комитет) хийж байгаа ажил бол өөрийн салбарын хүрээнээс өвчиний жагсаалт, ангиллыг байнга боловсронгуй болгох талаар үр бүтээлтэй ажиллаж байгаагийн үлгэр жишээ болж чадна. Хэрэх өвчиний судлал (ревматология) шинжлэх ухааны нэг салбар болон хэлбэрэлтгүй хөгжжик ирээнтэй уялдуулан 1934 оноос хойш тус хороо хэрэх өвчиний ангиллыг 4 удаа хянан засварласан байна. Сүүлийн хувилбарыг нь 1964 онд хэрэх өвчиний ажлын ангилал, жагсаалтын асуудлаарх симпозиум дээр Зөвлөлтийн томоохон ревматологч А. П. Нестеровын илтгэлийн дагуу баталжээ. Бүх Холбоотын хэрэх өвчиний эсэргүүцэх хороо үе мөчний өвчиний ангилал, жагсаалтыг боловсронгуй болгох талаар мөн нэгэн адил тууштай системтэй ажиллаж байна.

Гэхдээ дурдсан чиглэлд мэргэжилтэн нарын гаргаж байгаа хамтын хүчин чармайлт тэр болгон гүйцэд амжилттай болж чаддагүй нь мэдээж. Жишээ нь Минск хотноо пульмонологийн (уушки, амьсгалын замын эмгэгийг судлах салбар ухаан)

симпозиумаар (1964) баталж, Тбилис хотноо. Бүх Холбоотын дэвтрын эмч нарын эрдэм шинжилгээний нийгэмлэгийн бүгд хурлайлар (1972) нэмэлт оруулсан архаг уушгитасын ангиллыг хэлж болно. Өвчин ба үхлийн шалтгааны шинэ жагсаалт, ангилал зохиходоо эх орны жагсаалтыг олон улсынтай байртуулах зорилго тавих нь чухал. Учир нь эдийн засаг, соёл, эрүүлийг хамгаалахын зэрэг салбарт зөвлөлтийн олон улсын хэлжээ холбоо өргөжиж байна. Зөвлөлт Холбоот Улс болон гадаад орны ард иргэдийн өвчлөлт, үхлийн шалтгааны тухай ариун цэвэр-статистикийн материалыг жишиж судлах щаардлага улам их гарч байна. Ийнхүү харьцуулан судлах нь Зөвлөлтийн Эрүүлийг хамгаалахын ололт, дутагдлын аль алиныг тодруулж мэдэх болошоо олгоно.

Ажилд нь зөвлөлтийн эрдэмтэд ч оролцдог олон улсын анагаах ухааны зарим нийгэмлэг шинжлэх ухааны үндэстэй өвчин ангилал зохион талаар амжилттай ажиллаж байна. Чихэр шижингийн (сахарный диабет) талаар ДЭХБ-ын мэргэжилтний хорооны хийж байгаа ажлыг жишээ болгон дурдаж болно. Тус хорооны зөвлөмж болгосон чихэр шижингийн ангиллыг язь бүрийн орон, тэр дундаа ЗХУ-ын эмч нар 15 жилийн турш амжилттай ашиглаж ирлээ. 1980 онд санал болгосон шинэ ангилал нь мэргэжилтэн нарын (М. П. Балаболкин, 1981) үзэж байгаагаар шижин өвчиний эмгэг гарал, эмнэлзүй, эмчилгээг судлах талаар шижин судалалын шинэ амжилтыг аятайхан тусгажээ. Өөр нэг жишээ хэлбэрэл элэг хатуурах өвчиний (ширроз печени) Гаванын хуучин ангиллыг (1956) 1974 онд Мексикт болсон их хурлаар элэг судлах асуудлаарх Дэлхийн Холбооны баталсан бөгөөд гепатологийн (элэг судлалын) орчин үеийн байдалд тохирсон шинэ ангиллаар сольсон байна (Е. С. Рысс, 1983).

Бид энэхүү бүлэгт уг асуудлаас хамгийн чухал гэж үзсэн аргазүйн зарим талыг л авч ярих байна.

Формаль логикийн үүднээс бол ангиллын үндсэн зорилт нь эгнэн зэрэгцсэн ойлголтын (ангийудын) аль нэг хэмжээгээр нарийн чанд систем зохих замаар нэгэнт хуримтлуулсан мэдлэгийг системчлэхэд оршино. Нийт ойлгоцыг хуваах, судалгааны зүйлээ төсөөтэй буюу ялгаатай шинжээр нь цэгцэлэн хуваарилах логикийн дурмийг үндэслээн ангилыг зохион.

Туслах чанарын ач холбогдол бүхий хэлбэрийн (зохиомол) ангилал гэж байдаг. Учир нь дураараа сонгож авсан онцын чухал биш шинж. Тэмдгийг уг зүйлээ ялган будэглэхийн үндэс болгосон байдаг. Эмнэлгийн байгууллагын тайлан мэдээ, статистикийг журамлахад туслах чанарын схем болж өгдөг өвчиний жагсаалт, угсийн дарааллын нэрсийг ийм ангилалд хамааруулж болно.

Үүний сацуу нэг чухал өвөрмөц шинжийг (ниймэл нарийн ангилалд бол хэд хэдэн шинжийг) үндэс болгон зохиосон жам ёсны (агуулгын) ангилал гэж байдаг. Жам ёсны ынгилалт бол ихээхэн нарийн чанд цэгцэлсэн судалгазны объектыг эрхэд тус

дэхөм болохоор үл барам, судалж. байгаа зүйл, тэдгээрийн шинж, харилцаат шинжлэх ухааны үндсэн дээр ихээхэн тогтвортой системчлэх болоцоо олгоно. Ийм учраас бодит байдлыг шинжлэх ухааны үүднээс танин мэдэх, судалж буй объектыг түүний шинжээр тодорхойлох буюу хэрэв уг объектын анги нь мэдэгдэж байгаа бол шинжийг нь тогтооход тус болж чадна. Өвчиний жам ёсны ангилал нь өвчлэлийг ихээхэн үнэн зөв танихад тус болно. Учир нь өвчиний оношлохдоо тийм ангилал байхгүй бол учирзуун хувьд зөв үндэслэж, ялган салгах аргагүй юм. Машинаар онош тавих, эмнэлгийн мэдээллийг залууруйн аргаар боловсруулах щаардлага хийтэд эрдэм шинжилгээний, ариун цэвэр-урьдчилан сэргийлэхийн, зохион байгуулалтын ажлын эрх ашигийн үүднээс ч ийм ангилал зайлшгүй хэрэгтэй байна.

Зөв зохиогдсон ангилал бол ойлголтыг ялган хуваахад холбогдох хэд хэдэн щаардлагыг хангасан байх ёстой.

1. Анги болгож хуваахдаа нэгдмэл нэг үндсийг (шинж тэмдгийг) баримталаа. Ангийг дэд анги болгон олон удаа нарийвчлан хуваах болбол тухай бүрд жич үндсийг ашиглах болову тэр нь нэг л үндэс байх учиртай. Ингэхдээ ерөнхий ангиуд нь ихээхэн өргөн чухал үндэстэй, ангиудын тусгайдаа салбар нь ихээхэн явцуу, өвөрмөц үндэстэй байна. Гэвч анги (этнэ), бүрийг нэг л нэгдмэл үндсээр хуваана. Жишээ нь: Г. А. Алексеев цус багасах (анемия) өвчиний ангилахдаа эхлээд эмгэг шинжээ нь; 1. цус алдсанаас (пост-геморрагический) цус багасах, 2. цусны эргэлт гажсанаас цус багасах, 3. цусны задрал ихэссэнээс (гемолитический) цус багасах гэж ангилжээ. Цусны задрал ихэссэнээс цус багасах энэ суулчийн дэд ангиг ихээхэн явцуу өвөрмөц шинж тэмдгээр нь: 1. экзоэритроцитийн цусны задрал ихсэх хүчин зүйлийн улмаас цус багасах, 2. Эндоэритроцитын хүчин зүйлийн улмаас цус багасах гэж хоёр шинэ дэд ангид хуваажээ. Үүнээс цааш нь «эндоэритроцитын хүчин зүйлийн улмаас цус багасах» дэд ангийг: 1. эритроцитопати, 2. энзимопати, 3. гемоглобинопати гэж гурван бүлэгт хуваагаад бас цааш нь гемоглобинопатийг дотор нь: 1. талассеми (цус цайж багасах), 2. эс махирлаж цус багасах (серповидно-клеточная анемия), 3. С, Д, Е. Н гэх мэтийн гемоглобинопатии гэж ялгасан байна.

Харамсалтай нь өвчин, бэртэлт ба үхлийн шалтгааны олон улсын статистикийн ангилалд энэ журмыг баримтлаагүй нь түүний ялгаж заасан гол гол хэсгийг тоочиж ход л илт мэдэгдэнэ. Нийтдээ 17 хэсгийг ялгаж заасан нь: «Халдварт ба шимэгчийн үүсгэдэг өвчин», «Шинэ тогтоц», «Дотоод шүүрлийн (эндокринная) системийн өвчин, хоол тэжээл хямрах, бодисын солилцоо, дарклас алдагдах», «Цус ба цус бүтээгч эрхтний өвчин», «Сэтгэцийн хямрал», «Мэдрэлийн систем ба мэдрэх эрхтний өвчин», «Цусны эргэлтийн системийн өвчин», «Амьсгалын эрхтний өвчин», «Хоол боловсруулах эрхтний өвчин», «Шээс бэлгийн эрхтний өвчин», «Жирэмслэл, төрөлт, тө-

рөлтийн дараах үеийн хүндэрэл», «Арьс ба арьсан доржийн эслэгийн өвчин», «Яс бүлчингийн» систем, холбоо нэхдэсийн өвчин», «Төрөлжийн гажийн», «Төрсний дараах үед үүсэх зэфир байдал», «Шинж, шинж тэмдэг «башновчгүй тэмдэглэсэн байдал», «Бэртэлт, хордлого» эдгээр болно.

Иймийүү өвчлэлийн яиз бүрийн ангийг янз бүрний шинж тэмдэгээр ялгасан байх бөгөөд үүнд; өвчиний этиологор (халдварт ба шилмэгчийн үүсгэдэг өвчин), эмгэг гарлыйн ышилогоср» (төрсний дараах үед үүсэх зэфир байдал), байршилаар (амьсгалын эрхтний өвчин), тэр ч байтугай эмнэлгийн нэр томъёо гүйцэд боловсроогүй, оновчтой бус байгаа баримтын үндсэн дээр (шинж, шинж тэмдэг ба оновчгүй тэмдэглэсэн байдал) гэх мэтчилэн хуваажээ.

Өвчиний тангийг дэд анги, дэд ангийг бүлэглэл болгоож хуваахдаа нэгдмэл үндсийг баримтлах зарчмыг зөрчсөн байна. Жишээ нь: «Мэдрэлийн систем, мэдрэхүйн эрхтний өвчин» ангийг дэд анги болгоходоо этиологийн болон байршилын үндсийг нэг зэрэг баримтлан ялгажээ.

«Ходоодтос» (гастрит) ба дуодонит» багцад: цомног ходоодтос, хатингар ходоодтос, ходсодны салст «бүрхүүлийн томролт, архины ходоодтос, бусад ходоодтос, нарийн мэдэгдээгүй ходоодтос ба гастродудонит, дуодонит гэж 7 дэд багцыг ялгасан байна. Энд төрлийн тухай ойлголтыг өвчиний язцын шинж төлөв, ходоодны салст


бүрхүүлийн хэлбэрийн өөрчлөгдлийн хэв маяг, үрэвслийн явцын байршил аль алисаар нь хуваажээ. Үүнтэй уялдан «нарийн мэдэгдээгүй ходоодтос» гэдэг нэр томъёо, тоор юу хэлсэн нь тодорхойгүй байна. Этиологийг нь уу, өвчиний явцыг уу, ходоолны салст бүрхүүлийн байдлыг уу, эсвэл өөр нэг юмыг нь нарийн тодруулаагүй хэрэг үү?

Өвчин бэртэлт ба үхлийн шалтгааны олон улсын ангиллыг зохиогчид заримдаа гойдын хэрэгцээгүй байхад ацлан хуваах (дихотомическое деление) аргыг хэрэглэсэн байна. Жишээ нь: дотоод шүүрлийн системийн өвчиний ангид «Бамбай булчирхайн өвчин» болон «Дотоод шүүрлийн бусад булчирхайн өвчинийг» оруулаад ингэхлээр энэ хоёр дахь дэд ангид өнчин тархи, бөөрний булчирхай, өндгөвч зэргийн маш олон язнын өвчлөлийн хамруулсан байна.

Хэрэв жишээ нь эхний хуваарилалтыг ерөнхий этиологийн шинжээр хийж, үүний үр дүнд солилцооны өвчин, халдварт өвчин, бэртэлт зэргийг өвчлөлийн том том бүлэглэлд ялгасан бол өвчиний ангилал нь илүү зөв болох байлаа. Цааш нь эдгээр бүлэглэлийг этиологийн нэлээд өвөрмөц нарийн шинжээр нь задлан хувааж болох юм. Жишээ нь: халдварт өвчиний вирусийн, янгийн (бактерийн) гэх мэтчилэн анги болгоож болох байв!

Халдварт өвчиний этиологийн зарим тусгай шинжээр нь хуваасны дараа өвчлэлийн ангийг дэд ангид хуваах дараачийн

### I схем. ЧИХЭР ШИЖИНГИЙН АНГИЛАЛ



<sup>1</sup> Харамсалтай нь зарим өвчиний этиологийн тодорхой бус, зарим өвчин этиологийн хувьд олон давхар шинжтэй байдгийн улмаас энэ зарчмыг бүрэн дүүрэн хэрэглэх боломжгүй юм. Анагаах ухааны мэдлэгийн одоогийн түвшинд этиологийн шинжээр бус, анатомын байршилын шинжээр хувааж эхлэх зүйд нийлэмжтэй байж болох авч хэрэв интэвэл зөвхөн үүнийгээ үндэс болгон баримтлаад дараа нь өөр маягаар хувахад шилжих хэрэгтэй юм.

үндэс болгон байршлын шинжийг авч болох юм (жишээ нь уушгини сурьеэ, яс-үе мечний сурьеэ, гэдэсний сурьеэ гэх мэт). Өвчиний эдгэр багц (дэд анги) тус бурийг хэлбэр-үүргийн өөрчлөгдлийн шинж байдлаар нь зүйл болгон хувааж болох юм (жишээ нь, уушгини ширхэгээг тогтох сурьеэ, уушгини сийрхий ширхэглэх сурьеэ, уушгини үсэрхийлэх сурьеэ гэх мэт).

Анги, дэд анги, зүйл бурийг тусад ялган задлахад болохгүй гэх газаргүй. Зарим бүлэг өвчиний (хүүхдийн, эмэгтэйчүүдийн) бие даасан байдлаар ангилж болох бөгөөд харин нэг л ерөнхий шинж тэмдгийг баримтлах ёстой. Хуваарилалтын бүх энээг цэгцэлж, журамласан өвчиний нэгдмэл ангилал бий болгоыг эрмэлзэх нь зүйтэй. Нэгдмэл нэг үндсийг баримтлан дагахгүй бол хуваарилалт нь будлиантай давхардмал болж, үүний улмаас бүх анги-лал нь буруу ташаа болгоход хүрнэ.

2. Ангилал зөв байхын чухал нөхцөл нь хуваарилалтын хэмжээ ямагт зохицсон байхад оршино. Энэ бол хуваарилалтын бүх гишүүдийн (ойлголтын зүйлийн) нийлбэр нь ангийнхаа (төрлийн ойлголт) бүх хэмжээг бүрэн хамран багтаасан байх ёстой гэсэн уг юм.

Эс тэгвэл хуваарилалт нь буруу болж нэг бол хэтэрхий өргөн, эсвэл хэтэрхий явцуу болно. Жишээ нь, «уушгин зүрх» гэдэг ойлголтыг архаг ба цочмог хэмээн хувааж, цочмог хэлбэр нь хэд хэдэн хувил-

бартай байж болохыг харгалзахдаа дэндуу явцуу хуваарилалт хийж байгаа хэрэг. Бас цусны эргэлтийн өвчиний ангид холбох, нэхдэсийн нэвчих өвчинийг (диффузные болезни соединительной ткани) оруулбал ийм хуваарилалт нь үндэсгүй өргөн болно. Анаагаах ухаан шинэ шинэ зүйл, хувилбарын өвчиний нээн илрүүлж, ангиллыг байгана нөхөн дүүргэсээр байгаа учир эгнээ бурд хуваарилалтын шинээр нээгдсэн гишүүнийг нэмж бичих зайд үлдээвэл зохино.

Өвчин, бэртэлт ба ухлийн шалтгааны Олон улсын статистикийн ангилалд ангиллын эгнээ бүр нь «бусад өвчин», «бусад гажиг», «нарийн мэдэгдээгүй байдал» гэсэн дэд антиар (багц, дэд багцаар) дууссан байна. Энэ ойлголтын хэмжээ төдий л тодорхой биш учир энд хуваарилалтын хэмжээг зөв зохицуулж чадсан эсэх асуудал эргэлзээтай хэвээр үлддэжэ.

Бидний энд авч үзэж байгаа журмыг заримдаа зориуд зөрчиж байна. «Проблемы эндокринологии» («Дотоод шүүрлийн булчирхай судлалын асуудал») сэтгүүлд (1984, № 3) ДЭХБ-ын мэргэжилтний хорооны баталсан чихэр шижингийн ангиллын талаар өргөн шүүмжлэл нийтэлж эхэлжээ. В. Г. Баранов, А. М. Ситникова, А. С. Ефимов нар уул ангилалд урьд баримталж байсан шижингийн урьтал уе, далд шижин, цл чихэр шижин гэж өвчин ахих шатаар нь хувааж байсныг оруулсангүй гэж ангиллыг зохиогч нарыг зэмлэсэн байна (1 схем).

# ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

## ӨРХИЙН ЭМЧИЙН ЗАГВАР

Ц. Мухар

Эмнэлгийн үйлчилгээний нутаг дэвсгэрийн хэсэг (сум)-ийн эмнэлгийн зарчим бол хүн амд амбулатори-поликлиникээр үзүүлэх тусlamжийн шалгарсан арга мөн. Зөвхөн хэсгийн үйлчилгээний зарчмаар сэргийлэх, эмчлэн эрүүлжүүлэх номлол биелж амьдралд хэрэгжинэ.

Эмч, хүн амыг нягт холбосон хэсэгчилсэн үйлчилгээний ур дунд, нутаг дэвсгэрийн үйлчилгээний хүн нэг бурийг эрүүл мэнд-эмнэлзүйн хувьд танин мэдэх боломжийг бүрдүүлж эрт оношлох, өвчнийг тууштай эмчлэх, сэргийлэх, диспансерчлах нөхцөл бий болдог байна. Сүүлийн үед эмнэлгийн хэсэгчилсэн үйлчилгээг өрхийн зарчмаар зохион байгуулж, улмаар ерөнхийн мэргэжлийн буюу өрхийн эмч бэлтгэх, ашиглах галаар судлагч, мэргэжилтнүүд нэлээд бичиж байна (А. Е. Ромоненко 1987, Ш. Жигжидсүрэн, Ц. Мухар 1987, С. А. Сыгаев 1988, А. А. Солнцев, Р. Р. Шиляев и др 1988, Б. О. Мильков, Г. И. Шамрой и др 1988).

Өрхийн эмч бэлтгэх, ашиглах нь орчин үед хурц шүүмжлэж байгаа эмчийн ёсзүй, ур чадварын өсөлттөд нөлөөлөх гол хүчин зүйл болж болох юм. Өрхийн эмч бий болсноор хүн ам-эмч гэсэн холбоо өрх гэр-хүн ам-эмч болж бэхжих болно. Эмчийн ажлын хүрээ тэлж, мэргэжлийн явцуу хүрээнээс гарч эмчийн ур чадварын өсөлт хангагдахын хамт эмч өвчтөн, эрүүл хүмүүсийн харьцаанд эмчийн ёсзүйн агуулга улам баяжих юм. Ерөнхий мэргэжлийн ба өрхийн эмчийн үйлчилгээнд шилжих тухай асуудлыг ЗХУКН-ын Төв Хороо, СнЗ-өөс баталсан «2000 он хүртэлх хугацаанд ЗХУ-ын хүн амын эрүүл мэндийг хамгаалах, эрүүлийг хамгаалахыг өөрчлөн байгуулах үндсэн чиглэл»-д нэг ч/хэл зорилт болж тусгажээ.

1984 оноос Куба улс өрхийн эмчийн үйлчилгээнд шилжиж эхэллээ (С. А. Сыгаев 1988, Д. И. Кича 1989). Өрхийн эмчийн үйлчилгээ бол хөгжингүй капиталист орны хувьд уламжлал туршлагатай, шинжлэх ухаан техникийн өнөө үеийг хүртэл ач холбогдоо алдаагүй бөгөөд эмнэлгийн шинжлэх ухааны дагнал, төрөлжилт түргэн явагдаж байгаа энэ зууны эцэст улам өсөх болжээ.

ЗХУ-д өрхийн эмч бэлтгэх, ашиглах тухай хоорондоо зөрчилтэй хэд хэдэн санал шүүмж өрнөж байна. ЗХУ-ын ЭХЯ өрхийн эмчийг ашиглах чиглэлд баттай зогсож байна гэж үзэж болно. Н. А. Семашкогийн нэрэмжит нийгмийн эрүүл ахуй, эрүүлийг хамгаалахын эдийн засаг, удирдлагын эрдэм шинжилгээний институтээс боловсруулсан өрхийн эмчийг ашиглах гурван хэлбэрийг ЗХУ-ын ЭХЯ дэмжиж олон нийтээр хэлэлцүүлж байна. Өрхийн эмчтэй болох саналыг хүн амын бараг 90% дэмжиж байна. Гэтэл эмч нарын олонхи нь өрхийн эмчээс татгалзаж, дотор, хүүхэд, эх барих-эмэгтэйчүүдийн чиглэлээр олон жил мэргэжиж, дадлагажсан хэсгийн эмнэлгийн системийг бутаргах нь олсон ололтоосоо ухарсан алхам, ялангуяа эх нялхсын салбарт мэргэжлийн тусламж до-голдоно гэж үзэж байна.

Ерөнхий мэргэжлийн өрхийн эмч ажиллуулах нь шинэ хэлбэр болох учраас бэрхшээлтэй, маргаантай байх нь ойлгомжтой юм. ЗХУ-д нэг эмч гэр булийн бүх гишүүдэд (дотор, хүүхэд, эмэгтэйчүүд) амбулатори-поликлиникийн анхны тусламж үзүүлэхэд мэргэжлийн хувьд бэрхшээлтэй болно гэж үзвэл до-лоо хүртэлх насны хүүхдийг хүүхдийн эмч үзэхээр, эсвэл эмч нар нэг баг болж айл өрхөөр үйлчлэх хэлбэр байж болох юм гэж томъёолж байна. Гэвч сүүлийн хоёр хэл-

бэр бол мөн чанартаа өрхийн эмчийн зарчим биш гэсэн санаа байна.

Профессор О. П. Шепин, эрдэм шинжилгээний ахлах ажилтан В. Козлитон нар «Медицинская газета» сонинд бичсэн «Амьдралгүй узэл санаа явуургүй» гэсэн өгүүлэлдээ өрхийн эмчийн маргаанд дүгнэлт хийж «Эмнэлгийн тусламжийн чанарыг ялангуяа анхан шатны хүрээнд сайжруулах үүднээс авч үзэхэд өрхийн эмнэлэг бий болгох талаар эргэлзээ байхгүй гэсэн ганцхан дүгнэлт хийж болно. Дотрын биш тусламжийн хүрээг оролцуулан өрхийн бух гишүүдэд сэргийлэх, эмчлэн оношлох, нөхөн сэргээх тусламж үзүүлж чадах чадвар бүхий өрхийн эмчийн тухай бид тодорхойлж болно. Манай оронд хүүхдийн тусламжийн алба сайтар хөгжсөн туршлага дээр үндэслэн өрхийн эмнэлгийн загварт З хүртэлх насын хүүхдэд эмнэлгийн туслаамж үзүүлэхэд зориулж хүүхдийн эмчийг байлгаж ч болох юм. Өрхийн эмчийг дээд сургуулийн тусгай программаар бэлтгэх ёстой» гэж бичсэн байна. Дээрх зохиогчид өрхийн нэг эмчид оногдох хүний тоог ул суурьтай судалгааг үндэслэн тогтоох нь зүйтэй бөгөөд гурав хүртэл насын хүүхдийг мэргэжлийн эмч үзнэ гэж тооцвол нэг эмчид 1000—1500 хүн байх нь тохиромжтой гэж үзэж байна.

Куба улсад өрхийн эмчийн талаар богинохон хугацаанд багагүй туршлага хуримтлуулж байна. Ана-гаах ухааны талаар ойрын хорин жилд дэлхийн дээд түвшинд хүрэх зорилго тавьж зурх шилжүүлэн суулгах хагалгаа эхэлсэн энэ оронд өрхийн эмчийн үйлчилгээ сонгодог хэлбэрээр хөгжиж байна. Куба улсад өрхийн эмч-сувилагчийн баг байгуулж, үйлчлэх хүрээний нутаг дэвсгэрт хоёр давхар бага оврын барилга барьж доод давхарт нь өрхийн эмнэлгийн салбар, дээд давхрыг нь эмч, сувилагч нарын орон сууц болгон ашиглаж байна. Эмч-сувилагчийн нэг баг 600—700 хүн амд (120—140 гэр бүл) үйлчилж байна. Тэд эмнэлгийн бараг нийж бүрэн үйлчилгээг гүйцэтгэж эмч-

лэх, нөхөн сэргээх төдийгүй эрүүл хүмүүсийг өвчинөөс сэргийлэх, эрүүл мэндийг бэхжүүлэх үүрэгтэй юм. Үүний тулд эмчилгээ, эрүүл мэндийн хяналтаас гадна өвчтэй хүмүүсийг гэрээр идэвхтэй эргэж, шаардлага гарвал эмнэлэгт өвчтнийг өөрөө биеэр хүргэх зэргээр үйлчилгээний нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндийг шийдвэрлэх бүх асуудалд идэвхтэй оролцож, эмчээс хүний төлөө тавих ухамсартай са-хилга хариуцлагыг өндөржүүлсэн байна.

Куба улсад 1987 онд 4 мяняган өрхийн эмч байсан бөгөөд өрхийн эмчийг бэлтгэх хөтөлбөрийн дагуу 2000 он болоход 20 мяняга болж өснө. 1990 онд сийролцоогоор Куба улсын хүн амын 68% нь (7 сая хүн ам) өрхийн эмчтэй болно. Гаван хотынхон 1993 он болоход өөрийн гэсэн өрхийн эмч, сувилагчтай бо-лохоор төлөвлөж байна. Куба улсад дээд сургуульд эмч нарыг ерөнхий мэргэжлээр төгсгөж эхний нэг жил өрхийн эмчийн дадлага хийж цаашид турван жил анагаах ухааны ерөнхий эрдэмд суралцаж мэргэжинэ. Дээд сургууль төгссөний дараах 4 жилд өрхийн эмчийн мэргэжил дадлага суусан эмч нар өрхийн эмчээр ажиллах, өөр мэргэжил сонгох эсэхийг өөрсдөө шийддэг ажээ. Өрх гэр, эрүүл мэндийн салшгүй хоёр тал болсон нийгмийн ба эмнэлгийн иж бүрэн агуулга хэлбэр болдгийг судлагчид (И. П. Кашково 1987, В. Н. Городов, И. К. Баготова и др 1989, Н. А. Кравченкая, З. А. Хуснутданова 1989) нэгэн дуугаар зөвшөөрч байгааг өрхийн эмчийн ач холбогдолтой холбогдох нь зүйтэй.

Манай оронд өрхийн эмч бэлтгэх, ашиглах талаар тодорхой ажил хийгээгүй боловч, албан ёсны хурал зөвлөлгөөн, нийтийн хэвлэлд өрхийн эмчийг бэлтгэх, эсэх талаар зарим санал гарч байна. Бид өрхийн эмчийг бэлтгэх, ашиглах талаар бусад орнуудын туршлагыг хэвлэлээс судалж, зарим дүгнэлт өгөх оролдлого хийлээ.

Түүхэн уламжлалаас үзвэл манай оронд зөвхөн гэрээр өвчтөн

үзэж эмчилдэг уламжлалт эмнэлэг олон жил үйлчилж байсан бөгөөд ардын хувьсгалын дараа 60-аад оныг хүртэл эмчийг ерөнхий мэргэжлээр ашиглаж байсан юм. Үйлчилгээний хүн амын тоо олон байгаа боловч сумын эмч нар өрхийн эмчтэй төстэй зарчмаар ажиллаж, Улаанбаатар хотод 80-аад оноос дотрын хэсгийн эмч нар өрхийн диспансерчлалын хэлбэрээр өрхийн эмчийн зарим элемент эмнэлгийн үйлчилгээнд нэвтэрч иржээ. Энэ бүхэн нь өрхийн эмчийг цоо шинэ хөрсөн дээр бий болгохгүй, харин сэтгэл зүйн хувьд уламжлал, туршлага дээр тулгуурлах боломж байгааг харуулж байна.

Хүн амыг үе шатлан диспансерчлах туршилт судалгааны зарим урьдчилсан дүнгээс авч үзвэл хот, хөдөөгийн хүн амын 92% өрхийн эмчтэй болохыг зүйтэй гэж үзсэн байна. АУДЭС-ийн курст суралцаж байгаа 55 эмч нараас судалгаа авахад эмч нарын мэргэжил олгох курст сурч байгаа эмч нарын 70,7%, дээшлүүлэх курст суралцагчдын 57,1%, ерөнхий мэргэжлийн (өрхийн) эмч бэлтгэхийг дэмжиж, 24,4—42,9% нь эргэлзсэн байна. Хот, хөдөөгийн 130 эмч нараас авсан асуумжаар 77,4% нь өрхийн эмч бэлтгэх асуудлыг зүйтэй гэсэн дүгнэлт хийж байна. Ийм санал өгсөн эмч нарын 47,5% нь дотор, хүүхэд, эх барих эмэгтэйчүүдийн анхны тусламжийг нэг эмч үзүүлж чадна гэж үзсэн байна. Энэ урьдчилсан дүнг ЗХУ-д хийгдсэн судалгаатай харьцуулбал өрхийн эмчтэй байх талаар хүн амын санал бараг нэг түвшинд (80—90%) байгаа нь хэсгийн эмнэлгийн үйлчилгээнд өөрчлөлт шинэчлэлт хийх хэрэгтэй байгааг илэрхийлсэн үзүүлэлт. Харин манай эмч нар өрхийн эмчтэй болох талаар зөвлөлтийн эмч нараас илүү санал өгч байгааг ерөнхий мэргэжлийн үйл ажиллагааны уламжлал, манай орны өрхгэрийн онцлог, зан заншилтай холбон үзэх нь зүйтэй.

Өрхийн гишүүдийн эруул мэндэд үнэлгээ өгч, тэдний эруулжүүлэхэд чиглэсэн эмнэлэг-нийгүйн

иж бүрэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх явдал өрхийн эмчийн үндсэн чиг баримжaa мөн.

Өрхийн эмчийн ажиллагаа нь сэргийлэх, оношлох, эмчлэх, зохион байгуулах чиглэлтэй. Өрхийн эмчийг зөвхөн эмнэлэүйч төдийгүй нийгмийн эруул ахуйч байх түвшинд ажиллахыг амьдрал шаардана. Өрхийн эмчийн ажлын агуулга, хэсэг сумын эмч нарын ажлаас нэлээд онцлогтой юм гэдгийг зөвхөн дотор, хүүхэд, эх барих эмэгтэйчүүдийн мэргэжилтэн төдийгүй өөрийн онцлогийг агуулсан шинэ маягийн хэсгийн эмнэлгийн алба гэдгээр тайлбарлана. Үүнээс ямар дүгнэлт хийх вэ гэвэл өрхийн эмч бэлтгэх, мэргэжлийг нь дээшлүүлэх талаар түүний ажлын онцлогт тохирсон систем бүрдүүлбэл зохицно. Өрхийн эмч дараах үүрэгт ажлыг гүйцэтгэж болох баримжaa байна.

1. Урьдчилан сэргийлэх чиглэлээр:

— Өрх болгоныг хараандaa авч, эруул мэндийн сөрөг хүчин зүйлийг илрүүлэн арилгах, эруул аж төрөх ёсонд сургах.

— Эх нялхсын эмчлэн сэргийлэх бүх арга хэмжээ (гэр бүлийн төлөвлөлтөнд тусалж, хэрэгжүүлэх тухай цоо шинэ ажлын хүрээ бий болно).

— Эруул ахуй халдварт судлал  
2. Оношлох, эмчлэх чиглэлээр:

— Амбулатори-поликлиник, гэрээр үзүүлэх тусламжийн хамгийн элбэг тохиолдох дотор, хүүхэд, эх барих эмэгтэйчүүдийн өвчнийг судлах, шинжлэх арга, оношлол, эмчилгээ, ялгах онош.

— Эмнэлзүйн түгээмэл асуудал (хам шинж, хордлогууд, харшил судлал, антибиотик, дааврын гаралтай эмийн хэрэглээ, бага халууралтай өвчний хамшинж, мэдрэл, тархи-судасны үйл ажиллагааны хямрал).

— Архаг (арьс өнгө, сурьеэ, бруцеллез), хурийн халдварт өвчний онош.

— Яаралтай мэс заслын өвчний онош

— Уламжлалт анагаах ухааны уламжлалт арга (барна засал, зүүтгээнүүр, хануур, орон нутгийн ургамал амьтны гаралтай эм бэлдмэл хийж хэрэглэх арга барил).

3. Эрүүлийг хамгаалах чиглэлээр:

— Хүн амын эрүүл мэнд, өвчлөлд дүн шинжилгээ хийж авах арга хэмжээг боловсруулах.

— Дээд шатны эмнэлэг, поликлиникээр үзүүлэх тусlamжийг шуурхай хүртээмжтэй болгох.

— Ахнадагч, хоёрдогч сэргийлэлтийг хэрэгжүүлэх.

— Хөдөлмөрийн чадварын үнэлгээ өгөх, нөхөн сэргээх ажилд оролцох.

— Эмчийн ёсзүйд төгс боловсрох

Өрхийн эмч бол одоогийн хэсгийн эмнэлгийн дэвшилт хэлбэр болж нутаг дэвсгэрийн амбулатори-поликлиникийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг болж ажиллана. Ийм учраас хэсгийн эмнэлгийн байршилын одоогийн зохион байгуулалт эвдэгдэхгүй.

Өрхийн эмчийн кабинетыг наад захын шаардлагатай авсаархан тоноглох ёстой (А. И. Патанов 1988). Хүний эрүүл мэндийн талаар өрхийн эмчийн ёсзүй, ур чадвар хариуцлага өсөхийн хэрээр эмч нар өвчтөнийг аль болох чирэгдэл багатайгаар эрт оношлох, эмчлэх туйлын эрмэлзлийг дагалдан нүд, чих, хамар хоолой, мэдрэл, арсын зэрэг зарим өвчнийг өрхийн эмч эмчлэх болж, эмчийн сэтгэлгээний цар хүрээ тэлнэ. Үүний учир зарим эрхтэнийг шинжлэх авсаархан багаж, зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, шээс, наалдацыг түргэн аргаар шинжлэх аргууд өрхийн эмч, сувилагч нарын үйл ажиллагаанд өргөн ашиглах болно. Томоохон поликлиникуудын дэргэд өрхийн эмчид туслах «Гэр бүлд зөвлөгөө өгөх удамшлын кабинет» бий болж эх нялхсын эрүүл мэндийг хамгаалахад их үүрэг гүйцэтгэх болно. Өрхийн эмчийн үйлчилгээг баттай нэвтрүүлж чадвал больнициос гадуур үзүүлэх эмнэлгийн тусlamжийн зохион байгуулал-

тад зарим шинэчлэл, өөрчлөлт хийх нь зайлшгүй. Үүнд: Түргэн тусlamжаас хойшлуулшгүй тусlamжийг салган нутаг дэвсгэрийн поликлиник, өрхийн эмчийн үйлчилгээнд шилжүүлнэ. Албан газрын эмнэлэг, үйлдвэрийн цехийн хэсгийн үйлчилгээг аажмаар нутаг дэвсгэрийн поликлиникийн үйлчилгээнд шилжүүлж үйлдвэрийн дэргэд зөвхөн ажлын цагаар яаралтай тусlamж үзүүлэх хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналт тавих их, бага эмчийн салбар (цэг) бий болгох; Сургууль, сургуулийн өмнөх насны хүүхдийн эмчийн орон тоог цомхтон, хүүхдийн байгууллагын хоол хүнс, эрүүл ахуй, ариун цэврийн хяналтыг эмнэлгийн дунд мэргэжилтэн нарт хариуцуулах; Эрүүлийг хамгаалахын төсөвт аж ахуйн тооцоонд шилжихэд санхүүгийн эх үүсвэрийг үйлчилгээний нутаг дэвсгэрийн нэг иртгэн, нэг өвчтөнөөр тооцож эмнэлгийн төсөвт өрхийн эмчийн оролцох эрхийг нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх; Ажил, сургуульд орох, гадаадад явах зэрэг хүний эрүүл мэндийн баталгааг өрхийн эмч бие даан шийдвэрлэх.

Ийм зохион байгуулалтын үр дүнд өрхийн бүх гишүүд шууд өрхийн эмчийн хараанд орж, ерөнхий мэргэжлээр ажиллах эмчийн тоо ёсч нэг эмчид 300—900 хүн ам (150—200 өрх) оногдох нөөц бололцоо тооны хувьд бараг одоо (1990) бүрэлдэж болохоор байна. Гэвч өрхийн эмчийг бэлтгэх нэг мөр болсон систем бүрэлдүүлэх явдал чухал юм. Энэ нь оюутны сургалтад өөрчлөлт оруулахаас гадна хэсэг, сумын эмч нарыг өрхийн эмчээр дахин бэлтгэх нь хамгийн бэрхшээлтэй асуудлын нэг мөн.

Манай орны хүн амзүй, аж төрөх ёс, газарзүйн онцлогийг харгалзан өрхийн эмч-бага эмч (эх баригч)-сувилагчийн баг бүрэлдүүлэх нь зүйтэй бөгөөд 1991—1995 онд 2550, дараагийн арван жилд дунджаар 3500 орчим өрхийн эмнэлгийн ийм баг байх хэрэгцээ байна.

Бид АУДЭС-ийн эмзүй, шүднээс бусад ангийг нэгтгэн ерөнхий мэргэжлийн эмчээр бэлтгэж 2—3 жил

өрхийн эмчээр сурган дадлагажуулсны дараа өрхийн ба мэргэжлийн эмч бэлтгэх асуудлыг дорвигийгоор хөндөн ярилцаж болох юм гэж үзэж байна.

Эрүүлийг хамгаалахын өөрчлөн байгуулалтын үед эмчийн ур чадвар ёс зүйн өсөлт эмнэлэг үйлчилгээнд хамгийн чухлаар тавигдаж байна. ЗХУ-д дээд сургуулийг дунд төгсөгчдөд бага эмчийн диплом олгох тухай санал дэвшүүлж байна. Манай оронд ур чадвартай сайн эмч бэлтгэх зорилгоор өөрчлөлт шинэчлэлтийг эхлэх зайлшгүй шаардлага бий боллоо. Зөвхөн олон ургальч санал бодлоос алдаагүй зөв шийдвэр гардаг сургаалд тулгуурлан сайн эмч домч бэлтгэдэг үндэсний уламжлалыг бүтээлчээр

ашиглаж, сонгон шалгаруулах замаар шат дараалан сувилагч, бага 1 эмч, лаборант, дунд мэргэжлийн эмзүйч, шудний техникч эцэст нь их эмч, дээд мэргэжлийн эмзүйч, шудний эмч бэлтгэдэг системд шилжиж болох юм.

Өрхийн эмчийн ажлын чанар, үр дүнг дээшлүүлэхэд онол, арга зүй, дадлагын өндөр түвшинд бэлтгэхийн хамт нийгэм ахуйн (үйлчилгээний нутаг дэвсгэрт орон сууцаар хангах, алба амины машинтай болгох, урамшилт цалин) ба мэргэжил дээшлүүлэх (2—3 жил дутам сэдэвчилсэн курс хийлгэх, дадлага хийлгэх, эмчийн, эрдмийн зэрэгтэй болгох) талаар багагүй ажил хийх нь тодорхой.

## ОНОЛЫН СУДАЛГААГ ОНЦЛОН ХӨГЖҮҮЛЬЕ

Л. Зориг (АУ хүрээлэн)

Улс нийгмийн хөгжлийн тодорхойлогч хүчин зүйл болдог шинжлэх ухаан, техникийн дэвшил нь улам бүр өргөсөж байгаа эдүгээ манай эрүүлийг хамгаалах салбарын цаашдын хөгжлийг түргэтгэхийн тулд анагаах ухааны олон салбарт онолын суурь судалгааг хэтийн бодлоготой, эрчимтэй хөгжүүлэх явдал чухал байна.

Дэлхийн шинжлэх ухааны хөгжлийг түүхийн үүднээс нь харахад анагаах ухаан нь бусад шинжлэх ухааны нэгэн адил эмчилгээний практикаас хоцорч, түүний туршлага алдаан дээр үндэслэн хөгжиж иржээ. Жишээ нь: Английн эмч Э. Женнер цагаан бурхны эсрэг вакциныг XVIII зуунд дархлалын (иммунитет) тухай ямар ч ойлголтгүй байхдаа нээсэн ажээ.

Харин орчин үед анагаах ухааны онол эмнэлгийн практикаас бүх талаар түрүүлэн хөгжиж байна. Энэ нь шинжлэх ухаан техникийн үсрэнгүй хөгжил анагаах ухаан хөгжих асар их бололцоог бий болгосонтой холбоотой юм.

Манай улсын анагаах ухааны хөгжил нь практикийн эмнэлгийн

хөгжлөөс хоцорч түүний цаашдын хөгжлийн шинжлэх ухааны үндэслэл болох талаар шаардлага тэр бүр хангахгүй байна уу гэж бодож байна. Мөн анагаах ухааны салбарт онолын суурь судалгаа хоцрогдонгүй, хавсарга судалгаа давамгайлах байдал олон жил үргэлжилсэнээс эдгээр судалгааны зохицтой харьцаа алдагдаж байна.

Анагаах ухаан, эмнэлгийн практикийн хөгжил нь физиологи, патофизиологи, генетик, биохими зэрэг салбарын онолын суурь судалгааны ололт амжилтаас гол нь шалтгаалдаг. Эдгээр болон анагаах ухааны хөгжлийг тодорхойлогч бусад чиглэлүүдэд бага анхаарал тавьж, хавсарга судалгаа голчилсноос судалгаа шинжилгээний ажлын үр дүн түр зуурын ач холбогдолтой байх, практикт нэвтрэх үр өгөөж муутай, эмнэлгийн байгууллагын хэрэгцээг зарим талаар хангахгүй байснаас анагаах ухааны хөгжилд хөгжлийн эволюци хэлбэр (тасралтгүй, аажмаар) зонхилж байжээ. Үүнээс болоод анагаах ухаан нь эмнэлгийн байгууллагаас хөгжлийн хурдцын хувьд хоцрох, дэлхийн анагаах ухаа-

\*

ны ололт амжилтыг цаг алдан хангалтгүй ажилдаа нэвтрүүлэх, тэр ч бүү хэл эмнэлгийн байгууллагаас материаллаг баазын хувьд ихээхэн хол хоцорч байна. Хамгийн ойрын жишээ гэхэд манай улсын томоохон эмнэлгүүдэд эхосонографи, тооцоолуурт томографи, барокамери бусад орчин үеийн эмчилгээ, оношлолын нарийн багаж төхөөрөмж нэвтэрсэн байхад, анагаах ухааны эрдэм шинжилгээний хүрэллэнгүүдийн дунд ч зориулалтаар төхөөрөмжилсөн судалгааны лаборатори, туршилтын бааз одоогоор байхгүй байна. Эрдэм шинжилгээний байгууллагын материаллаг баазын энэхүү хоцрогдонгуй байдал нь анагаах ухааны онолын суурь судалгааг орчин үеийн зохих түвшинд явуулахад муугаар нөлөөлөөд зогсохгүй улмаар эмнэлгийн байгууллагуудад шинжлэх ухааныг хөгжүүлэхэд саад болж байгаа юм.

Энэ нь цаашлаад шинжлэх ухаан ба эмнэлгийн практикийн байгууллагын ажил төрлийн уялдаа алдагдах, эрдэм шинжилгээний ажлын үр дүн практикт нэвтрэхэд хүндрэл учруулж байна. Үүнээс болоод эрдэм шинжилгээний болон эмнэлгийн байгууллагын хооронд зарим үед ажил төрлийн маргаан, үл ойлголцох явдал гарах шалтгаан болдог.

Шинжлэх ухаан үйлдвэрлэлийн холбоог бэхжүүлэх талаар олон жил ярьж зарим тодорхой арга хэмжээнүүд авч байна. Харин эдгээр арга хэмжээнүүдийн үр өгөөж зарим үед тааруухан байдаг нь сургалт, шинжлэх ухаан, практик гурвын холбоо зохистой оновчтой биш байгаатай холбоотой гэж хэлж болно.

Орчин үед шинжлэх ухааны олон салбарын нийлбэр цогц болж шинжлэх ухааны цөө шинэ салбар бий болох тодорхой асуудлыг шинжлэх ухааны олон салбар хамтран шийдвэрлэж, судалгааг эрдэмтдийн хамтарсан хүч, хамтлагаар шийдвэрлэх явдал өргөжиж байна.

Иймд эрүүлийг хамгаалахын өнөөгийн хөгжлийн түвшин, ирэх таван жил болон 2000 он хүртэлж хөгжлийг тодорхойлсон хэтийн тө-

лөвлөгөөтэй уялдуулан анагаах ухааны онолын суурь судалгааг хөгжүүлэх хөтөлбөр, чиглэл боловсруулах нь зүйтэй юм.

Үүний тулд өөрчлөлт шинэчлэлийн үеийн эрүүлийг хамгаалах, нийгэм хангамжийн цаашдын хөгжлийн явцад эрдэм шинжилгээний болон эмнэлгийн байгууллага хоёрын ажлын уялдаа холбоо ямар байх, яаж хөгжих, зохион байгуулалт, эдийн засаг эрхийн ямар механизмыг үйлчлэх вэ гэдгийг харгалзан үзье.

Анагаах ухаан бол шинжлэх ухааны бусад салбараас ялгараах өвөрмөц онцлогтой юм. Энэхүү онцлогийг хадгалсан, харилцаан нягт уялдаа бүхий холбоог эрдэм шинжилгээний байгууллага, эмнэлэг хоёрын хооронд тогтоох нь өөрчлөлт шинэчлэлтийн өнөө үед бүр ч чухал болж байна. Энэ нь байгууллага хоорондын хамтын ажиллагааны янз бүрийн хугацаатай гэрээ, аж ахуйн дотоод тоосдоонд түшиглэн харилцаан ашигтай ажиллах, мэдээллийг өөр хоорондоо солилцох, түүгээр ч үл барам эмнэлгийн аль нэг тасаг, кабинетийг эрдэм шинжилгээний байгууллага түрээслэн авч үр дүнтэй ажиллах гэх мэтийн хэлбэртэй байж бүлэг юм. Мөн төрөөс эдийн засгийг удирдах зах зээл төлөвлөлтийн арга нэвтрүүлэхийн чухлыг зааж буй өнөөгийн нөхцөлд анагаах ухааны эрдэм шинжилгээний байгууллагууд үйлдвэр, аж ахуйн газар, шинжлэх ухааны бусад хүрээлэн, тэрчлэн гадаадын шинжлэх ухааны байгууллагатай аж ахуйн тооцооны үндсэн дээр үр ашигтай хамтран ажиллах явдлыг улам бүр өргөжүүлэх хэрэгтэй байна. Энэ бүхний эцсийн зорилт нь хүн амын эрүүл мэндийг хамгаалан бэхжүүлэх, анагаах ухааны хөгжлийг хурдасгах юм.

Сүүлийн хориод жилд анагаах ухааны судалгаа шинжилгээнд кибернетик, цахим тооцуур өргөн нэвтэрч, биохими, молекулын биологи, иммунологийн ухаанд шинжлэх ухааны хувьсгал болсон томоохон нээлтүүд хийгдэж эрчимтэй хөгжиж

байна. Иймд манай орны анагаах ухааны хувьд ЗХУ, бусад орчныудын төдийгүй дэлхийн анагаах ухааны хөгжлийн чиг хандлагыг баримтлал болгох нь зөв болов уу гэж бодож байна.

Манай улсын шинжлэх ухааны чадамж нь эдийн засгийн нийт чадамжийн нэг орчим хувь байдаг ажээ. Тэгвэл анагаах ухааны чадамж нь эдийн засгийн нийт чадамжийн хэдэн хувийг эзэлж байгаа, үүнийг цаашид дээшлүүлэхийн тулд ямар арга хэмжээ авах, түүний хэрээр улсын нийт төсвөөс ногдох хувийг ихэсгэн үр дүнтэй ашиглах талаар бодох хэрэгтэй байна. Манай орны шинжлэх ухааны салбарт ажиллаж буй эрдэм шинжилгээний ажилтанд нэг жилд ногдох судалгаа шинжилгээний зардал цалинтай нь нийлээд дунджаар 17000 төгрөг байдаг бол ЗХУ-д 17800 орчим рубль, Японд 150000 америк доллар байдаг ажээ. Энэ нь эрдэм шинжилгээний байгууллагад ажиллагдын дундаж цалин бусад ажилтан нарынхтай адил байгаа өнөөгийн нөхцөлд цэвэр судалгаа шинжилгээнд зарцуулах зардал нэлээд бага байна гэсэн үг юм.

Анагаах ухааны бүх салбарт онолын суурь судалгааг явуулахад эрдэм шинжилгээний байгууллагыг санхүүжүүлдэг үлдэгдлийн одоогийн зарим нь хүчтэй тулхэц өгч чадахгүй байгаагаас түүнийг өөрчлөх шаардлага зүй ёсоор гарч ирж байна.

МАХНын Төв Хорооны V бүгд хурал «Шинжлэх ухааны бүх салбарт суурь судалгааны ач холбогдлыг дутуу үнэлдгээс онолын тал нь хоцорч, тэр нь улмаар хавсарга судалгааны хөгжлийг saatuuлах ноцтой муу нөлөө үзүүлж байгаад дүгнэлт хийх цаг болсон байна» гэж тэмдэглэжээ. Тэгвэл өнөөдөр манай анагаах ухааны салбарт онолын суурь судалгааны эзлэх хувийн жин ямар хэмжээнд байна, цаашины хөгжлийн төлөв нь ямархуу байна гэсэн асуулт урган гарч ирж байгаа юм. Гадаадын эрдэмтдийн үзэж байгаагаар анагаах ухаанд суурь судалгааны эзлэх

хувь 40—45% байх нь хамгийн тохиromжтой байдаг.

Онолын суурь судалгааны үр дүнг практикт нэвтрүүлэх үе шат нь нэлээд төвөгтэй, цаг хугацаа, хөрөнгө мөнгө шаардах ч тал бий. Иймээс практикт даруй нэвтрүүлэхгүй бол ямар ч том чухал нээлт бүр ашиггүй байх явдал ч байдаг ажээ.

Иймд эрдэм шинжилгээний байгууллагын судалгааны үр дүнг практикт нэвтрүүлэх нь хоёр талаасаа харилцан санаа тавьж, хамтран ажиллаж байж биелэх асуудал юм. Харин эрдэм шинжилгээний байгууллага дангаараа хариуцах үүрэг мэт ойлгох нь хэт өрөөсгөл юм. Мөн шинжлэх ухаан техникийн үсрэнгүй хөгжлийн өнөөгийн байдал нь үйлдвэрлэлд ажиллаж буй мэргэжилтэн, ялангуяа удирдах хүмүүст чанарын шинэ шаардлага тавих болсныг мартаж болохгүй.

Тийм учир томоохон эмнэлгүүдэд шинжлэх ухаан техникийн баазыг түлхүү хөгжүүлэх, эмч мэргэжилтнүүдийг шинжилгээ судалгааны ажилд оролцуулах явдлыг өргөжүүлэх хэрэгтэй байна. Энэ бүхэн нь анагаах ухааны судалгааны үр дүнг эмнэлгийн практикт бүрэн нэвтрүүлэх явдалд тулхэц өгнө.

Сүүлийн үед сургалт, шинжлэх ухаан, үйлдвэрлэл гурвын уялдаа холбоог сайжруулах явдал хамгийн гол нь юм гэж бичиж байна. Үүнийг манай эрүүлийг хамгаалах системийн хувьд өнөөгийн шаардлагыг тэр бүр хангахгүй байгаа явдал гэрчилж байна. Энэ нь дээд сургуулиудад хийж буй эрдэм шинжилгээний ажлын ихэнх хэсэг нь судалгаа шинжилгээний байтугай сургалтын баазыг зохих түвшинд өөд татааж чадаагүй нөхцөлд хийгддэгээс шалтгаалан практикт нэвтрэх үр өгөөж муу байх, хавсарга судалгааны хэлбэр голчлох, зөвхөн хувь хүний хэрэгцээ хантах төдий байхтай холбоотой. Иймд эрдэм шинжилгээний ажилтан боловсон хучнээр харьцангуй сайн хангагдсан өнөөгийн нөхцөлд сургалтын салбарт өөрчлөлт шинэчлэлийг эмч, эмнэлгийн дунд мэргэжилтэн бэлтгэдэг сургалтын программын зарим

хэсгийг эргэж харах, эрдэмшилгээний ажилтан нарыг их сургуулийн хүрээнд эрдэмтэн багш эрдэмшилгээний ажилтан нарын оролцоотойгоор авьяас сонирхолтой залуучуудаас бэлтгэж эхлэх байдлаар хийж эхлэх нь зүйтэй. Монголын уламжлалт сургах аргын нэг багшшавийн барилдлагат тогтоох юмуу ганцаарчилсан сургалтыг ч туршиж үзэх нь ашигтай юм.

Тэдгээр оюутнуудыг эрдэмшилгээний ажилд эхнээс нь танилцуулан дадлагажуулах, онолын сэтгэн бодох чадварыг их хөгжүүлэх, улмаар ахлах ангиас нь факультетийн эрдэмшилгээний салбарт мэргэжлийн ажилчин, техникч, лаборантын орон тоонд тодорхой хугацаагаар ажиллуулж болно.

Ихэнх оронд шинжлэх ухааны эрчимтэй хөгжиж буй тэргүүлэх чиглэлээр боловсон хүчин бэлтгэх ажлыг их дээд сургуульд шинэ салбар нээх замаар шийдвэрлэж, түүнийгээ шаардлагатай боловсон хүчин, техник төхөөрөмжөөр сайтар хангадаг байна. Мөн нэгэнт бэлтгэсэн боловсон хүчиний давтан сургалтыг ч тэнд явуулдаг ажээ.

Бүтээлч сэтгэлгээ буюу шинэ санаа дэвшиүүлэх чадвар 30 хүртэлх насанд илүү сайн байдгийг нэгэнт тогтоосон тул энэ үед сургалт, судалгаа шинжилгээний ажлыг хослон явуулах нь хамгийн үр дүнтэй юм. Иймд залуу ажилтнуудын ийм чанарыг эрдэмтдийн өргөн мэдлэг, арвин туршлагатай хослуулж хөгжүүлвээс их үр дүнд хүрэх болно.

Сургалтын салбарт хийх өөрчлөл шинэчлэлт хийх шаардлага боловсон хүчинийг бэлтгэхэд тооны талыг хэт баримталснаас анагаах ухааны шинээр хөгжиж буй салбруудад нарийн мэргэжлийн боловсон хүчин дутах, сургалтын чанар нь улс орны нийгэм-эдийн застгийн хөгжлийн хурдцын шаардлагыг зарим талаар хангахгүй байх, бэлтгэж гаргасан боловсон хүчин нь шинжлэх ухааны болон эмнэлгийн практикт дасан ажиллах хугацаа нь уртсах зэрэг олон шалтгаанаас үүдэн гарч байна.

Сургалтад хийх өөрчлөн байгуулалт нь дараах таван үе шатыг дамжин хөгжих зүй тогтолтой ажээ.

Нэгдүгээр шатаанд сургалтын системд өөрчлөлт хийх шаардлага танин мэдэгдэж, шинжлэх ухааны ундэслэл зарчим боловсруулагддаг. Энэ бүгд нь туршилтаар батлагдаж, тодруулагдаж тогтсоноор хоёрдуугаар шат дуусдаг байна. Дараа нь боловсролын системд хэрэгжиж нэвтрэх үйл явц үргэлжийн тогтвортой давамгайлан зонхилох хандлагатай болсноор дөрөвдүгээр үе шат дуусдаг. Шинжлэх ухаан техникийн хөгжлийг дагалдан сургалтын энэ систем нь мөн л шаардлага хангахаа больж дахин шинэчлэл хийх санаа гарч ирцэг.

Ийнхүү мөчлөг байдлаар явах нь аливаа хөгжлийн диалектктай колбоотой гэж үздэг. Энэ байдал нь манай оронд ч ажиглагдаж байгаа юм.

Сургалтын салбарт хийх өөрчлөлт шинэчлэлтийн өөр нэг чухал тал нь дээд сургуулийн хүрээнд хийх судалгаа шинжилгээний ажлын материаллаг баазыг бэхжүүлэх, хавсарга судалгааны үр ашгийг дээшлүүлэх, онолын суурь судалгааг давуутай хөгжүүлэх явдал юм.

Одоо манай хүрээлэнд эхлэж нь тавигдан хөгжиж буй хүний генетик судлал, иммунологи, клиникийн биохими зэрэг нь дээд сургуулийн холбогдох тэнхим лабораторийг түшиглэн хөгжих нь ашигтай байна.

Дараагийн нэг анхаарал татсан зүйл бол эрүүлийг хамгаалах системийн эрдэмшилгээний байгууллагуудын материаллаг баазын шаардлага хангахгүй байгаагаас судалгаа шинжилгээний ажлын үр дүнд сөрөг нөлөө үзүүлж байгаа явдал юм. Иймд анагаах ухааны судалгаа шинжилгээний ажлын эцсийн үр дүн нь шийтэгээний эрүүлийг хамгаалах байгууллагын хөгжлийн нэг шийдвэрлэх хүчин зүйл болох үүднээс түүний материаллаг баазыг яаралтай бэхжүүлэн сайжруулмаар байна. Юуны өмнө анагаах ухааны эрдэмшилгээний төв лабораторийг байгуулах явдлыг яаравчлах нь зүйтэй юм.

Эрдэм шинжилгээний байгууллагууд төсөвт аж ахуйн тооцоонд шилжиж буйтай холбогдуулан тэдний бие даасан байдлыг улам өргөжүүлэх цаашид тэднийг аж ахуйн дотоод тооцоо, өөрийгөө санхүүжүүлэх зарчимд аажмаар шилжих бэлтгэлийг хангахын тулд харьяа яамны аппаратын үргэлжлэл байдлаар ажилладгийг багасгаж, харин яамны захиалгаар аж ахуйн тооцооны үндэстэй ажилладаг болгож, хүрээлэнгийн зарим боломжтой сектор, лабораторийг аж ахуйн тооцоонд шилжүүлэх нь зүйтэй.

Мөн үйлдвэр аж ахуйн газруудтай харилцан ашигтай хамтын ажиллагааны гэрээ байгуулахдаа судалгаа шинжилгээний ажлын заралыг (санхүүжилтийг) гэрээт аж ахуйн газарт нь хариуцдаг журмыг өргөнөөр турших хэрэгтэй байна.

Өөрчлөлт шинэчлэлтийн өнөө уед эдийн засгийн сэтгэлгээ, боловсрол чухлаар тавигдаж буй нь эрүүлийг хамгаалах салбарын хувьд онцлог учир холбогдолтой юм. Эрүүлийг хамгаалахын эдийн засгийн ухаан бие даан хөгжих эхлэл тавигдаж буй нь үнэхээр цат үеэ олж байгаа ба энэ нь анагаах ухааны хөгжлийн хандлагыг эдийн засгийн талаас нь чиглүүлэх болов уу гэж бодож байна.

Энэ бүхэнд анагаах ухааны оруулах хувь нэмрийг дээшлүүлэхийн тулд шинжлэх ухааны боловсон хучний бодлогыг оновчтой явуулах, залгамж халааг тасралтгүй байлгах, шинжлэх ухааны тодорхой салбар чиглэлд тэргүүлэх эрдэмтдийг хэтийн бодлоготой бэлтгэх, нарийн мэргэжлийг эрдэмтдийг шинжлэх ухаан өндөр хөгжсөн оронд тодорхой хугацаагаар томилон ажиллуулах, тэдгээр орнуудтай хамтран ажиллах ёвдлыг өргөжүүлэх хэрэгтэй байна.

Мөн АУДЭС-ийн сургалтын хөтөлбөрийг дахин хэлэлцэж нийгмийн ухааны хичээлийн цагийг багасгах, физикийн олон төрлийн хичээлийн оронд англи хэл, эдийн засгийн онолын үндэс, хүний экологи, адаптацийн төрлийн хичээлийг зааж эх-

лэх нь зүйтэй байна. Ер нь эрүүлийг хамгаалахын төлөвлөлт, хэтийн төлөвлөгөөнүүд нь нөхцөл байдлаас шалтгаалан өөрчлөгднө сэлбэгдэх чадвартай, уян хатан байх нь их шаардлагатай болж байна. Энэ нь эмнэлгийн практикт нарийн багаж төхөөрөмж олноор нэвтрэрч, эмнэлгийн үйлчилгээний өртөг асар хурдацтай өсөх болсонтой нэг талаар холбоотой юм.

Иймд анагаах ухааны ололтыг эмнэлгийн практикт нэвтрэх хугацааг богиносгох нь эмнэлгийн үйлчилгээний үр дүнг дээшлүүлэх нэг чухал нөөц гэдгийг мартах ёсгүй.

Шинжлэх ухаан техникийн дэвшил эрчимжиж буй өнөө уед хүний гараар байгаль орчин ихэд бохирдсоноос буцаад хүний эрүүл мэндэд хортойгоор нөлөөлөх боллоо. Мөн хотжилт болон техникжилт ихсэхтэй холбогдон хүмүүс унаган байгалиасаа холдох болсон нь тэдний эрүүл мэндэд нөлөөлж, хорт хавдар, зүрх судас, мэдрэл сэтгэхүйн зэрэг энэ зууны гэгдсэн өвчинүүд элбэгтийн төлөвтэй боллоо.

Энэ уялдаа холбоог хүний орчиндоо дасан зохицох чадвар, өвчинөөс анхдагч урьдчилан сэргийлэх боломжтой нь холбон судалдаг хүний экологийн ухаан дэлхийн хэмжээнд эрчимтэй хөгжиж байна. ЮНЕСКО-гийн хүрээнд олон улсын «Хүн ба шим мандал» хөтөлбөр боловсруулан судалгаа шинжилгээний асар өргөн хүрээтэй ажилхийж байна. Нэлээд оронд энэ асуудлыг засгийн газрын бодлогын хэмжээнд дэмжиж байна.

Манай орны шинжлэх ухаан техникийн хөгжлийн хэрээр Монгол хүний экологи, дасан зохицох чадвар, өвчинөөс анхдагч урьдчилан сэргийлэх боломжийн тухай асуудал маш хурцаар дэвшигдэн гарч ирж байна.

Монгол хүний антропометрийн дундаж хэмжээ, цусны биохимиин болон микрэлементийн хэвийн үзүүлэлт гэх мэт монгол хүний бие организмын онцлогийг нарийн тогтоогоогүй байна.

Энэ нь эмч бид Европчуудын би-  
еийн байдалд тохирсон эмийн тун-  
гаар монгол хүн ялангуяа хүүхдийг  
эмчилж байсан хэрэг бөгөөд энэ  
талаар судлан тогтоох нь зайлш-  
гүйг харуулж байна. Гадаадын тех-  
нологиор хийсэн тутал монгол хү-  
ний хөлд тохиромж муутай байдаг  
нь бас нэг баталгаа юм. Энэ мэт  
олон жишээ дурдаж болно.

Хүний биеийн бүтэц, эрхтэнүү-  
дийн үйл ажиллагаа, орчиндоо да-  
сан зохицох чадвар нь тухайн хү-  
ний үндэсний болон удамшилын (ге-  
нийн) онцлог, амьдран суугаа нут-  
аг орны байгаль цаг уурын нөх-  
цөл байдал, амьдралын хэв маяг,  
ёс заншил, хоол тэжээл зэрэг олон  
зүйлээс маш их хамааралтай бай-  
даг билээ. Энэ бүгд нь тухайн үн-  
дэстэн, хэсэг бүлэг хүмүүс (попу-  
ляци), бие болон хувь хүний орчин-  
доо дасан зохицох чадварт нөлөөлж  
улмаар өвчлөл, нас баралтанд ч  
ихээхэн нөлөө үзүүлдэг нь тогтоогд-  
сон юм.

Хотжилт ихсэж, хүмүүс өөр га-  
зар оронд шилжин суурьших нь өр-  
гөжиж буй өнөө үед монгол хүний  
экологи, адаптаци, өвчнөөс анхдагч  
урьдчилан сэргийлэлтийн талаар  
онолын суурь судалгааг явуулах нь  
эрүүлийг хамгаалахын хөгжлийн  
нэг чухал нөхцөлийг бий болгоно.

Анагаах ухааны хүрээлэнд эмнэ-  
лэг-биологийн сектор байгуулан  
хоёр дахь жилдээ эмнэлэг-биоло-

гийн судалгаа явуулж байна. Цаа-  
шид энэ судалгааны хүрээг улам  
өргөжүүлэн монгол хүн судлалыг  
эрчимтэй хөгжүүлэхийн тулд мате-  
риаллаг баазыг нь бэхжүүлэх,  
шинжлэх ухааны бусад салбартай  
үйл ажиллагаагаа уялдуулан зохи-  
цуулах замаар монгол хүн судла-  
лын үндэсний хөтөлбөрийн хамтлаг  
байгуулах нь зүйтэй юм.

Монголын уламжлалт анагаах  
ухааныг цаашид улам хөгжүүлэх-  
дээ энэхүү бүхэл бүтэн шинжлэх  
ухааны онолын суурь судалгааг  
иж бүрэн явуулах хэрэгтэй байна.  
Үүний тулд АУХ, ардын эмнэлгийн  
хүрээлэнгүүдийн судалгаа шинжил-  
гээний ажлын уялдаа холбоог  
сайжруулах, хүрээлэн дундын эрдэм  
шинжилгээний лаборатори, туршилт  
үйлдвэрлэлийн бааз бий болгох та-  
лаар бодох нь зүйтэй.

Эцэст нь Монгол улсын анагаах  
ухааны хөгжлийн түүхийг судлах,  
ашигтай өв уламжлалыг орчин  
үеийн судалгаагаар батлах явдал  
чухал байна.

Энэ мэтээр анагаах ухааны сал-  
бар материаллаг бааз, боловсон  
хүчний ашиглалтыг улам сайжруул-  
лан бэхжүүлж, онолын суурь су-  
далгааг түлхүү хөгжүүлэх чиглэл  
баримтлах аваас эрүүлийг хамгаа-  
лахын өөрчлөлт шинэчлэлд оруу-  
лах хувь нэмэр нь улам арвижих  
билээ.

64

## 1989, 1990 ОНД ЭРДМИЙН ЗЭРЭГ ХАМГААЛСАН ЭМЧ, МЭРГЭЖИЛТНҮҮД

(Үргэлжлэл. Түрүүч нь манай сэтгүүлийн 1990 оны № 1 (116)-д бий

Хоёр. Дэд эрдэмтний зэрэг хам-  
гаалсан нь:

7. Жамсрангийн Мэндсайхан, ас-  
пирант

Сэдэв-Эпидемийн болон эпиде-  
мийн бус үед ялгасан томуугийн  
вирусийн биологийн шинж чанар.

Хэзээ, хаана хамгаалсан — 1989  
оны 4 дүгээр сарын 11, Ленинград.

Ж. Мэндсайхан энэхүү бүтээл-  
дээ эпидемийн болон эпидемийн  
бус үед ялгасан эсрэгтөрөгчийн 4  
хувилбарт хамаарах томуугийн ви-  
русийн 34 омгийн биологийн төр-  
хийг харьцуулан судалж, томуу-  
гийн вирусийн эпидемийн чадавхийг  
үнэлэх шинэчилсэн хэмжүүр бо-  
ловсруулжээ.

62

**8. Даржаагийн Галбадрах, Эрүүл ахуй, халдварт нян судлалын улсын институтийн секторын эрхлэгч**

**Сэдэв: — БНМАУ-ын хүрээлэн байгаа орчны объектуудын вирус судлалын шинжилгээ**

**Хэзээ, хаана хамгаалсан — 1989 оны 4 дүгээр сарын 28, Москва**

Д. Галбадрах энэхүү бүтээлдээ БНМАУ-ын нутаг дэвсгэрт анх удаа хүрээлэн буй орчин, тухайлбал үндны болон ил задгай, бохир ус, газрын хөрөний гэдэсний өвчин үүсгэгч вирусээр бохирдсон зэрэглэлийг судалж, улирлын хөдлөл зүйтэй болохыг тогтоожээ. Цаг агаар болон нийгмийн хүчин зүйлс бохирдолд нөлөөлж байгааг илрүүлсэн байна.

**9. Баатарын Баярт, аспирант**

**Сэдэв: — Ин-вибо тогтолцоонд макрофагийн үйл ажиллагааг зонхицуулагч лимфокины биологийн идэвхийг судалсан нь**

**Хэзээ, хаана хамгаалсан — 1989 оны 11 дүгээр сарын 29, Москва,**

Б. Баярт энэхүү бүтээлдээ ин виво тогтолцоон дахь лимфокины М ба Л булэглэлүүдийн идэвхийг үнэлэх сорил боловсруулжээ.

Лимфокины М ба Л булэглэлд хамаарах полипептид нь шарх эдгэрэх хугацааг хоёр дахин бодижносгож, фагоцитозыг идэвхжүүлж байгааг тогтоосон байна.

**1990 оны эрдмийн зэрэг хамгаалсан эмч, мэргэжилтнүүд**

**Нэг. Докторын зэрэг хамгаалсан нь:**

**1. Эрээдэрийн Лувсандагва — Эх. хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах эрдэм шинжилгээний улсын нэгдсэн төвийн нэгдүгээр орлогч захирал.**

**Сэдэв: — Эпидемиологийн болон эмнэл зүйн шинжилгээгээр БНМАУ-ын хүүхдийн ерөнхий өвчлөлийн бүтцийн дотроос бөөрний өвчинүүдийг судалсан нь**

**Хэзээ, хаана хамгаалсан — 1990 оны 5 дугаар сарын 30, Москва**

Э. Лувсандагва энэхүү бүтээлдээ БНМАУ-д тохиолдож буй бөөрний эмгэгийн онцлог нь цусархаг

шаскулиттай холбоотой бөөрний үрэвсэл (нефрит) болохыг илрүүлж хамгийн их өвчлөл уулархаг нутагт (Улиастай хотод) 1000 хүүхдэд 70, хамгийн бага өвчлөл тал нутагт (Чойбалсан хотод) 1000 хүүхдэд 15 байгааг тогтоосон байна.

Бөөрний эмгэгт хургэж байгаа гол шалтгааныг эрс тэс уур амьсгал амьсгалын эрхтэний өвчлөл, хүүхдэд буй халдварт архаг голомт, хүүхдийн ойр төрлийнхэнд байгаа бөөрний өвчин, ойр ойрхон төрөх, жирэмсийн нефропати гэж үзсэн байна.

Нас барсан хүүхдийн дотор бөөр, шээсний замын эмгэгт 57,6 хувь байгаа нь Москва хотынхаос (45 хувь) их байгаа ажээ.

Бөөрний өвчнийг Эмчлэхэд зүү эмчилгээ өндөр үр дүнтэй байгааг тогтоожээ. Д витамин дутагдлын сульдаа болон бөөрний тубулопатийг яланг оношлох шалгуур боловсруулжээ.

**2. Аюулгүйн Өлзийхутаг — Ана-гаах ухааны хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан**

**Сэдэв — БНМАУ-ын бэсрэг болон нам уулын бүсэд оршин суугч уугуул хүн амын цусны эргэлт, амьсгал цусны эмнэлзүй-физиологийн онцлог.**

**Хэзээ, хаана хамгаалсан — 1990 оны 9 дүгээр сарын 20, Минск**

А. Өлзийхутаг энэхүү бүтээлдээ оршин суух газрын өндөр нэмэгдэх тутам уушгины эзлэхүүн, цусны хүчилтөрөгчийн эзлэхүүн нэмэгдэж arterийн цусан дахь хүчилтөрөгчийн шингэлт, оксигемоглобини агуулга багасч, судасны цохилт цөөрч байгааг тогтоосон байна.

Газрын өндөр болон жилийн хугацаанд хүйтрэлттэй хоногийн тоо нэмэгдэхэд систолын ба диастолын arterийн даралтын давтамж өсч байгааг илрүүлсэн байна.

Говь-Алтай болон Хангайн бэсрэг уулсын бүсэд суугаа уугуул хүн амын дунд тохиолдож буй зүрхний булчингийн бодисын солилцоо дистрофийн өөрчлөлт, зүрхний дамжуулах чанарын хямрал, Дор-

нодын нам уулын бүсэд оршиг сууж байгаа хүмүүсийнхээс 3,6—5,5 дахин илүү тохиолдож байна гэж дүгнэжээ.

Цусны эргэлтийн тогтолцооны байдлаар Эрүүл мэндийн байдлыг үнэлэхэд бэсрэг уулын бүсэд оршин суугчид, нам уулын бүсэд оршин суугчдаас эрүүл мэндийн үзүүлэлтээр доогуур байгаа нь нотлогдсон байна.

Хоёр. Дэд эрдэмтний зэрэг хамгаалсан нь:

1. Очирхүүгийн Бадамцэрэн — Улаанбаатар хотын клиникин төв эмнэлгийн эмч

Сэдэв: — Монгол орны уулын нөхцөлд артерийн битүүрээгүй цорго хэмээх зүрхний төрөлхийн гажгийн эмнэл зүй, оношийн онцлог

Хэзээ, хаана хамгаалсан — 1990 оны 3 дугаар сарын 20, Улаанбаатар

О. Бадамцэрэн энэхүү бүтээлдээ артерийн битүүрээгүй цорго хэмээх төрөлхийн тажгийн цусны хөдлөл зүйн өөрчлөлт болон өвчтөнд илэрч байгаа шинж тэмдгийг гадаад орны судлаачид, цусны эргэлтийн өөрчлөлтгүй хүмүүсийнхтэй тус тус харьцуулан дун шинжилгээ хийх, тажгийн үед илрэх объектив, субъектив шинжүүдийн оношийн ач холбогдлыг тогтоосон. Артерийн битүүрээгүй цорготой хүмүүст илрэх гадаад амьсгалын өөрчлөлт, цусны хөдлөл зүйн байдлыг хүмүүсийн оршин сууж байгаа газар нутгийн байдлаар (газар зүйн бүсээр), өвчний бүлгээр судалж, уул тажгийн бүлэг бүрт тохирсон мэс заслын хувилбарыг тогтоосон байна.

2. Дэчингийн Дорж — Анааах ухааны дээд сургуулийн багш

Сэдэв: — БНМАУ дахь флюroz өвчний газар зүй

Хэзээ, хаана хамгаалсан, 1990 оны 4 дүгээр сарын 5, Улаанбаатар

Д. Дорж энэхүү бүтээлдээ эмнэлэг газар зүйн судалгааны аргачлал боловсруулан, нутаг дэвсгэрийн үнэлгээ өгч, загвар зураглал зохиожээ.

Нутагшмал эмгэгт зонхилох өвчний нэг болох флюрозыг сонгон авч түүнийг тухайн нутаг орны онцлог, усны фторын хэмжээтэй холбон олон талаас нь нарийвчлан авч узжээ.

3. Гомбодоржийн Цэцэгдарь — аспирант

Сэдэв: — Дунд чихний архаг булагтай өвчтөнд сонсголын гуурсны үйл ажиллагааны алдагдлыг оношлож, эмчлэх нь

Хэзээ, хаана хамгаалсан — 1990 оны 5 дугаар сарын 31, Улаанбаатар

Г. Цэцэгдарь нь энэхүү бүтээлдээ дунд чихний архаг булгийн үед сонсголын гуурсны үйл ажиллагааны байдлыг оношлох, эмчлэх бүрдмэл аргыг өөрийн орны нөхцөлд анх удаа боловсруулж, үр дүнт судалсан байна.

Судалгааны явцад боловсруулсан бүрдмэл арга нь дунд чихний булгийн үед сонсголын гуурсны үйл ажиллагааны бүхий л үзүүлэлтийг тодорхойлон оношлох, эмчилгээ (эмийн болон сонсгол сайжруулах мэс засал)-ний арга барил сонгон авах, үр дүнг нь тооцож, дээшлүүлэхэд ач холбогдолтой болжээ.

**ГЭМТЭЛ СОГОНИЙ ЖИЛИНИЙ ЭМНЭЛ-  
ГИЙН 30 ЖИЛИНИЙ ОЙД**


Эрүүлийг хамгаалах байгууллагад олон жил үр бүтээлтэй ажилласж хүн ардын эрүүл мэндийг хамгаалах үйлсэд тодорхой амжилт гаргаж БНМАУ-ын өрөнхийлөгчийн зарлигаар шагнагдсан тэргүүний сайчууд:



—Гэмтлийн их эмч Ж. Олзой, энэ байгууллагдаа 24 жил тасралтгүй ажилласан ахмадуудын нэг билээ:



—Рентген тасгийнхан (зүүн гарас)  
лаборант Д. Мөнхсайхан, их эмч Б.  
Гантемэр, лаборант Ц. Чулуунбат нар





— Гавал тархины гэмтлийг мэс заслаар эмчилж буй

—Хэвлэлийн зэрхтний гэмтэлийг  
эмчилж буй  
Гэрэл зүргийг Ж. Даваасамбуу

Улсын клиничийн төв эмчээргийн баатар шээсний зөвхөн эрхтэйг дурдаж хабибистын-хэрэглэж байгаа үргэлжлийн газар багжадар шэсний сувийн нарийсантыг дотроос нь эусч томс-годог.

Энэ багажийг герман улсадас 1988 онд авч эмчилгээнд хэрэглэж байна.



Т: Лхагваасурэнгийн авсан гэрэл зураг

Герман улсыд үйлдвэрлэсэн DMG 410 гээг төхөөрөмж шудамийн мачижийн эрдэмийг дасан юм:

—Монгол, шадамн түүгээс, металургийн холбогддог эхийн дээрээдэдэгээрээ шудамийн холбогддог эхийн төхөөрөмжийн хэрэгжилэгээрээ «Металл ломбо» гэгчийг бэлтгэдэг байна:

—Металл помбо нь читарын ондор узувчилсан: —Шудамийн эмчийн эмчилгээнд байдран багасан. Помбо нь боломжийн нийтийн 7 кг.

—Материалыг чөг хэдийнээгээ —220 вольт замандаа —DMG 410 гээг эссааржин эх төхөөрөмжийн ширгийн төгрөгийн өргөн нэдэгжүүлж байна;

Чинийн эмчилгээнд эхийн замандаа ширгийн төгрөгийн өргөн нэдэгжүүлж байна;